

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 06 дугаар сарын 02-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-16

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 17-74

<i>1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг нарын 9 гишүүн 2025.07.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	18-27
<i>2.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 7 гишүүн 2026.05.14--ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	27-34
<i>3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин нарын 6 гишүүн 2026.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	34-39
<i>4.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	39-73
<i>5.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/</i>	73-74

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны
06 дугаар сарын 02-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 28 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 67.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 34 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Г.Дамдинням, Ц.Сандаг-Очир,
Да.Цогтбаатар;
Чөлөөтэй: Д.Ганбат, Б.Дэлгэрсайхан, Б.Пүрэвдорж;
Тасалсан: Д.Пүрэвдаваа.

Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг хэлэлцэх асуудлын дарааллын 4 дүгээрт орсон Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэх асуудлын дарааллын 1 дүгээрт оруулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 10
Бүгд: 19
47.4 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар хэлэлцэх асуудлын дарааллын 6 дугаарт орсон Бусад асуудлыг хэлэлцэх асуудлаас хасах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг нарын 9 гишүүн 2025.07.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Зам, тээврийн яамны Авто тээврийн бодлого, зохицуулалтын газрын ахлах шинжээч Т.Эрхэмбаатар, мөн газрын мэргэжилтэн А.Энхболд, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, С.Эрдэнэболд, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад Зам, тээврийн яамны Авто тээврийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн А.Энхболд, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу санал хураалт явуулав.

Д.Цогтбаатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 13¹ дүгээр зүйлийн 13¹.2.9 дэх заалтын “зүй зохистой ашиглах, хэрэглээний соёлыг эзэмшүүлэх” гэснийг, 13¹.2.5 дахь заалтын “оршуулгын газар” гэснийг болон 13¹.2.3, 13¹.2.4, 13¹.2.6 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 59, 60, 61, 64 дэх хэсэг болон 63.2, 63.3, 63.4 дэх заалтыг хасаж, 63.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж дугаарыг 62 болгон өөрчлөх:

“62.Нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээд нь эрх бүхий этгээдээс тогтоосон зогсоолын байршлаас бусад нийтийн эзэмшлийн зам, гудамж, талбай, нийтийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт хүрээлэн, авто зогсоол, ногоон байгууламж, нийтийн зориулалттай орон сууцын байшингийн орчны газрын ногоон зүлэг, хүүхдийн тоглоомын талбай, эдгээртэй адилтгах газарт тээврийн хэрэгслээ байршуулсан бол тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 7 гишүүн 2026.05.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг хариулж, тайлбар хийв.

Д.Цогтбаатар: 1.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 13
Бүгд: 20
35.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20
55.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

1.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9. Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 10
Бүгд: 20
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20
55.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

9.Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Тулга Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин нарын 6 гишүүн 2026.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан өмгөөлөгч Б.Батбаяр, хуульч Б.Эрхбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад өмгөөлөгч Б.Батбаяр, хуульч Б.Эрхбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, С.Амарсайхан, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 7
Бүгд: 21
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Д.Мөнх-Эрдэнэ, Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Д.Энхтөр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батбямба, Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, мөн яамны Нийтийн эрх зүйн хэлтсийн дарга Д.Энхтөр, шинжээч Ж.Амгалан, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын ахлах шинжээч Ш.Энхтуяа, Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх албаны дарга Э.Товуудорж, мөн албаны Тасгийн дарга Б.Эрхэсбаатар, Гаалийн ерөнхий газрын Хар тамхи, мөнгөн угаахтай тэмцэх хэлтсийн дарга Г.Ганзориг, Хил хамгаалах ерөнхий газрын Шалган нэвтрүүлэх хэлтсийн дарга Э.Мөнхцог, Шүүх шинжилгээний ерөнхий газрын Байгалийн ухааны шинжилгээний хэлтсийн дарга Б.Ламчин, Мал эмнэлгийн ерөнхий газрын ахлах мэргэжилтэн Ч.Лувсанжанцан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний дэргэдэх Сэтгэц, нийгмийн сэргээн засах төвийн зохицуулагч Б.Түмэндэмбэрэл, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмч С.Байгальмаа, Гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны ахлах мэргэжилтэн У.Дэлгэрхишиг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, С.Одонтуяа, Б.Баярбаатар, О.Номинчимэг, Х.Баасанжаргал, М.Нарантуяа-Нара, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Д.Мөнх-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батбямба, Гаалийн ерөнхий газрын Хар тамхи, мөнгөн угаахтай тэмцэх хэлтсийн дарга Г.Ганзориг, Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх албаны дарга Э.Товуудорж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний дэргэдэх Сэтгэц, нийгмийн сэргээн засах төвийн зохицуулагч Б.Түмэндэмбэрэл нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, М.Нарантуяа-Нара, С.Эрдэнэболд, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: 1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 10
Бүгд: 19
47.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

8.Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Байгалийн ургамлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Гэр бүлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 10
Бүгд: 19
47.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

19.Гэр бүлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Жолоочийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ирээдүйн өв сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Монгол Улсын төрийн ордны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9

Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Тагнуулын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Усан замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Харьяатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Цэргийн алба хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Шуудангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

38.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

39.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

41.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

42.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 19 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Тав. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй тул тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 19 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 42 минут үргэлжилж, ирвэл зохих 28 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 71.4 хувийн ирцтэйгээр 19 цаг 16 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 06 дугаар сарын 02-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
15 цаг 34 минут.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Хууль зүйн байнгын хорооны гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг эрье. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, 67,9 хувьтай Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хороо /ХЗБХ/-ны 2026 оны 06-р сарын 02-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурал /УИХ/-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Дамдины Цогтбаатар, Норовын Алтанхуяг, Халтмаагийн Баттулга, Хүрэлбаатарын Баасанжаргал, Энхбаярын Батшугар, Дамбын Батлут, Баярмагнайн Баярбаатар, Жудагийн Баярмаа, Лхагвын Мөнхбаатар, Мөнхтөрийн Нарантуяа-Нара, Одсүрэнгийн Номинчимэг, Салдангийн Одонтуяа, Ухнаагийн Отгонбаяр, Пүрэвжавын Сайнзориг, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг, Саруулсайханы Цэнгүүн, Сүхбаатарын Эрдэнэболд гэсэн бүрэлдэхүүнтэйгээр 67.9 хувьтайгаар ирц бүрэлдсэн байна. Ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр төлөвлөгөөт ёсоор 6 асуудал байна. 1.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд УИХ-ын гишүүн Сайнзориг нарын 7 гишүүн 2026 оны 05-р сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх асуудал байгаа. Хоёрдугаар асуудал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл УИХ-ын гишүүн Энхтүвшин нарын 6 гишүүн 2026 оны 04-р сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх асуудал байгаа. Гуравдугаар асуудал, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль шинэчилсэн найруулга байгаа. Энэ хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд, ЗГ 2026 оны 03-р сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх асуудал байгаа. Дөрөвдүгээр асуудал, Хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, УИХ-ын гишүүн Батчимэг нарын 9 гишүүн 2025 оны 07-р сарын 03-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг байгаа. Тавдугаар асуудал, Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төсөл. Зургаадугаар асуудал бусад гэсэн томьёололтой хэлэлцэх асуудлууд байгаа.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байвал нэрсээ өгнө үү? Уянгахишиг гишүүн, та кнопоо дараад. Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Хэлэлцэх асуудлын дараалалтай холбоотойгоор горимын санал гаргах гэсэн юм. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль /ЗХАБТХ/-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад

хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлгээр хэлэлцүүлэх ёстой. Энэ дээр 2 зарчмын зөрүүтэй саналыг гүйцээн боловсруулах авсан тэр асуудлыг хэлэлцчих учраас нөгөө шинэ хуулиудын өмнө 1 дүгээр асуудал болгож өгөөч гэдэг горимын санал гаргаж байна.

Д.Цогтбаатар: Горимын саналыг миний хувьд дэмжиж байна. Тэгэхээр энэ горимын гаргасан саналаар өөрөөр хэлбэл 4 дүгээр асуудлыг 1 дүгээр асуудал болгоё гээд санал хураая. Тэгээд 2 дахь нэг надад санал байгаа. Тэр нь бусад гэсэн 6 дугаар асуудал өнөөдөр хэлэлцэх асуудал нь байхгүй байгаа учраас энийг хэлэлцэх асуудлаас хасъя гэсэн ийм 2 горимын санал гаргаад, энүүгээр санал хураалт явуулъя.

Эхний 4 дүгээр асуудлыг 1 дүгээр асуудал болгоё гэсэн саналаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү. Гишүүд бэлдсэн байгаа юу? Санал хураалт дэмжье гэсэн томъёоллоор. Эрдэнэболд гишүүн, уучлаарай. Эрдэнэболд гишүүний микрофон.

С.Эрдэнэболд: Горимын санал гаргая. Саяын санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү. Дахиад санал хураалгах гэсэн юм.

Д.Цогтбаатар: Саяын саналыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ. Түрүүний томъёоллоор 4 дүгээр асуудлыг 1 дүгээр асуудал болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Тэгээд нөгөө 6 дугаар асуудлыг хасъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг нарын 9 гишүүн 2025.07.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

ЗХАБТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл УИХ-ын гишүүн Батчимэг нарын 9 гишүүн 2025 оны 07-р сарын 03-ны өдөр өргөн мэдүүлсэн эцсийн хэлэлцүүлэг явуулахаар байгаа. Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг Байнгын хорооны гишүүдэд тараасан байгаа. Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, УИХ-ын гишүүн Уянгахишиг танилцуулна. Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол УИХ-ын гишүүн П.Батчимэг нарын 9 гишүүнээс 1925 оны 07-р сарын 03-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн ЗХАБТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол УИХ 2026 оны 05-р сарын 28, 29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлсэн.

Монгол УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу ЗХАБТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар нэг санал, хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар нэг зарчмын зөрүүтэй саналыг гүйцээн боловсрууллаа.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, ЗХАБТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулиудын төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа. Ажлын хэсэг.

Д.Цогтбаатар: Уянгахишиг гишүүнд баярлалаа. Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгатай холбогдуулан асуулт асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Эрдэнэболд гишүүнээр тасаллаа.

Би ажлын хэсгийг танилцуулчихъя хуралд оролцож байгаа. Б.Батзориг Цагдаагийн ерөнхий газар /ЦЕГ/-ын Хуулийн хэлтсийн дарга, Т.Эрхэмбаатар Зам, тээврийн яам /ЗТЯ/-ны Замын хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан ахлах шинжээч, А.Энхболд ЗТЯ-ны Замын хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн гэсэн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг оролцож байна. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Эцсийн хэлэлцүүлэг Байнгын хороогоор хийгдэж байна ЗХАБТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах. Нийгэмд үүсээд байгаа ялангуяа явганаар зорчих хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль гэж ерөнхий зарчмын хувьд ойлгож дэмжээд байгаа бас хууль санаачлагч. Тэгэхдээ энэ саналуудыг хараад байхаар зарим нэг зүйлүүдийг тодруулах зайлшгүй шаардлага байна. Одоо ээж аав тодорхой үүрэг хүлээж байна. Хүүхдээ мопед, скүүтер унуулахгүй байх. 18 насанд хүрээгүй хүүхдүүд замын хөдөлгөөнд оролцоод явбал ээж аавыг торгох юм байна. Эргээд ийм техникийн шийдэл хийгээгүй компанийг торгох юм байна. Ер нь бусдын зэмийг халдааж хэрэглэх энэ зарчим байж болох уу, энэ дээр чадах уу?

Ээж аав одоо магадгүй 2 найз явж байгаад унаад явчихъя, нэг нь 18 хүрчихсэн, нэг нь 17-той байж байхдаа бие биедээ мопед түрээслээд ч юм уу өөрийнхөө 18 хүрсэн нөхөр нь аваад өгчихье. Энэ дээр тэгээд ингээд явахаар одоо аав ээж нь хүлээх нь байна шүү дээ. Наадах чинь нөгөө Зөрчлийн хууль болон Монгол Улсын Үндсэн хуульд заасан бусдад жижиг ч бай, бага ч бай бусдад зэм, шийтгэл алдаж хэрэглэж болохгүй гэсэн суурь зарчмыг зөрчиж байгаа юм уу, үгүй юу? Энэ дээр нэг хариулт өгөөч 1 дүгээрт.

2 дугаартаа энэ скүүтер /scooter/, мопедтой хүмүүс автомашины замаар явах ёстой. Автомашины зам дээрээ баруун талаараа ер нь шахаж явах юм байна гэж

ойлгож байна. Энэ том машинууд буюу том тракуудын сохор бүсэд орж ирж байгаа юм. Ингэж хууль баталж улам бүр замын осол аваарыг нэмэгдүүлэх, энэ дундаа хүүхэд залуучуудын амь нас, эрүүл мэндээрээ эрсдэх нөхцөл байдлыг хууль баталж шийдэж өгөөд байгаа юм биш биз дээ? Баруун талаараа шахаж явна, автобуснууд 1 дүгээр эгнээгээр явж байгаа, яг одоо энүүгээрээ ингээд бас дүрэм бариулаад янз бүр болоод явдаг. Би зүгээр болгоомжлолын үүднээс яаж байгаа шүү. Протоколд үлдэг. Энэ том, том машинуудыг нь сохор бүсээр, сохор бүс дээр явуулах гэж байна шүү дээ энэ одоо. Ер нь зөв үү? Хэдүүлээ нэг аймаар тийм зөв юм хийх гэж байна гэж байгаад баахан хортой юм хийчих вий дээ. Ингээд баахан автобусны жолооч нар нь хэрэг төвөгт орох, чадна, чадахгүй хүмүүс зам дээрээ гарч байгаад явах ийм зүйлүүд байх юм.

Уг нь бол би шийдэл нь тодорхой, энэ скүүтер, мопедод тавигдах шаардлагуудаа тавиад, орон нутаг болгон өөрсдийнхөө хэмжээгээр зохицуулчих байсан юм. Энэ хэсэг дээр мопедтой явж болно, энэ хэсэг дээр түрээд явна, энэ хэсэг дээр зөвхөн замаар гээд тэмдэглэгээгээрээ шийдэх эрхүүдийг тухайн аймаг, нийслэлийн иргэдийн.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Гүйцээгээд асуучих. Сайнзориг гишүүний микрофоныг өгье гүйцээгээд.

П.Сайнзориг: Өгчихвөл зүгээр байсан байхгүй юу. Одоо энэ хуулийн зохицуулалт чинь аймгуудад томдчихно. Аймгуудад ингээд сүртэй юм яваад байгаа юм байхгүй. Энэ Улаанбаатар хотын асуудлыг зохицуулах гэж байна гэж байгаад аймгуудад дагаж мөрдөхөд хэцүү, тэгээд шал хэрэггүй ийм зүйлүүдийг бий болгочхож байгаа юм. Тэгэхээр уг нь ийм зүйлүүдийг орон нутаг нь шийдээд явчих эрх мэдлийг нь өгчих ёстой байхгүй юу. Ийм зүйлүүд байна, 3 асуулт байна. 1 дүгээрт, тэр ял зэм, шийтгэлийг халдааж хэрэглэж болж байгаа юм уу? Мэргэжлийн хүмүүс хариулаадхаач. 2 дугаарт, энэ сохор бүс дээр явахаар улам осол аваар чинь ихсэх юм биш үү, бүр бүр ноцтой болох юм биш үү? 3 дугаарт, уг нь аймаг, нийслэлийн иргэдийн хурлын хэмжээнд нь тодорхой энэ хуулиараа мопед болон скүүтерийнх нь хурд байдаг юм уу, тавигдах ерөнхий шаардлага, ямар хүмүүс жолоодох гэдэг юм уу ийм зүйлүүдийг нь тавиад, яг энийгээ тодорхой тэмдэглэгээ.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Ажлын хэсэг хариулах уу? 1 дүгээр микрофон.

Б.Батзориг: Гишүүний асуусан асуултад хариулъя. Эхний асуултын хувьд Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлд байдаг л даа. Гэмт хэрэг үйлдсэн хүнд өөрт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ, эрүүгийн хариуцлагыг бусад хүнд халдаан хэрэглэж болохгүй гэсэн хууль ёсны зарчим байгаа. Ажлын хэсгээс энэ зөрчилтэй холбоотой асуудал дээр ингэж шийдвэрлэсэн байгаа. Тухайлбал ЗХАБТХ замын хөдөлгөөний дүрэмд зааснаар одоо байгаа эрх зүйн зохицуулалтын хувьд 10 насанд хүрээгүй хүнийг замын хөдөлгөөнд ганцааранг нь оролцуулахгүй байх эрх зүйн зохицуулалттай байгаа. Үүндээ нийцүүлээд мөн 16 насанд хүрээгүй хүүхэдтэй холбоотой асуудлууд байгаа. Үүндээ нийцүүлээд ажлын хэсгээс шийдвэрлэсэн зохицуулалтууд, төслүүд, саналууд байгаа. Хуулийн хувьд Эрүүгийн хуульд энэ зарчим хэвээр үйлчилж байгаа.

Д.Цогтбаатар: Уянгахишиг гишүүн хариулъя.

Г.Уянгахишиг: 3 асуултад ерөнхийдөө товчхон хариулчихъя. 1 дүгээрт, яг энэ хариуцлага нь ЗХАБТХ-д эцэг эхийн үүрэг болоод орж ирж байгаа. Өөрөөр хэлбэл, яг хуулиар тогтоосон үүрэг нь буюу эцэг эхийн өөрийнх нь үүрэг учраас тэр үүргээ, хариуцлага алдсаны үр дүн нь Зөрчлийн хууль дээр тусгагдаж орж ирж байгаа юм. Тэгэхээр өөрөөр хэлбэл, яг энэ гэм зэм нь өөрөө эцэг эх дээр байгаа буюу тэр зохицуулалт нь ЗХАБТХ дээр тусгагдчихаж байгаа учраас Зөрчлийн хууль дээр шууд халдаан хэрэглэж байна гэж үзэх нь хэр зохистойг мэдэхгүй байна. Ер нь бол эцэг эх өөрийн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй учраас Зөрчлийн хуулиар хариуцлага хүлээж байгаа гэж ойлгож болно.

2 дугаарт, авто замаар явна гэхээр мэдээж аюул осол ихсэж байгаа. Гэхдээ одоо бид Замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм рүү.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Гүйцээгээд хариулъя, Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Яг тухайн хуулиар ЗХАБТХ-д тусгайлан нөхцөлүүдийг зааж өгөх нь өөрөө нөгөө замын хөдөлгөөний дүрмийнхээ буюу хуулийн техникийн хувьд зарчим алдагдаад байгаа учраас замын хөдөлгөөний дүрмийн дагуу шийдэхээр зохицуулалтыг зассан байгаа. Үүн дээр бол жишээлбэл, замын хөдөлгөөний дүрмийн 25.4 дээр юу гэж байгаа вэ гэхээр унадаг дугуй унадаг дугуйн зам буюу унадаг дугуйн эгнээгээр явах бөгөөд дараах тохиолдолд зорчих хэсгийн баруун гар талын захаар байрлан явж болно гэдэг ийм зохицуулалттай. Нөгөө талаасаа яг энэ мопед дээр яг энэ заалт адилхан үйлчилж байгаа гэсэн үг. Тэгэхээр мопед буюу түүний төрөлд хамаарах цахилгаан скүүтер гэж орж ирж байгаа учраас унадаг дугуйг 14-өөс, мопедыг 18-аас дээш насны хүн жолоодож замын хөдөлгөөнд оролцохдоо унадаг дугуйн зам буюу унадаг дугуйн эгнээгээр явах бөгөөд дараах тохиолдолд зорчих хэсгийн баруун гар талын захаар.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Гүйцээх үү? Уянгахишиг гишүүн гүйцээгээд хариулъя.

Г.Уянгахишиг: Тэгэнгүүт яг дүрэм дээрээ 25.5 дээр энэ дүрмийн 25.4-д заасны дагуу зорчих хэсгийн захаар байрлан явахад хүндрэлтэй буюу боломжгүй байвал унадаг дугуй, мопед нь хөвөөгөөр явган зорчигчдод саад учруулахгүйгээр явбал зохино гэдэг. Хэрвээ явган зорчигчийн хөдөлгөөний ирэлт ихтэй байвал бууж явгалан явган зорчигчийн үүргээр хөдөлгөөнд оролцоно гээд яг энэ зохицуулалтыг замын хөдөлгөөний дүрэм дээр маш нарийн зохицуулчихсан учраас энэ мопед, түүнтэй адилтгах буюу түүний төрөлд хамаарч байгаа цахилгаан скүүтерийн хөдөлгөөн энүүгээрээ зохицуулагдаад явна гэсэн үг.

3 дугаар асуултын хувьд анхнаасаа хууль санаачлагчийн хувьд Сайнзориг гишүүн бас хууль санаачлагчаар байгаа. Энэ хуулиараа зохицуулсан нь зөв юм байна гэдэг байдлаар оруулж ирсэн. Энэ утгаараа орон нутагт эрх, үүрэг өгнө гэхээсээ илүүтэйгээр хуулийн зохицуулалт оруулж ирсэн бөгөөд харин орон нутаг буюу нийслэл, аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж байгаа тэр зохицуулалт.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Үгүй ээ, би өөрийн чинь асуусан асуултаар тэр 2 дахь асуултаар яг мэргэжлийн хүмүүс хариулмаар байна. Тэгэхгүй энд гишүүд хариулж мэдэхгүй шүү дээ. Тэр харагдахгүй blind spot гэж яриад байгаа сохор бүс гэж яриад байгаа шүү дээ. 4 дүгээр микрофон, тэр бол асуух ёстой асуулт байгаад байна. 4 дүгээр микрофон.

А.Энхболд: ЗТЯ-ны Замын хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн Энхболд байна. Тэгэхээр замын хөдөлгөөний аюулгүй байдал гэдэг бол ганцхан хүнээс хамаардаг биш, замын хөдөлгөөний аюулгүй байдал гэдэг бол хүнд тээврийн хэрэгсэл, зам, орчин гэсэн 4 элементийн аюулгүй байдлын цогц гэж үздэг юм. Тэгэхээр энэ замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад инженерийн шийдэл гэдэг бол 90 хувийн үүргийг гүйцэтгэдэг, эрх зүйн шийдэл бол 10-аас 15 хувийн үүргийг гүйцэтгэдэг гэж үздэг юм. Тэгэхээр энэ дээр Сайнзориг гишүүний хэлдэг бол яах аргагүй үнэн л дээ. Тээврийн хэрэгсэл, том оврын автобус хөдөлгөөнд оролцоход яах аргагүй нөгөө унадаг дугуйтай хүмүүс, мопедтой хүмүүс бол сохор бүсэд орно. Энийг одоо яадаг вэ гэхээр гарц шийдэл нь юу юм бэ гэхээр инженерийн шийдэл буюу тэр явган, тэр скүүтерийн зам, дугуйн замыг инженерийн шийдлээр аль болохоор тусгаарлах, тусгаарлаж өгөх хэрэгтэй. Манай Монгол Улсад бол.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 4 дүгээр микрофон, гүйцээгээд өгье.

А.Энхболд: Явган хүний зам, унадаг дугуйн замын өөрийнх нь стандарт бий. Тухайлбал, унадаг дугуйн зам гэхээр нэг унадаг дугуй явах өргөнийг бол нэг метр, 2 унадаг дугуй зөрж өнгөрөхөөр бол одоо яадаг вэ гэхээр аюулгүй байдлыг хангах хажуугийн зай нь бол 50 сантиметр, захаар явах аюулгүй байдлыг хангах хажуугийн зай 25 сантиметр гэж тооцоод, тэгээд 2 дугуй дөнгөж зөрж өнгөрөхөөр бол хамгийн багадаа 2.5 метр байх ёстой гээд энэ бүх хэмжээг нь тодорхойлчихсон ийм зам бий. Дан явган хүний явган хүний эрчим нь бол одоо 300-ас дээш байх юм бол заавал унадаг дугуй, явган хүний зам 2-ыг тусад нь шийдэж өгнө гэсэн ийм стандартууд нь бүгдээрээ байдаг. Харамсалтай нь, энэ стандарт нь хэрэгжихгүй байж байгаа. Өнөөгийн одоо ашиглагдаж байгаа унадаг дугуйн зам, явган хүний.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 4 дүгээр микрофон, гүйцээгээд өгье.

А.Энхболд: Өөрийнх нь инженерийн шийдэл бол өнөөгийн стандартын шаардлага хангахгүй байх асуудал нь 80-аас 90 хувь нь шаардлага хангахгүй байна л гэж үзэж байгаа. Энийг шаардлага хангуулах заавал шаардлагатай. Ингэж байж аюулгүй байдал хангагдана.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Хотуудад бол энэ мопед, скүүтерийн асуудал тулгамдсан, тэгээд уг нь зохицуулах гэж орж ирж байгаа. Харин энэ зохицуулалт маань явж, явж улам зам тээврийн осол, ялангуяа энэ том машин 1 дүгээр эгнээгээр автобус явна гэдэг бид зориулалтын юман дээр бол улам нөхцөл байдлыг хүндрүүлэх юм байна гэж би зүгээр хувьдаа бодож байна. Тэгээд мэргэжлийн хүмүүс сайн ажилласан юм байлгүй дээ, үр дагаврыг нь тэгээд одоо хэн ч хариуцахгүй, хуулийн нэг ийм зовлон байдаг юм л даа. Ийм сонин юм хийжээ. Энийг зүгээр яах вэ, протоколд үлдэг.

2 дугаарт, мопед унаж яваад хүн гэмтээчихвэл ээж аав нь хариуцах уу? Энэ чинь бага насны хүүхдийг л замын хөдөлгөөнд ганцааранг нь оролцуулбал ээж аав хариуцлага хүлээх, бусдуудад нь бол байж байгаа шүү дээ. Энэ ингээд эрх зүйн зарим чадамжтай, бүрэн чадамжтай, хэсэгчилсэн чадамжтай гэдэг энэ үр дагавруудыг тооцож, ялгаж салгаж энийг чинь хийдэг болохоос биш хавтгайд нь

аваачаад 18 нас хүрээгүй хүүхдийг ийм юм байж болохгүй. Энийг татаж аваад ажлын хэсэг дахиад ажиллавал яадаг юм бэ? Ингэж ял зэмийг халдааж болохгүй.

Д.Цогтбаатар: Гүйцээж асуух уу? Уянгахишиг гишүүн гүйцээгээд хариулах уу? С.Эрдэнэболд гишүүн. Ажлын хэсгээс харин би тийм учраас асуугаад байна шүү дээ. Тэгэхдээ та хэд чинь хоорондоо яриад байхаар. Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэболд: Ер нь бол зохицуулалт шаардлагатай юу гэвэл шаардлагатай. Тодруулах зүйлс байна. Одоогийн энэ ЗХАБТХ маань 2015 оны 07-р сарын 08-нд батлагдсан гэх юм бол 11 дэх жил рүүгээ орж байгаа. Тус хууль дээр хууль зүйн нэр томъёоны талаас 11 тайлбар байгаа. Энийг юу гэж ойлгох вэ гэдэг технологи явган зорчигчоос өгсүүлээд. Тэгэхээр 2018 оны ЗГ-ын 239 дүгээр тогтоолоор батлагдсан замын хөдөлгөөний дүрэм дээр 55 төрлийн тодорхойлолт байгаа. Жишээлбэл, 1.2.24 дээр мопед гэж юуг хэлэх вэ гэдгийг ингээд тодорхойлчихсон байгаа. Тэгэхээр одоогийн энэ хуулийн нэмэлт, өөрчлөлт маань мопед, скүүтер гэсэн үг маш олон давтамжтайгаар орж ирж байгаа. Тэгэхээр мопедоо ямар ч байсан тодорхойлчихсон бол, скүүтерээ бид тодорхойлоогүй байгаад байгаа юм. Тэгэхээр одоо яг бодвол замын хөдөлгөөний дүрэм энэ хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдсаны дараагаар замын хөдөлгөөний дүрэм дотроо скүүтерийн тодорхойлолт орж ирэх байх гэж бодож байгаа. Тэгэхээр яг энийгээ ард нь Монгол хэлээр маш сайн нөгөө морь тайлбарлаж байгаа юм шиг тайлбарлахгүй бол технологи чинь хөгжөөд яваад байдаг, 11 жилийн өмнөх мопедын үзүүлэлт одоо шал өөр болчихож байгаа байхгүй юу. Тэр технологи хөгжингүүт бид нар нэгэнт л хуульд хүрч нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа бол тэр технологийнх нь шийдлийг давхар шинэчлэх зайлшгүй шаардлага байна.

Бас нэг юм байна. Ховерборд /hoverboard/ гээд нэг юм байна, 2 төрлийнх байна. Нэг нь яг нэг том дугуйн дээр 2 талдаа дөрөөтэй тэнцвэрээ олж явдаг зүйл. Энийг унаж байгаад гэмтэл авсан маш олон хүн байна. Нөгөөдөх нь 2 дугуйны голд тэнцвэрээ олоод явдаг гишгүүртэй төрөл байна. Үүний хүчин чадал яг одоо скүүтер болон түүнээс илүү хүчин чадалтай болчихсон байгаа юм. Одоо Монголд яг ийм төрлийн хэрэглэгч нар их байна, зонхилох биш юм гэхэд байна. Тэгээд нэгэнт орж байгаа юм чинь энэ мопед, скүүтер, нэмэх нь ховерборд гээд оруулаад явахгүй бол одоо хүүхдүүд яах вэ гэхээр нэгэнт хууль баталчихаар хуулиас тойроод ховербордын хэрэглээ маш их болно. Энэ бол олон нийтийн зам, машин зам дээр хэрэглэх боломжтой өндөр хүчин чадалтай ховербордууд маш их ороод ирчихсэн байж байгаа. Энийг ингээд орхигдуулахгүйгээр оруулах саналтай байгаад байгаа юм, ер нь зүгээр. Тэгэхгүй болохоор яах вэ энэ чинь агуулгын хувьд 2 дугуйтай юу, нэг дугуйтай юу гээд явж байгаа. Гэхдээ яг энэ бол ингээд хуулиас гадна үлдчих шиг болох юм. Энэ дээр ямар судалгаа байна вэ?

Д.Цогтбаатар: Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Ер нь бол нэр томъёо болон хуулийн зохицуулалт нийцүүлээд замын хөдөлгөөний дүрмийг шинэчлэх, зохих өөрчлөлтүүдийг тусгахыг УИХ-ын тогтоолоор үүрэг болгочхож байгаа. Яг энэ нэр томъёоны хувьд ЗХАБТХ-ийн 3.1.12 дээр нэр томъёог нь маш тодорхой тусгаад өгчхөж байгаа. Энэ дээр юу гэж байгаа вэ гэхээр мопед түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл гэж ямар тээврийн хэрэгслийг хэлэх вэ гэхээр 50 куб сантиметрээс ихгүй ажлын багтаамж бүхий дотоод шаталтад хөдөлгүүртэй эсвэл

0.25 киловаттаас 4 киловатт хүртэл чадал бүхий цахилгаан хөдөлгүүртэй, техникийн дээд хурд нь 50 километр цагаас ихгүй 2 эсвэл хэд хэдэн дугуйтай тээврийн хэрэгслийг гэж заасан байгаад байгаа юм.

Тэгэхээр үүнд одоо жишээлбэл ховерборд чинь техникийн нөхцөлийнхөө хувьд жишээлбэл 0.25 киловаттаас доош байвал энэ зохицуулалт орохгүй, 0.25 киловаттаас дээш хүчин чадалтай байх юм бол энэ хуулийн зохицуулалтад ороод явна гэсэн үг. Тэгэхээр энэ дээр одоо яг тийм дугуйтай, ийм юмтай гэж ингэж нөгөө нэрлэж хийх бол угаасаа боломж байхгүй. Яг Эрдэнэболд гишүүний хэлснээр энэ бол цаг, бараг цагаар өөрчлөгдөж явж байгаа хэлбэр дизайн, өгөгдөл, нэр томьёо, бүх юм өөрчлөгдөж явж байгаа учраас ингэж орж ирж байгаа юм. Тэгэхээр яг энэ нэр томьёотой нийцээд замын хөдөлгөөний дүрэм дээр нөгөө мопед гэдгийн оронд яг мопед түүний төрөлд хамаарах скүүтер гээд яг энэ нэр томьёогоор өөрчлөгдөх юм байгаа юм. Тэгэхээр энэ цаашаагаа ийм нөхцөл байдлаар, ийм нэр томьёо, нэршлээр цаашаа явна гэсэн үг.

Д.Цогтбаатар: С.Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье, тодруулъя.

С.Эрдэнэболд: Тийм, та хэд бас давхар лавлаарай. Яагаад гэхээр энэ адилтгах гэдэг тэртээ тэргүй ингээд жишээлбэл мопед гэхээд нөгөө талд нь скүүтер, түүнтэй адилтгах гээд нэрийг нь заах уу, заахгүй юу? Энийг дүрэм дээрээ болох байх гэж бодож байна.

Дээрээс нь ингэж байгаа юм, одоо би ингээд Болор толь гээд энэ хэл шинжлэлийн талаас ингээд нэгэнт хууль шинээр орж ирж байгаа, одоо хэрэгжиж байгаа хууль нь 11 жилийн өмнөх, хуулийн дагуу замын хөдөлгөөний дүрэм маань нийтдээ 9 жилийн өмнө батлагдсан ингээд явж байгаа. Тэгэхээр бид яг скүүтер гэдэг үгийг яг хууль зүйн нэр томьёонд шинэ тутам оруулж байгаа юм. Гэнгүүт одоо энэний галиглалын зарчмаа болохоор бид яг нөгөө Непкогийнхон нөгөө институт гэдэг үгийг институт гэж номууд дээрээ бичээд байдагтай адилхан Монгол маягийн сонссоноор галиглачхаж байгаа юм л даа. Одоо жишээлбэл, орос галигаар бид нар ихэвчлэн кирилл бичгээ дагаад скутер ч гэдэг юм уу тэгж бичих гээд байна шүү дээ. Яг нийтийн юугаа.../минут дуусав/

Д.Цогтбаатар: С.Эрдэнэболд гишүүний микрофоныг гүйцээгээд өгье.

С.Эрдэнэболд: Тэгэхээр нөгөө хууль зүйн нэр томьёоны орчуулга тал дээрээ жишээлбэл, бид нар ихэвчлэн кирилл бичиг дээр 100 тохиолдлын 90-ээс дээш хувьд нь орос галигаар нэр томьёог тавьдаг. Орос гэдэг нь яах вэ дээ, нөгөө кирилл галигаар галигчилж тавьдаг мөртөөсөө яг энэ хууль дээр скүүтер /scooter/ гэж бичихдээ 2 ү-тэй Монгол хэллэг талаасаа галиглачхаж байгаа нь, ер нь яг зөв үү? Зүгээр тодруулж асууж байгаа шүү. Тэгээд энийг та нар яг ингээд хэл шинжээчтэй ярьсан уу? Яг одоо скүүтер гэж 2 ү-тэй бичих нь зөв үү? Яагаад гэхээр энэ ингээд нэг явчих юм бол прецедент /precedent/ байдлаар цаашлаад ийм технологийн хэлийг одоо бид театрыг театр гэж бичдэгтэй адилхан болж байгаа юм л даа. Тэгэхээр ингээд цаашдаа хуульд ингээд нэг удаа ийм кэйс /case/ оруулчих юм бол дараа дараагийн нэр томьёо дээр яг ийм зүйл давтагдаад явчих юм биш үү? Үгүйсгээгүй шүү, зүгээр тодруулж асууж байгаа юм, олон нийтэд ойлгомжтой байх үүднээс.

Д.Цогтбаатар: Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Зөв, зөв. Яг нэр томъёоны хувьд болохоор ерөнхийдөө хууль санаачлагч яг энэ нэр томъёогоор оруулж ирсэн 1 дүгээрт. Мөн түүнчлэн одоо скүүтерийн компаниуд байгаа, тэдгээрийг улсын бүртгэлд бүртгэхдээ бол яг ийм 2 ү-тэй скүүтер гэдгээр бүртгэж байгаа нэршил дээр нь. Мөн түүнчлэн яг энэ нэршилтэйгээ холбоотойгоор Хэл шинжлэлийн хүрээлэнгээс бас албан бичиг, саналыг нь авсан юм байна лээ. Тэгэхээр одоо ингээд цаашдаа нэгэнт хуульд ингээд өөр хуульд бол энэ нэр томъёо орж ирээгүй, тэгэхээр ингээд анх удаа ЗХАБТХ-д орж ирж байгаа учраас цаашид энэ нэр томъёо энэ хэлбэрээрээ адилхан авагдаад явна л гэж ойлгогдож байна.

Д.Цогтбаатар: Гишүүд асуулт асууж дууслаа. Надад нэг юу байна. Тэр Сайнзориг гишүүний асууж байгаа асуултад Энхболд дарга, ЗТЯ-ны Замын хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн та, Энхболд дарга хариулж байхдаа ингэж байна лээ, харамсалтай нь одоо яг ийм стандарт юмнууд байхгүй байгаад байна гээд. Тэгээд би өөрийн чинь тэр үгнээс юун дээр болгоомжилж байна гэхээр харамсалтай гэдэг чинь тэр эрсдэл байж байна гэсэн үг байна шүү дээ. Тэгэхээр бид энэ хуулийг ингээд өөрчилж гаргаад, араас нь тэгвэл одоо тэр стандартыг өөрчлөх талаар юу хийх ёстой вэ? Ямар хугацаанд, аль болох би өөрөөр хэлбэл яаралтай энийг нь хийхгүй бол бид нэгний аюулгүй байдлыг сайжруулах гээд нөгөө эрсдэлийг нэмээд өгч болохгүй шүү дээ. Тэгэхээр тэрэн дээр одоо энийг дагаад яаралтай тэр эрсдэлийг бууруулах талаар юу хийх ёстой гэж та бодож байна? 4 дүгээр микрофон.

А.Энхболд: Тэгэхээр би нөгөө буруу хэлчихсэн юм болов уу. Манайд явган хүний замын стандарт, дугуйн замын стандарт бүгдээрээ байгаад байгаа юм. Харамсалтай нь, тэр стандартын хэрэгжилт нь байхгүй байна гэдгийг л хэлэх гэсэн юм. Өөрөөр хэлбэл, дугуйн стандарт ямар байх ёстой вэ, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс хэрхэн яаж тусгаарлах ёстой вэ, явган хүний зам нь ямар тохиолдолд дугуйн замаасаа тусгаарлагдах ёстой вэ, дугуйн зам нь ямар хэмжээтэй байх ёстой вэ гэдэг стандартууд нь бүгдээрээ байж байгаа. Тэр стандарт нь одоо стандартын дагуу тэр зам нь тавигдахгүй байна гэдгийг л би хэлсэн юм.

Д.Цогтбаатар: Яг үнэн. Тэгэхээр та сая хүртэл хариулахдаа харамсалтай нь хууль хэрэгжихгүй байна гэж ярьж байна шүү дээ. Хууль хэрэгжихгүй байгаа тухай энд ХЗБХ дээр бид ийм үгийг харин хүлээж авч би болохгүй байгаад байна шүү дээ. Тэгэхээр харамсалтай ерөөсөө байж болохгүй, тэр хэрэгжих ёстой. Хэрэгжүүлэхэд юу нь болохгүй байгаад байна, тэрийг дараа нь хууль хэрэгжүүлэхэд юу хийх ёстой вэ гэдгийг би танаас асууж байна. Бидний зүгээс жишээлбэл, юу хийвэл зүгээр байна вэ? Нөгөө дүрэм журмын, бид жишээлбэл, энэ дээр авч хэлэлцээд энэ хэрэгжихгүй байгаа, хэрэгжүүлэхгүй байгаа, тэр зам барьж байгаа хүмүүстэй хариуцлага тооцох талаар ярих ёстой юу? Тэрийг л би асууж байна.

А.Энхболд: Хууль хэрэгжүүлэхийн тулд хамгийн түрүүнд хариуцлага тооцох ийм механизмыг бий болгох ёстой гэж үзэж байна. 2 дугаарт нь, энэ нэгэнт батлагдсан стандарт, инженерийн шийдэл байх юм бол тэрийгээ одоо тэр стандартыг бол заавал хэрэгжүүлэх ийм нөхцөл бололцоог хангаж өгөх ёстой.

Д.Цогтбаатар: Харин би таныг тэрнийг тэрийг л танаас асуугаад байна, та зоригтой хэлэх ёстой шүү дээ. Би таныг энэ юу хэлээд байна гэхээр замын төсвөө

тавиад өгөөч дээ та нар гээд тэрийгээ зоригтой хэлээч. Яг ийм боломжуудыг ашиглаж та нар хэлж байх ёстой байхгүй юу. Түүнээс та нарыг хэлэхээр бид энд цочроо авч энийг чинь хийнэ шүү дээ. Тэгэхгүй бол тэр төсвийг чинь батлуулах гээд баталж өгдөггүй, гишүүд өөр юм руу зүтгээд л явчихдаг байхгүй юу. Тэгээд ийм чухал асуудлуудаа ийм боломжийг ашиглаж л танай салбарын мэргэжлийн хүмүүс та нар энийгээ хэлж байх ёстой байхгүй юу, тэрийг л би хэлүүлэх гээд байгаа юм. Тэр зам дээр жишээлбэл хэрэгжихгүй байгаа бол яг тэр стандартаар нь тавихгүй байна. Тэрэн дээр мөнгийг нь тавьж өгөхгүй байна, тийм үү? Эсхүл хариуцлага тооцохгүй, харин байгаа бол одоо 1 дүгээр микрофон, Батзориг дарга, арай замын цагдаа чинь хариуцлага тооцохгүй яваад байгаа юм биш биз дээ? Сая бол асуултын хариулт тийм маягаар гарч ирж байна шүү дээ. Тэгэхээр 4 дүгээр микрофон өгөөд, дараа нь 1 дүгээр микрофон хариулъя.

А.Энхболд: Тэгэхээр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг бид нар ерөөсөө тэр түгжрэл гэдэг юм чинь өөрөө 1 дүгээрт нь уг шалтгаан, үр дагавар гээд нэг юм байгаад байгаа юм. Тэгэхээр уг шалтгаан нь бол хот төлөвлөлтийн асуудал, үр дагавар нь өөрөө түгжрэлийн асуудал байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр 1 дүгээрт, төлөвлөлтөө хэрэгжүүлэх, энэ төлөвлөлтийн дагуу замаа тавих ёстой асуудал байгаад байгаа юм. 2 дугаарт нь, бид нарын тэр төсөв шийдэх асуудал, хууль хэрэгжүүлэх асуудал бол энэний дараа шийдэх асуудал болчихоод байна л даа.

Д.Цогтбаатар: 1 дүгээр микрофон. Тэр хариуцлага тооцохгүй байна гэдэг дээр, хажууд чинь яг сууж байгаа мэргэжилтэн ярьж байна шүү дээ. Тэрэн дээр та юу гэж хариулах вэ?

Б.Батзориг: Энхболд мэргэжилтний мэдээлэл нь болохоороо зөвхөн нөгөө түгжрэлтэй холбоотой, мөн төрийн удирдах бүхий байгууллагуудаас гаргаж байгаа шийдвэртэй холбоотой төсөв мөнгөтэй холбоотой асуудлыг хөндөж байна гэж ойлголоо. Цагдаагийн байгууллагаас энэ чиглэлийн тээврийн цагдаагийн алба бол энэ ЗХАБТХ тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажилладаг. Энэ хүрээнд замын хөдөлгөөнтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг алба хаагч нар 24 цагаар үүрэг гүйцэтгэж, Эрүүгийн хуулийн болон Зөрчлийн тухай хуулийн зохицуулалтын биелэлтийг хангах чиглэлээр ажилладаг.

Д.Цогтбаатар: Ер нь бол тэгэхдээ энэ дээр тэр эрсдэл бол гарч байгаа шүү. Эрсдэлээ яаж бууруулах тал дээр энэний дараа ахиад нэмж дүрэм журамд өөрчлөлт оруулах хэрэгтэй бол Батзориг дарга, Энхболд дарга нээлттэй ирж надтай яриарай, би тэрийг чинь дэмжиж өгнө шүү. Яагаад гэвэл нэг хууль сайжруулах гээд нөгөө эрсдэлийн үүд хаалгыг нээгээд байж бид нар болохгүй шүү дээ, тэрийгээ сайн анхаараарай. Ирж надтай яг энэ асуудлаараа тодорхой тусгайлан би уулзахыг та 2-т бас урьж байна. Ирж энийгээ яриарай.

Гишүүд санал хураалтдаа бэлдээрэй. Одоо 2 санал хураалт явна шүү. ЗХАБТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол. УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтад заасны дагуу дараах саналыг хураалгана.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 13¹ дүгээр зүйлийн 13^{1.2.9} дэх заалтын зүй зохистой ашиглах, хэрэглээний соёлыг эзэмшүүлэх гэснийг, 13^{1.2.5} дахь заалтын оршуулгын газар гэснийг болон 13^{1.2.3}, 13^{1.2.4}, 13^{1.2.6} дахь заалтыг

тус тус хасах гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 55 хувиар санал дэмжигдлээ.

2 дахь санал хураалт төслийн 1 дүгээр зүйлийн 59, 60, 61, 64 дэх хэсэг болон 63.2, 63.3, 63.4 дэх заалтыг хасаж, 63.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж дугаарыг 62 болгон өөрчлөх.

62.Нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээд нь эрх бүхий этгээдээс тогтоосон зогсоолын байршлаас бусад нийтийн эзэмшлийн зам, гудамж, талбай, нийтийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт хүрээлэн, авто зогсоол, ногоон байгууламж, нийтийн зориулалттай орон сууцын байшингийн орчны газрын ногоон зүлэг, хүүхдийн тоглоомын талбай, эдгээртэй адилтгах газарт тээврийн хэрэгслээ байршуулсан бол 50 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэсэн томъёоллоор, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 55 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд УИХ-ын гишүүн Уянгахишиг гишүүн өөрөө танилцуулчих уу? Уянгахишиг гишүүн танилцуулна. Ингээд 1 дүгээр асуудал хэлэлцэж дууслаа.

16.13 цаг

Одоо дэс дарааллаараа 2 дахь асуудал руу ороод явна.

Хоёр.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 7 гишүүн 2026.05.14 -ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд УИХ-ын гишүүн Сайнзориг нарын 7 гишүүн 05-р сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх асуудал байгаа. Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол УИХ-ын гишүүн Пүрэвжавын Сайнзориг танилцуулна. 10 минутад гишүүнээ багтааж танилцуулаарай. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

УИХ-ын гишүүн Н.Алтаншагай, Д.Амарбаясгалан, М.Мандхай, Л.Мөнхбаатар, Х.Тэмүүжин, Г.Уянгахишиг нарын хамтаар Монгол Улсын Үндсэн хуулийн 20 дугаар зүйлийн нэг дэх, Үндсэн хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн 20 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт Монгол УИХ бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү УИХ хадгална гэж, 25 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт УИХ нь төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ гэж, мөн хэсгийн нэг дэх заалтад хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах гэж тус тус заасан.

Түүнчлэн Монгол Улсын ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.1.14-д хүний эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын гэрээний конвенцод нийцүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж хуулиас давсан зохицуулалт бүхий дүрэм журмуудад дүн шинжилгээ хийж цэгцлэх арга хэмжээ авна гэж заасан. Харин парламент нь хэм хэмжээ тогтоох эрхийг бусад албан тушаалтан, байгууллага буюу нийтлэгээрээ гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад шилжүүлэх нь олон улсын жишиг төдийгүй манай улсын хууль зүйн тогтолцоонд хэвшиж буй ойлголт болно.

Парламент нь хэм хэмжээ тогтоох эрхийг бусад албан тушаалтан, байгууллагад зөвхөн хуулиар шилжүүлдэг бөгөөд хуулиар эрх олгогдсоны дагуу батлах эрх зүйн дэд актын агуулга, хүрээ, хязгаарыг хуульд тодорхой тусгах шаардлагатай байдаг. Энэхүү эрх зүйн дэд актын зарим тодорхой хэсгийг захиргааны хэмжээний акт гэсэн нэршлийн хүрээнд Хууль тогтоомжийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Монгол УИХ-ын тухай хуулийн хүрээнд зохицуулж байна. Захиргааны ерөнхий хуулийг 2016 оны 07-р сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхлэхээс өмнө захиргааны хэмжээний акттай холбоотой харилцааг ЗГ-ын тогтоолоор баталсан журмын хүрээнд зохицуулж байсан байдаг.

Харин Захиргааны ерөнхий хуульд захиргааны хэмжээний акт батлах эрх, эх сурвалж, үндэслэл, актад тавигдах шаардлага, хүчин төгөлдөр болох нөхцөл, түүнийг хянан бүртгэж мэдээллийн сан үүсгэх, мэдээллийн сангаас сонирхогч этгээдийг мэдээллээр хангах зэрэг харилцааг тодорхой тусгасан хэдий ч захиргааны хэмжээний акт батлах субъектийг захиргааны байгууллага гэсэн нэр томъёоны хүрээнд ерөнхий шинжээр нь тусган зохицуулсан байдаг. Монгол Улсын хэмжээнд 2025 оны 09-р сарын байдлаар 2400 орчим захиргааны хэмжээний акт улсын нэгдсэн бүртгэлд бүртгэлтэй байх бөгөөд Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.2-т зааснаар Монгол Улсын Ерөнхийлөгч, ЗГ-ын баталсан захиргааны хэмжээний актыг УИХ-д хүргүүлдэг зохицуулалттай.

Мөн энэхүү захиргааны хэмжээний акт нь хууль тогтоомжид зааснаар нийтлэг байдлаараа дээд шатны байгууллага, захиргааны шүүхийн хяналтад, зарим субъектийн баталсан захиргааны хэмжээний акт нь ҮХЦ-ээр хянагдах боломжтой байдаг. Эрх бүхий этгээдийн шийдвэр, үйл ажиллагаа нь шүүх болон ҮХЦ буюу шүүх эрх мэдлийн байгууллагын хяналтад байх нь Монгол Улсын Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал, зарчим төдийгүй хууль дээдлэх зарчим, хүний эрхийг хамгаалахад өндөр ач холбогдолтой болно.

Гэвч Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжүүлж эхлэхээс өмнө хууль тогтоох практикт нийтэд заавал дагаж мөрдөх үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй эрх зүйн хэм хэмжээг бий болгох, тогтоох эрх мэдлийг байгууллагын дотоод бүтцийн нэгжид шилжүүлэх явдал бий болсон байдаг. Тухайлбал, УИХ-ын Байнгын хороо, дэд хороонд захиргааны хэмжээний актын шинжийг агуулсан шийдвэр гаргах эрх мэдлийг шилжүүлсэн нь цөөнгүй бөгөөд хуулийн зохицуулалт өнөөдөр ч үйлчилж байна. УИХ-ын Байнгын болон дэд хороо нь УИХ-ын үйл ажиллагааны зохих салбар, чиглэлээр байгуулагдсан хуулийн этгээдийн эрхгүй дотоод бүтцийн нэгж төдийгүй шийдвэр нь шүүх, ҮХЦ-ийн хяналтад байдаггүй. Түүнчлэн баталсан шийдвэрийн бүртгэлийн сан байхгүй, лавлагаа мэдээллээр иргэд, хуулийн этгээдийг хангах нэгдсэн зохицуулалт байдаггүй болно.

Нөгөөтээгүүр, Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд зааснаар УИХ нь хууль тогтоох онцгой бүрэн эрхийг эдэлдэг. Түүнчлэн Монгол УИХ-ын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5-д хуульд өөрөөр заагаагүй бол Байнгын хороо нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон дүрэм, журам батлахгүй гэж хуульчилсан. Гэвч дээрх зохицуулалтын "хуульд өөрөөр заагаагүй" гэсэн зохицуулалт нь нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг хуулиар зөвшөөрсөн тохиолдолд УИХ-ын Байнгын хороо гаргаж болохоор заасан нь хууль тогтоох онцгой бүрэн эрхийг 126 гишүүнээс бүрдэх УИХ-д хадгалах, засаглалын аливаа эрх мэдлийг харилцан хяналттай байх Монгол Улсын Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал, зарчим алдагдах болон хууль ёсны эрх ашиг нь хөндөгдсөн тохиолдолд шүүх эрх мэдлийн байгууллагад хандах иргэдийн эрх зөрчигдөх зэрэг сөрөг үр дагаврыг үүсгэхээр байна.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсруулсан бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол УИХ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол УИХ-ын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс /ХЭҮК/-ийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсрууллаа. Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг дэмжиж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүнд баярлалаа. Хууль санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү? О.Номинчимэг гишүүнээр тасаллаа. Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

О.Номинчимэг: Энэ хуультай танилцлаа. 2 асуудал байна. 1 дүгээрт, яах вэ хууль тогтоомжийн хуулийг хөндөөд орж ирж байгаа, гэхдээ харах юм бол дотоод нэгж гэдэг утга дээр бол зөвхөн Байнгын хорооны асуудал байгаа. Тэгэхээр 1 дүгээрт, техникийн хувьд яагаад заавал Хууль тогтоомжийн тухай хууль дээр ийм юм оруулж өгсөн юм бэ? Эсвэл зүгээр л Монгол УИХ-ын тухай хуулиасаа "хуульд өөрөөр заагаагүй бол" гэдэг юмаа хасаад л ороод ирэхэд энэ асуудал чинь цэгцрэхээр байгаа шүү дээ. Тэгээд энийг заавал Хууль тогтоомжийн тухай хууль дээр нэмэлт заалт оруулж байж ингэх, надад бол техникийн болон учир холбогдол байхгүй байгаад байгаа юм. Дагуулж орж ирж байгаа асуудлууд ч гэсэн дандаа УИХ-тай Байнгын хороо баталж байгаа асуудалтай холбоотой. Ер нь бол зарчмын хувьд Байнгын хорооноос ийм юм баталж болохгүй гэдэгтэй бол санал нэг байгаа. Хууль тогтоомжийн хуулийг хэлэлцэж байх үед энэ байр суурийг илэрхийлж байсан. Гэхдээ техникийн хувьд Хууль тогтоомжийн тухай хууль дээр нэмэлт ийм заалт оруулалгүйгээр УИХ-ын тухай хуулийн 22.5-ыг хөндөөд энийг бол оруулаад ирэх бүрэн боломжтой байсан гэж харж байгаа юм.

2 дугаартаа, энэ дагаж орж ирж байгаа тэр УИХ, Байнгын хороонд өгсөн эрхүүдийг нь бүгдийг нь УИХ болгож байгаа юм. Тэгээд ингээд яг энэ зарчмаар харах юм бол зарим нь дутуу юм шиг харагдаад байгаа байхгүй юу. Одоо жишээ нь, манай ХЗБХ дээр Шүүхийн ерөнхий зөвлөл /ШЕЗ/-ийн шүүгч бус гишүүнийг сонгон

шалгаруулах журмыг саяхан баталсан, адилхан сонгон шалгаруулалттай холбоотой хэм хэмжээ тогтоосон ийм журам байгаа. Тэгээд Төрийн албаны зөвлөл /ТАЗ/-ийн энэ асуудал эд нарыг нь бүгдийг нь оруулж ирсэн мөртөө тэр нь хаягдчихсан байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр алин дээр нь ХЗБХ Байнгын хороо ийм журмаа гаргаад, алин дээр нь болохгүй байх гэдэг ялгаа зааг ер нь гаргаж ирж байгаа юм уу, эсвэл бүгдээрэнг нь өөрчлөх гэж байгаа тэр асуудлуудыг хаягчаад байна уу л гэдэг ийм 2 тодорхой асуулт байна.

Ер нь захиргааны хэм хэмжээний актыг дотоод бүтэц ер нь бол гүйцэтгэх засаглал дээр гаргана гэдэг ерөөсөө байхгүй шүү дээ. Захиргааны ерөнхий хууль дээрээ ч гэсэн тэр нь байгаа юм. Тэгэхээр энэ чинь угаасаа зөвхөн УИХ, түүний нэгж болж байгаа Байнгын хороотой холбоотой асуудал байгаа. Тэгэхээр Хууль тогтоомжийн тухай хууль бол дахиж ийм заалт гэхээсээ илүү зүгээр УИХ-ын тухай хуулийнхаа 22.5-ыг өөрчлөөд, дагаад л эд нарыг нь өөрчлөөд явчих боломжтой гэж харж байгаа гэж хэлмээр байна. Энэ 2 асуултад хариулт авъя.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Яах вэ ер нь яагаад Хууль тогтоомжийн тухай хууль дээр хийж байна гэдэг бол нийтлэг зохицуулалт. Зөвхөн УИХ дээр яах вэ практик нь тогтоод байгаа гэвэл үнэн. Гэхдээ зарим өнгөрсөн үеүдэд байсан тохиолдлууд бий. Тодорхой яамны газрын дарга батлах байдлаар хүртэл журам, эрх мэдэл шилжүүлж байсан байхгүй юу. Энэ бол засагдаж байсан. Тэгэхээр ер нь зүгээр цаашдаа ийм нөхцөл байдлууд гарахыг бас үгүйсгэхгүй учраас нийтлэг байдлаараа зохицуулалт нь Хууль тогтоомжийн тухай хууль дээр байгаа. Хууль дээр захиргааны хэмжээний актыг батлах эрхийг шилжүүлэхдээ ямар нийтлэг тавигдах шаардлагууд байх вэ гэдгийг зохицуулж өгсөн. Өөрийн чинь өргөн барьсан тэр хуулийн төсөл дээр энэ зохицуулалтууд нь орж ирсэн байхгүй юу. Тийм учраас Захиргааны ерөнхий хууль дээр биш шүү. Тийм учраас энэ дээр оруулж ирэхээс өөр аргагүй болсон. Тэгэхээр энэ дээр 1 дүгээрт үндэслэл байгаа. Энэ дээр ямар, ямар асуудлууд дээр өнгөрсөн хугацаанд яригдсан уу, үгүй юү бүгд мэдэж байгаа шүү дээ. Ийм, ийм асуудлуудыг эрх олгосон шилжүүлэх хаалтад заавал тусгана гээд. Тэгэхээр энэ боловсруулах процессоосоо эхлээд хязгаарлалтыг нь тавьж өгье гэдэг байдлаар 1 дүгээрт орж ирж байгаа юм.

2 дугаарт Шүүхийн хууль энэ тэрийг бол УИХ-ын гишүүд санаачлах нь зохимжгүй гэж үзэж байгаа. Энийг энэ хуулийн дагуу тодорхой хэмжээнд тэр журам, нөхцөл байдлуудаа үзээд, ЗГ нь яг зохих журмын дагуу оруулж ирээсэй гэж хүсэж байгаа. Шүүхийн хууль дээр ч зарчим барьж байсан. Шүүхийн хуулийг гишүүд бол өргөн барихгүй, энийг нь бол ЗГ тодорхой саналуудыг нь авч орж ирнэ гэдэг энэ зарчмын дагуу үлдээсэн байгаа. Энийгээ бол тодорхой хууль тогтоомжид нийцүүлээд оруулж ирэх байх гэж бодож байгаа.

Д.Цогтбаатар: О.Номинчимэг гишүүн тодруулъя.

О.Номинчимэг: Тэгэхээр хар даа, нийтлэг зохицуулалт хийх гэж байгаа бол Захиргааны ерөнхий хууль дээр энийгээ оруулж өгөх ёстой байхгүй юу. Тэнд чинь угаасаа зохицуулчихсан байдаг. Тэгээд захиргааны хэм хэмжээний актыг хэн гаргаж болох вэ, болохгүй вэ гэдэг юман дээр үнэхээр дотоод нэгжид хориглоно гэдэг нийтлэг зохицуулалт хэрэгтэй байна гэвэл Захиргааны ерөнхий хууль дээр орж ирэх ёстой, Хууль тогтоомжийн тухай хууль биш байхгүй юу.

Хууль тогтоомжийн тухай хуулиар чинь хуулиар бид захиргааны хэмжээний эрх олгох гэж эрх олгох гэж байгаа бол ямар хэмжээ хязгаар дээр байх вэ л гэдэг асуудал байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр нөгөө асуудал нь зөв боловч хууль зүйн техникийн хувьд Хууль тогтоомжийн тухай хууль дээр биш өөр юман дээр орох ёстой, эсвэл шууд УИХ-ынхаа хуулийн 22.5-ыг хөндөөд л оруулаад ирэх ёстой байсан юм байна гэсэн миний байр суурь байгаад байна. Тэгээд ТАЗ юунуудыг нь хөндчихөөд, шүүхийнхийг нь болохоор үлдээчихээд байдаг, одоо энийг нь тэгэхээр яах ёстой вэ гэдэг асуудал бас гараад байх шиг байна шүү дээ. Тэгээд нэг мөр энэ дээрээ Байнгын хороо ийм захиргааны хэм хэмжээний нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний акт баталж байхгүй гэх юм бол ШЕЗ-ийн журам маань байхгүй болчихоод байдаг, тэгвэл энэ дээр ажлын хэсэг гарч байгаа. Нөгөө сонгон шалгаруулалт.../минут дуусав/

Д.Цогтбаатар: О.Номинчимэг гишүүн гүйцээгээд хариулъя.

О.Номинчимэг: Сонгон шалгаруулалт явж байгаа нөгөө маань зөвхөн хуулиа барьж ажиллах гээд байдаг гэх мэтчилэн юмнууд байгаа болохоор би зүгээр дагаж орж ирсэн зүйлүүдийг нь харахаар үнэхээр яг ийм журмуудаа бүгдийг нь цэгцэлье гэж байгаа бол тэрийгээ оруулаад ирэхгүй, Шүүхийн тухай хууль дээрээ хөндөөд оруулаад ирэхгүй яав даа гэсэн тийм байр суурь байгаад байна л даа.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүн хариулах уу?

П.Сайнзориг: Хариулъя. Номинчимэг гишүүний хэлж байгаа Захиргааны ерөнхий хуулийг баталсан хуулийн дагуу захиргааны хэмжээний актыг батлаад, тэрийг улсын бүртгэлд бүртгүүлээд дагаж мөрдөх харилцаа Захиргааны ерөнхий хууль дээр байгаа. Энэ анхнаасаа боловсруулах түвшинд эрх олгож шилжүүлэх актыг байгууллагын дотоод нэгжид шилжүүлж болохгүй гэж байгаа учраас Хууль тогтоомжийн тухай хуульд оруулж ирж байгаа юм анхнаасаа. Нэгэнт баталж явуулчихсан хойно Захиргааны ерөнхий хуулиар хориглоод нэмэргүй байхгүй юу. Хууль тогтоомжийг Хууль тогтоомжийн тухай хуулиар барьж боловсруулдаг учраас гээд явчихна. Тийм учраас та бид 2-ын зөрөх юм байхгүй. Хууль тогтоомжийн тухай хуулийн 27¹ дээр хуулийн төсөлд захиргааны хэмжээний акт батлах эрх олгох зохицуулалтад тусгахад тавигдах шаардлага гээд та өөрөө оруулчихсан байхгүй юу даа, Цогтбаатар гишүүн санаачлаад, Номинчимэг гишүүн ахлаад. Тэгэхээр энэ дээр анхнаас нь санаачлах буюу томъёолж орж ирэхдээ дотоод.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Х.Баасанжаргал гишүүн. Надад нэг асуулт байгаа юм. Энэ хууль тогтоомжийн хуулийг өөрчлөх үеийн яг энэ журмуудыг ер нь цэгцэлье гэдэг энэ санаатай бол энэ нийцэж байна, би тийм учраас энийг дэмжиж байгаа юм.

Харин П.Сайнзориг гишүүнээ, миний нэг болгоомжилж байгаа юм УИХ-ын хүрээний асуудал нь сая Номинчимэг гишүүн миний асууя гэж байсныг асуучихлаа. Наадах чинь өөр яам, тамгын газар дээр очоод бас энэ журамтай холбоотой, бид нар чинь ингэж байгаа шүү дээ, журмыг цэгцэлье гэдэг нь хуулиар тодорхой мандат олгочихсон бол өөрөөр хэлбэл журам гаргахгүй гээгүй, журмын эсрэг хууль биш байхгүй юу. Журмыг бол гаргахгүй бол болохгүй шүү дээ. Журмыг гаргахдаа тэр хуулиар олгосон мандаттай бол гаргана гээд тэгж байгаа шүү дээ. Тэгтэл одоо өөрийн чинь энэ ярьж байгаагаар зарим агентлагууд эд нар дээр энэ журам гаргахтай холбогдсон, тэрийг нь аваачаад яам руу шилжүүлж байгаа юм уу? Би бас

гүйцэд ойлгоогүй байж магадгүй. Тэгэхээр нөгөө агентлаг дээр зүй ёсоор гарах ёстой байсан юуг нь бүр аваачаад төвлөрүүлээд, яамны түвшинд юм уу авааччихаж байгаа тийм асуудал байгаа юу, байхгүй юу?

П.Сайнзориг: Цогтбаатар даргын асуултад хариулъя. Байхгүй. Хуучин бол нөгөө ЗГ-ын тогтоолоор явж байхад их замбараагүй байсан юм. Байгууллагын дотоод нэгж рүү шилжүүлдэг, Төрийн захиргаа, удирдлагын газар нь батална ч байдаг юм уу, эсвэл тийм нэгжийн дарга нь батална гээд ийм байсан. Бид хэд Захиргааны ерөнхий хуулийг мөрдүүлээд ерөнхийдөө цэгцтэй болгож өгсөн юм. Тухайн яамны сайд нь л хариуцлагаа хүлээгээд гаргаж байгаа шүү дээ. Тэгээд бүртгүүлнэ. Тэгэхээр энэ хууль батлагдсанаар агентлагт байгаа юмыг яам руу ч юм уу татах зүйл биш. Агентлаг ч гэсэн бие даасан хуулийн этгээд учраас энэ Захиргааны ерөнхий хуулийн үйлчлэл нь захиргаа гэж үзэж байгаа учраас бие даагаад журам батлах эрхтэй.

Одоо яг нөгөө нэг манай Байнгын хороо жишээ нь хуулийн этгээдийн эрхгүй байхгүй юу. Тэгсэн мөртөө ингээд дүрэм, журмуудыг батлаад байдаг. Энэнээс иргэдийн эрх ашиг хөндөгдөнгүүт лавлагаа мэдээлэл өгөх албан ёсны юм байхгүй, зохицуулалт байхгүй. Дээрээс нь Байнгын хорооны шийдвэрийг захиргааны шүүх ч өгч болдоггүй, Цэцэд ч өгч болдоггүй ингээд иргэдийн эрх зөрчигдөөд байвал хаана хандах вэ гэдэг Үндсэн хуулийн суурь зарчим алдагдаад байгаа юм. Тэгэхээр энэ Захиргааны ерөнхий хууль, хууль тогтоомжийн ерөөсөө суурь зарчим чинь л тэр байгаа, шүүхийн мэдлийн хяналтад байх. Тэгэхээр УИХ-ын шийдвэр өөрөө Цэцийн хяналтад байгаа. Тэгээд УИХ-аас эрх олгосны дагуу баталж байгаа захиргааны хэмжээний актууд чинь ихэнх нь бол захиргааны шүүхийн хяналтад, зарим нь одоо магадгүй ЗГ, Ерөнхийлөгчийн баталж байгаа, сайд нарын баталж байгаа зарим юм бол Цэцэд хянагдах ч хүртэл боломжтой байж байгаа. Тэгэхээр энэ хүрээндээ одоо асуудлуудыг иргэн талдаа, хүний эрхийг хамгаалах талдаа л боловсруулж нэг талд нь гаръя, энэ явж ирж байгаа практикийг нэгмөсөн цэгцэлчихье гэдэг байдалтай байгаа юм.

Д.Цогтбаатар: Ойлголоо. Хууль санаачлагчаас асуух асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгье. Байхгүй байна. Шууд Байнгын хороог төлөөлөөд хариулчихдаг гишүүнтэй болсон байна. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд үг хэлэхгүй.

Гишүүд санал хураалтад бэлдье. Санал хураалаа гээд дуудчих, одоо гялс, энэ чинь нэлээн хэдэн санал хураалт байна шүү. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Ингээд түрүүн үг хэлж дууссан тул одоо санал хураалтдаа орно.

1.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Батлут гишүүний микрофоныг өгье.

Д.Батлут: Саяын санал хураалтыг хүчингүй болгож, ахин санал хурааж өгөхийг хүсье. Сая би хуруугаа уншуулаад санал хураалтад бэлтгэж амжаагүй байсан байна.

Д.Цогтбаатар: Саяын Батлут гишүүний горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 55 хувиар санал дэмжигдлээ. Түрүүн уншиж танилцуулсан томьёоллыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 55 хувиар санал дэмжигдлээ.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 55 хувиар санал дэмжигдлээ.

3.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 55 хувиар санал дэмжигдлээ.

4.Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 55 хувиар санал дэмжигдлээ.

5.Монгол УИХ-ын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 55 хувиар санал дэмжигдлээ.

6.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 55 хувиар санал дэмжигдлээ.

7.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 55 хувиар санал дэмжигдлээ.

8.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 55 хувиар санал дэмжигдлээ.

9.Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Энэ уначихлаа шүү дээ. Одонтуяа гишүүний микрофоныг өгье.

С.Одонтуяа: Горимын санал гаргах гэсэн юм. Саяын санал хураалтыг хүчингүй болгож өгөөч. Би дарсан чинь энэ эсрэг гарчихлаа.

Д.Цогтбаатар: Саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн С.Одонтуяа гишүүний горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 55 хувиар санал дэмжигдлээ. 9.Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 55 хувиар санал дэмжигдлээ.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд УИХ-ын гишүүн Тулга танилцуулна.

16.42 цаг

Гурав.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин нарын 6 гишүүн 2026.04.30 -ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалдаа оръё. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /ЭХХШТХ/-д нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, УИХ-ын гишүүн Энхтүвшин нарын 6 гишүүн 2026 оны 04-р сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж эхэлье. Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол УИХ-ын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин танилцуулна. Энхтүвшин гишүүнээ, 10 минутад багтааж танилцуулахыг хүсэж байна. Энхтүвшин гишүүний микрофоныг өгье.

Д.Энхтүвшин: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

ЭХХШТХ-д нэмэлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын гишүүн Соронзонболд, Алтангэрэл, Уянгахишиг, Пүрэвдаваа, Батболд, Энхтүвшин нарын 6 гишүүн 2026 оны 04-р сарын 30-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн. Манай улс 2014 оноос өмнө зөвхөн хувь хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байсан бол 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах зарчмыг анх хуульчилсан.

Улмаар 2017 оны ЭХХШТХ-ийн зорилгод гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах гэж тусган, мөн хуулийн 20 дугаар бүлгээр хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой тусгайлсан бүлэг оруулж, хуулийн этгээдийн гэм бурууг тогтоож, түүнд эрүүгийн хариуцлага оногдуулах асуудал процессын хувьд тодорхой хэмжээнд зохицуулагдсан. ЭХХШТХ-д хэргийн оролцогч гэж сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч хуулийн этгээд, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг хэлнэ гэж заасан бөгөөд хуулийн этгээдийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс хэргийн оролцогчийн хувьд ялгамжтай авч үзсэн.

Хэдий тийм боловч ЭХХШТХ-д сэжигтэн, яллагдагчид хамаарах зарим зохицуулалтыг хуулийн этгээдэд нэгэн адил хэрэглэх байдлаар ерөнхийлөн тусгасан нь хуулийн этгээдийн онцлогт тохирсон журам бүрэн тусгагдаагүй. Тэдгээрийн нэг нь хуулийн этгээдэд авах таслан сэргийлэх арга хэмжээний зохицуулалт юм. Түүнчлэн мөрдөн шалгах ажиллагааны журамд ч хуулийн

этгээдийн субъектийн онцлогт тохирсон нарийвчилсан зохицуулалт дутмаг байна. Тодруулбал, ЭХХШТХ-д заасан хуулийн этгээдэд тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг нь түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авахтай холбоотой журамд таслан сэргийлэх арга хэмжээ авахад харгалзах нөхцөл, хугацаа, үндэслэл, таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгох, хугацаа сунгах журам зохицуулагдаагүй байна.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад хуулийн этгээдэд голчлон хийгддэг ажиллагааны нэг бол хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах ажиллагаа юм. Гэвч эдгээр ажиллагааг хэрэгжүүлэх нөхцөл, шаардлага, хугацааны зохицуулалт мөн л тодорхой бус байна. Бизнесийн байгууллагуудын хувьд үйл ажиллагаа түр зогсох, доголдол, тасалдал үүсэх зэрэг тохиолдолд жижиг бизнесүүд санхүүгийн дарамт, эрэлт буурах зэрэг хамгийн хурдан буюу дунджаар 1-3 сарын дотор хямралд ордог бол, дунд, том бизнесүүдийн хувьд 3-6 сарын дотор санхүү, үйл ажиллагааны хүндрэл мэдрэгдэж улмаар дампуурах хүртэл эрсдэлд ордог талаар судалгаанууд бий.

Иймд энэ үр дагаварт хүргэж болзошгүй хуулийн этгээдийн үйл ажиллагааг түдгэлзүүлэх, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах зэрэг арга хэмжээ авахдаа хуулийн этгээдэд үзүүлэх үр нөлөөг харгалзан үзэж, эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжих үүднээс хуульд шалгагдах журмын зохицуулалтыг оновчтой болгох зайлшгүй шаардлагатай байна. Процессын тодорхой байдлыг хангах нь Монгол Улсын Үндсэн хууль болоод ЭХХШТХ-ийн зарчимд бүрнээ нийцэх ба хэм хэмжээний бус байдлаар иргэн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулахаас урьдчилан сэргийлэх, шударга шүүхээр шүүлгэх эрхийн биелэлтийг хангах суурь болно. Энэ зорилгоор Монгол Улсын ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг баталгаажуулж, шүүхийн шийдвэргүйгээр баривчлах, цагдан хорих, иргэний эрхийг хязгаарлах ажиллагааг зогсоон, хүний эрхийг хамгаалах, процессын шударга ёсыг хангах, мэргэжлийн байлгах чиглэлд ЭХХШТХ болон бусад холбогдох хуулиудыг бүрэн процессжуулан хуульчлахаар тусгасан.

Түүнчлэн Монгол Улсын ҮХЦ 2025 оны 07-р сарын дүгнэлтээр цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний талаар авч хэлэлцэхдээ хүний эрхийг хязгаарлах зохицуулалтын үндэслэл, журам хуульд тодорхой тусгагдаагүйгээс төр хуулийн процессыг тодорхой болгох Үндсэн хуульд заасан үүргээ биелүүлээгүй байна гэж дүгнэсэн. Эдгээр шаардлагыг үндэслэн ЭХХШТХ-д нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд дараах нэмэлтийг оруулахаар хуулийн төсөлд тусгалаа.

1 дүгээрт, хуулийн этгээдэд тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авахад харгалзах нөхцөл, хоёрдугаарт, хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авах үндсэн болон нэмэлт нийт хугацаа, гуравдугаарт, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах мөрдөн шалгах үйл ажиллагааг явуулахдаа харгалзах нөхцөл.

ЭХХШТХ-д нэмэлт оруулах хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдэд таслан сэргийлэх арга хэмжээ авах, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах ажиллагаанд харгалзах нөхцөл, хугацаа тодорхой болох бөгөөд ажиллагааны процессыг хуульчилснаар хуулийн этгээдийн шударга шүүхээр шүүлгэх эрх, процессын тодорхой байдал, пропорциональ зарчмыг хангах суурь болно. Нөгөө

талаас эдийн засгийн гол хөшүүрэг болсон хувийн хэвшил, бизнесийн байгууллагуудын тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, цаашлаад энэ нь хууль зүйн орчны тодорхойгүй байдлыг бууруулж, Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалт татах зэрэг нийгэм, эдийн засгийн эерэг үр дагавартай гэж үзэж байна.

УИХ-ын гишүүд ээ, ЭХХШТХ-д нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгнө үү. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Энхтүвшин гишүүнд баярлалаа. Хууль санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуух асуулттай гишүүд байвал нэрээ өгнө үү. Х.Баасанжаргал гишүүнээр тасаллаа. Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Хууль тогтоомжийн тухай хуульд өөрчлөлт ороод цаашид энэ эрүүгийн процесстой холбоотой энэ хуулийн өөрчлөлт дээр Улсын дээд шүүх болон Улсын ерөнхий прокурор /УЕП/-ын саналыг авах тухай заалт байгаа. Тэгээд бидэнд өгсөн яг энэ хуулийн төслийн хамт өргөн мэдүүлж байгаа материалууд дотор тэр материал байхгүй байсан. Тэгээд би сая яах вэ авч уншлаа. УЕП-ын энэ татгалзаж байгаа санал болоод Дээд шүүхийн бас яг гаргаж байгаа саналууд дээр та бүхэн ямар байр суурьтай байгаа вэ? Аль, аль нь ер нь бол татгалзсан ийм санал өгсөн байна гэсэн ийм асуулт байна.

Д.Цогтбаатар: Энхтүвшин, хэн хариулах вэ? Ажлын хэсэг, 3 дугаар микрофон.

Б.Батбаяр: УЕП болон Улсын дээд шүүхээс ирсэн саналуудтай танилцсан. Үүнтэй холбоотой зарим хэсэг дээр энэ хуулийн төсөл дээрээ өөрчлөлт оруулаад явсан байгаа. Тухайлбал, ЭХХШТХ-ийн 26.1, 2 дээр байгаа, байсан 6 сарын хугацааг УЕП-оос авсан саналын хүрээнд өөрчилсөн. Дээд шүүхээс тодорхой санал ирээгүй, ер нь бол санал өгөхгүй гэдэг ийм байр суурь илэрхийлсэн гэж ойлгосон, ийм байгаа.

Д.Цогтбаатар: Баасанжаргал гишүүний микрофоныг өгье, тодруулъя.

Х.Баасанжаргал: Дээд шүүхийн татгалзсан шалтгаан нь их тодорхой биччихсэн байсан шүү дээ. Нөгөө хуулийн төсөл өөрөө түүхий байна, тэгээд судалгаа, дүн шинжилгээ дутуу байна, үзэл баримтлал нь тодорхойгүй байна гээд татгалзсан санал дээрээ биччихсэн байсан. Тэгээд яг энэ татгалзсан үндэслэлүүд нь арилсан уу л гэж би асуугаад байгаа гэсэн үг.

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон, ажлын хэсэг хариулах уу? 3 дугаар микрофон.

Б.Батбаяр: Дээд шүүх болон УЕП-оос ирсэн саналууд дээр ерөнхийдөө бид ажилласан. Ажиллаад тодорхой саналуудыг, хариултуудыг бол ер нь өгсөн. Үзэл баримтлал, танилцуулга, судалгааны энэ юун дээр хуулийн төсөл дээр хийсэн судалгаануудаа үүн дээрээ дурдаж өгсөн байгаа. Тэгэхээр бид ер нь тодорхой бэлдсэн, процессын тодорхойгүй байдлыг тодорхой болгоё гэдэг энэ зарчмын байр сууриа илэрхийлээд, процесс хуулийн 14.4.4-т байгаа энэ ямар ч зохицуулалтгүй орхичихсон хэсгүүдийг зохицуулах шаардлагатай. Хуульд зарчмын ямар нэгэн

нэмэлт, өөрчлөлт оруулахгүй, гагцхүү энэ тодорхой бус орхичихсон байгаа хэсгүүдийг илүү тодорхой болгоё л гэдэг ийм зүйлийг бичиж өгсөн байгаа.

Д.Цогтбаатар: Гишүүд асуулт асууж дууслаа. Надад нэг асуулт байгаа юм. Энэ хуулийг зарчмын хувьд би дэмжиж байгаа, энэ маш зөв хууль оруулж ирж байна. Харин зүгээр энэ чинь нөгөө Хууль тогтоомжийн тухай хууль баталчихсан байж байгаа шүү дээ. Тэрний дагуу энэ чинь нөгөө хүний эрхийг, уг хууль нь өөрөө та нар хязгаарлаж байгаа хуулийг улам харин одоо бизнесүүддээ тохируулж сайжруулж өгч байгааг чинь ойлгож байна, оруулж ирж байгаа санал чинь.

Гэхдээ хууль чинь өөрөө тэр эрхийг хязгаарлаж байгаа хууль байхгүй юу. Тэгэхээр үүн дээр нөгөө Хууль тогтоомжийн тухай хуульд бол аливаа нэгэн эрхийг хязгаарлаж байгаа, ялангуяа хүний эрхийг хязгаарлаж байгаа хууль орж ирэх юм бол Хүний эрхийн комиссоос заавал нөгөө бүрдүүлбэрт нь санал авдаг байх ёстой байгаа. Тэгэхээр та нар энэ хууль тогтоомжийн хуулийнхаа дагуу ХЭҮК-оос санал авсан уу? Энэ бүрдүүлбэр дээр би харахгүй байна л даа. Тэгээд та хэд маань ингэж бодож байж магадгүй, энэ хүний эрхийн биш нөгөө ААНБ-ын тухай гэж тухайн үедээ бодсон байж магадгүй. Гэтэл энэ чинь нөгөө олон улсын, нийгмийн болон эдийн засгийн, соёлын эрхийн тухай фактын чинь дагуу энэ жинхэнэ тэрэнд хамаарагдаж байгаа хүний эрхийн асуудал байхгүй юу. Эдийн засгийн эрхийнх нь тухай асуудал. Тэгэхээр тэрэн дээр та нар тэгж ойлгож, Хүний эрхийн комиссоосоо санал авсан уу? 4 дүгээр микрофон, өөрийгөө танилцуулаарай.

Б.Эрхбаяр: Хуульч Эрхбаяр. ХЭҮК-оос санал авсан, яг бичгээр тэр тодорхой саналыг нь би сайн санадаггүй. Бас хэлэлцүүлэг, тийм авсан. Энэ дээр хэлэлцүүлэг хийсэн. ХЭҮК, Өмгөөлөгчдийн холбоо, Хуульчдын холбоо гээд, тэр дээр болохоор ХЭҮК-оос бол яг энэ хуулийн төслийг дэмжиж байгаа гэдэг саналаа өгч байсан.

Д.Цогтбаатар: Ер нь бол Энхтүвшин гишүүнээ, энийгээ гүйцээгээд та нар тэгвэл бичгээр, одоо тэр уулзалт хийгээд авсан байна шүү дээ, тэрийгээ бичгээрээ авч нөгөө бүрдүүлбэртээ гүйцээгээрэй. Яагаад гэвэл тэр хуулийнхаа шаардлагыг, эрх зүйн шаардлагыг хангасан байх ёстой шүү. Ингээд хуулийн төслийн үзэл баримтлалд, асуулт асууж, хариулт авч дууслаа гишүүд. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгье. Амарсайхан гишүүнээр тасаллаа. Амарсайхан гишүүнийг оруулаарай. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Яах вэ, хэлэлцэх эсэхийг нь шийдээд дэмжээд явъя. Би ч түрүүн харсан, жоохон боловсруулалт нь тийм байна лээ. Сая Баасанжаргал гишүүн ч асуугаад байна. Уг нь бол дэмжсэн, дэмжээгүй саналаа зүгээр л ил тод сайхан тайлбараа л биччих ёстой байхгүй юу, нуугаад л, шинэ залуучууд л байх шиг байна. Ер нь бол яг тайлбар. Би ч гэсэн энэ Хууль тогтоомжийн тухай хууль дээр жишээ нь яасан шүү дээ, Захиргааны ерөнхий хууль дээр боловсруулаад санал аваад ЗГ дэмжээгүй, ЗГ-ын саналыг аваад л хасчихсан байхгүй юу, ялгаагүй. Тэгэхээр ийм тайлбаруудаа өгч сурахгүй бол ингээд гишүүдийгээ эвгүй байдалд оруулаад, авсан тэгээд хийсэн гээд. Тэр юуг чи одоо энэ саналыг, Дээд шүүхээс авсан саналыг энд хавсаргаж ирүүлээгүй, эндээ ширээн доогуураа хийснээрээ нэг их асуудал шийдэх гээд байгаа юм байхгүй шүү дээ. Тэгэхээр ийм зүйлүүд байна.

Би тэгээд Байнгын хороон дээр өөр хэд хэдэн ийм процессын хууль байгаа байх, тийм ээ? Тэмүүжин гишүүн нарын эрүүгийн хууль, эрүүгийн процесс байгаа,

өөр бас ямар гишүүдийнх байна. Ингээд нэгтгээд нэг ажлын хэсэг гаргаад, уялдуулж харахгүй бол маш олон жижиг ажлын хэсгүүд явах бол энэ процессын хуулиуд хэцүү шүү л гэж хэлэх гээд, нэгтгэж хэлэлцье л гэсэн ийм байр суурьтай байна. Тэгэхээр Энхтүвшин гишүүн дэмжиж байвал, өөр чинь одоо процессын хууль дангаараа орж ирсэн, Тэмүүжин гишүүнийх чинь Эрүүгийн хуулиа дагасан уу, дангаараа байсан бил үү, би сайн одоо мартчихаад байна, уучлаарай. Тэгээд тэр байвал ингээд нэгтгээд хэлэлцээд, уялдааг нь хангаад явъя гэсэн ийм зүгээр зарчмын байр суурьтай байна, нэгтгэж хэлэлцье л гэсэн үг.

Д.Цогтбаатар: Амарсайхан гишүүний микрофоныг өгье.

С.Амарсайхан: Хууль санаачлагчийн энэ хуулийн зорилго, санааг үгүйсгэхгүй байгаа. Гэхдээ хэд хэдэн анхаарах асуудлууд байгаад байгаа. ХЗДХЯ-наас 4 санал өгсөн. Ялангуяа одоо энэ хуулийн этгээдийн эрх, хөрөнгө, үйл ажиллагааг хязгаарлах зохицуулалт нь хэт ерөнхий байна гэдэг, бас зарим зүйлүүд тодорхойгүй байгаад байгаа. Ялангуяа бизнесийн болон гуравдагч этгээдүүдийн энэ эрхийг хязгаарлах, сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлүүд бас байна гэж үзэж байгаа юм. Яах вэ бид одоо ингээд 930 гаруй хууль байна. Тэгээд хуулийн хэрэгжилтүүд хангагдахгүй байгаа, процесс нь тодорхойгүй байгаа. Өнөөдөр хүртэл процесс нь батлагдаагүй маш олон хууль тогтоомжууд, хэрэгжилт хангагдахгүй, хийдэл, давхардлууд маш их байгаа учраас энэ хуульд, энэ дундаа энэ Эрүүгийн хууль, энэ бусад иргэний хуулиудтай холбоотой өөрчлөлтийг хийхдээ нэлээн нухацтай бөгөөд уялдуулж, дээрээс нь тал талын санаа оноогоо нэгтгээд, олон талаас өргөн барьж байгаа хуулиудыг ялангуяа УИХ дээр бид нэгтгэж хэлэлцэх нь зүйтэй байна гэж үзээд байгаа. Тэгээд манай яамнаас энэ хуулийн этгээдийн эрхийг 1 дүгээрт хязгаарлах үндэслэл хэт ерөнхий байна гэдэг 1 дүгээр саналыг өгсөн байгаа.

2 дугаарт, энэ хөрөнгө орлогын хөдөлгөөнийг хязгаарлах зохицуулалт хэт өргөн байна гэж. Өөрөөр хэлбэл энэ ААН-үүдийн үйл ажиллагааг хязгаарлах, тэр нь ойлгомжгүй, зохицуулалтгүй байдгаас үүдээд өнөөдөр хэлмэгдүүлэлт их явдаг, хууль хэрэгждэггүй, хуулийн нугалаа гардаг, хууль хэрэгжүүлэх нэрээр иргэн, ААН-үүдийн үйл ажиллагааг хэт удаан хугацаанд зогсоодог, битүүмжилдэг, түүнээс болоод алдагдалд ордог, хохирдог, дампуурдаг, эргээд эзэн байдаггүй ийм нөхцөл байдлууд байдаг.

3 дугаарт, энэ мөрдөн шалгах үйл ажиллагааны хугацаа сунгалтын зохицуулалт тодорхой бус байна гэдэг ийм саналуудыг өгсөн.

4 дүгээрт, энэ хуулийн төсөл хууль тогтоомжийн хэлбэр бүтэц, найруулгын шаардлагыг бүрэн хангах хэрэгтэй байна гээд. Ажлын хэсэгт ийм 4 агуулгатай, тэгээд нарийвчилж яривал цаг хугацаа их авах гээд байгаа учраас би ерөнхийд нь ингээд манай ХЗДХЯ-наас өгсөн саналыг 1 дүгээрт Энхтүвшин гишүүн анхаараарай нэгд. 2-т бол Сайнзориг гишүүний хэлсэн шиг ингээд нийлүүлээд хамтатгаад, ингээд нэг мөр засаад явчихвал илүү үр дүнтэй байх гэсэн ийм саналтай байгаа шүү.

Д.Цогтбаатар: Гишүүд үг хэлж дуусаж байна. Би нэг товчхон юм хэлчихье. Энхтүвшин гишүүнээ, ер нь бол нэг ийм бид байр суурь барьж байгаа, би хуулийг чинь дэмжиж байгаа, энэ бол зөв хууль орж ирж байна, тийм учраас би бол дэмжинэ.

Ер нь цаашдаа бол нэг юмыг анхаармаар байна, манай аль ч гишүүн. Эрүүтэй холбоотой асуудлуудыг ЗГ-аар оруулж, оруулж ирж байх ёстой шүү. Ялангуяа

процесстой холбоотой ийм асуудлуудыг. Түүнээс гишүүд өөрсдөө дангаараа яг Эрүүгийн хуулийг өргөн бариад яваад байх бол тийм их дэмжээд байх бол нээрээ жинхэнээсээ асуудал биш шүү. Энэ хуулийн чинь агуулга, үзэл баримтлал өөрөө зөв байгаа болохоор би дэмжье гэж байгаа юм.

2 дугаарт, тэр Хүний эрхийн комиссоос та нар саналаа гүйцээж аваарай. Танай бүрдүүлбэр дотор энэ нөгөө Хууль тогтоомжийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт чинь шинэ байгаа болохоор та нар гүйцэд тэрэнтэйгээ тулгаагүй ч байж магадгүй. Эдийн засгийн тооцоолол, энэ чинь бол аягүй амархан гарах эдийн засгийн тооцоололтой хуулийн санал байхгүй юу. Ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн давхарга, хэсгийн саналыг аваад, тэгээд тэрэн дээр эдийн засгийн тооцоолол заавал хийгдсэн байх ёстой гэж байгаа шүү дээ, тэр эд нар чинь энэ бүрдүүлбэр дотор байхгүй байгаад байна. Тэгэхээр хэлэлцүүлгийнхээ явцад энийгээ нөхөж та нар хийгээрэй, нөгөө бүрдүүлбэртээ бол заавал орох ёстой учраас.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Уянгахишиг гишүүн бэлэн болов уу?

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 66.7 хувиар санал дэмжигдлээ. ЭХХШТХ-д нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд УИХ-ын гишүүн Баярбаатар танилцуулна.

17.01 цаг

Дөрөв. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.03.18 -ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалдаа орёе. Мансууруулах эм, энэ чинь 4 дүгээр асуудал болчхож байгаа. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд, ЗГ 2026 оны 03-р сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх асуудал байна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол УИХ-ын гишүүн, ЗГ-ын гишүүн, ХЗДХ-ийн сайд Сайнбуянгийн Амарсайхан танилцуулна. 10 минутад багтааж сайдаа танилцуулаарай. Амарсайхан гишүүний микрофоныг өгье.

С.Амарсайхан: Минут хүрэхгүй. Эрхэм хүндэт ХЗБХ-ны дарга, гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой хөгжил, хүн амын удмын сан, иргэдийн амь нас, эрүүл мэндэд ноцтой аюул заналхийлэл учруулж буй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй

тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх эрх зүйн зохицуулалтыг шинэ шатанд гаргах зорилгоор боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгыг та бүхэндээ танилцуулж байна.

Монгол Улс 2002 онд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг анх баталсан. Энэ хуулийн дагуу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих эрх зүйн үндэс суурийг бүрдүүлж өнөөдрийг хүртэл төрдөж ирсэн. Гэхдээ өнгөрсөн хугацаанд нийгэм, эдийн засаг, технологийн хөгжил, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн арга хэлбэр эрс өөрчлөгдөж байна. Хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ, хууль бус эргэлт, тэдгээртэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийн гаралт тогтмол нэмэгдэж байгаа. Уг харилцааг зохицуулж байгаа эрх зүйн орныг зайлшгүй шинэчлэх шаардлагатай байна гэж үзсэн учраас энэ хуулийн төслийг боловсруулж танилцуулж байгаа.

Улсын хэмжээнд 2017-2025 онд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой 2100 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Нийт 2422 хүн холбогдож тэдгээрийн дийлэнх буюу 66, 86 гаруй хувийг 18-35 насны залуучууд эзэлж байгаа юм. Тэгээд энэ хугацаанд буюу 2017 оноос 2025 оны хооронд нийтдээ 2018 зөрчил бүртгэгдсэн байгаа юм. Энэ бол албан ёсны тоо бүртгэл. Гэхдээ энэ давхардсан тоо, албан бусаар бол нөхцөл байдал ихээхэн хүндрэлтэй зам руу орсон байгаа гэдгийг дурдах нь зүйтэй байна. Нийт 1976 хүн холбогдож хэрэгт холбогдож, зөрчилд холбогдогчдын ихэнх нь мөн залуучууд байгаа. 2025 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоо өмнөх онтой харьцуулахад гэмт хэрэг 20 гаруй хувиар, зөрчил 26.6 хувиар тус тус өссөн. Энэ төрлийн гэмт хэргийн гаралт тогтмол өсөх хандлагатай байгаагаас гадна хил дамнасан зохион байгуулалттай энэ мансууруулах эм, сүүлийн үеийн шинэ төрлийн мансууруулах бодис, хар тамхийг зөөвөрлөх, нийлүүлэх, хангах, хэрэглэх цар хүрээ улам нэмэгдэж байгаа. Ялангуяа Зүүн Өмнөд Азийн улс орнуудаас манай улс руу чиглэсэн томоохон зорилтот бүлэглэлүүдийн үйл ажиллагаа ихээхэн анхаарал татаж байгаа гэдгийг бас энд хэлье.

Үүнтэй холбоотойгоор хууль сахиулах байгууллагын ажлын хэсэг, холбогдох албад ажиллаж, бас сүүлийн үед үндэстэн, улс орон дамжсан энэ төрлийн гол бүлэглэлийн нийлүүлэгчид, худалдагчид, зохион байгуулагчид, далд эздийг олон улсын интерполын /Interpol/ шугамаар баривчлах, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлууд дээр анхаарал хандуулж ажиллаж байна. Сүүлийн жилүүдэд мансууруулах бодисын төрөл хэлбэр өөрчлөгдөж байгаа, ургамлын гаралтай бодисоос гадна синтетик /synthetic/ эм бодис болон бусад хэрэглэдэг эм бодисын хэрэглээ нэмэгдэх ийм хандлагатай болсон. Сүүлийн 2025 оны байдлаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, эм, ахуйн хий зэрэг бодисын хэрэглээний улмаас нийт 49 хүн нас барсан тохиолдол бүртгэгдсэн. Мөн хугацаанд 17 төрлийн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, урвуулан хэрэглэх эрсдэлтэй эм бодис их хэмжээгээр хураагдсан. Тэдгээрийг хэрэглээний тунгаар тооцох юм бол нийтдээ 510579 хүнд өөрөөр хэлбэл манай хүн амын бараг 30 хувьтай тэнцэхүйц хэмжээний хүн тунтай тэнцэх хэмжээний ийм бодисыг хурааж авсан байгаа.

Дээр дурдсан нөхцөл байдал, тулгамдсан асуудлыг харгалзан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээнд хяналт тавих, хууль бус хэрэглээтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоог илүү боловсронгуй болгох шаардлагатай

байна гэж хуулийн төслийг боловсруулсан бөгөөд хуулийн төсөлд дараах зохицуулалтыг тусгасан. 1 дүгээрт, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ангилал, жагсаалтыг дотооддоо тогтоодог болно. Энийг бид тогтоох ангиллыг нь хатуу хориглосон, хязгаарлалттай мөн хяналттай гэсэн энэ ангиллууд руу оруулах шаардлагатай байна гэж, хоёрдугаарт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой үйл ажиллагааг зөвхөн тусгай зөвшөөрлийн үндсэн дээр болон бусад тодорхой зохицуулалтын хүрээнд эрхэлдэг байх ийм зохицуулалтыг зайлшгүй хийх шаардлагатай байна гэж үзэж байгаа юм. Яагаад гэвэл одоо эмийн морфиноос эхлээд өвчин намдаах, мөн мэдээ алдуулагч тариа, бусад төрлийн эм, эмийн хэрэгслийг хяналтгүйгээр хэрэглэж байгаа ийм нөхцөл байдлууд тогтоогдож байгаа.

Гуравдугаарт, энэ төрлийн гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг илүү чангатгая гэж байгаа юм. Дөрөвдүгээрт, Эрүүгийн хуульд энэ төрлийн эм бодисын их хэмжээ, онц их хэмжээний шалгуурыг илүү тодорхой болгож тодотгох зайлшгүй шаардлагатай гэж үзэж байгаа юм. Тавдугаарт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, донтох эмгэгийн сэргээн засах үйлчилгээг төрөөс дэмжиж, хувийн хэвشلүүдтэй хамтран хэрэгжүүлж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамаарал бүхий хүнд эрүүл мэнд, сэтгэц, нийгэм, нийгмийн хамгааллын цогц тусламж, үйлчилгээ үзүүлэх энэ тогтолцоогоо шинэчилж гэж байгаа. Өөрөөр хэлбэл энэ донтолт болон хэрэглээнд нэвтэрсэн хүмүүсийн нөхөн сэргээх эмчилгээ, засах, сэргийлэх эмчилгээнүүдийг эрчимжүүлэх шаардлага байна гэж үзэж байгаа юм. Зургаадугаарт, хууль бус эргэлтийг сурталчилсан зар сурталчилгаа, контент /content/ бүтээгчдэд хариуцлага хүлээлгэх ийм шаардлага байна гэж үзэж байгаа юм. Нэг талаараа цахим хөгжил, энэ ухаалаг шийдлүүд ажил амьдралыг хөнгөвчилж, ололт амжилтыг авчирч байгаа хэдий ч нөгөө талаараа бас энэ төрлийн гэмт хэргүүд цахим орчинд үйлдэгдэх, сурталчлагдах, ил далд иргэд, хүүхэд багачуудыг санаатай, санамсаргүй татаж оруулах ажлууд явагдаж байгаа. Сүүлийн үеийн арга хэрэгслүүд улам нарийсаж байгаа. Ийм учраас эдгээр хуулиудын төслийг боловсруулж танилцуулж байна.

Хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, хүүхэд залуучуудын, ялангуяа улс орны ирээдүй болсон аюулгүй орчинд ажиллаж, амьдрах эрхийг хангах, хангагдах ёстой хүүхдүүдийн эрх ашиг, залуучуудын аюулгүй байдлыг хангаж, цаашлаад улс орны үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн эрх зүйн чухал шинэчлэл гэж үзэж байгаа. Хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар бид мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чадавхыг үндэсний хэмжээнд нэмэгдүүлнэ. Түүнээс урьдчилан сэргийлэх төрийн бодлого илүү тодорхой болно. Салбар хоорондын уялдаа холбоо илүү ойрхон бөгөөд үр дүнтэй, бүтээмж өндөртэй болно. Үр нөлөөтэй эрх зүйн үндэс ингэж бүрдсэнээр бид бас нэлээн ахиц дэвшил гарна гэж үзэж байгаа юм. Одоо бол хууль сахиулах байгууллага дээр хар тамхи, мансууруулах бодисын эргэлт, хэрэглээтэй тэмцэх алба ажиллаж байгаа ч гэсэн хүчин чадал хангалтгүй байна.

Сүүлийн үеийн үндэстэн дамнасан бүлэглэлүүдийн үйл ажиллагаа улам нарийн зохион байгуулалттай болж байгаа. Хил, гаалиар орж ирэх хяналт шалгалтыг чангатгахаас гадна гаднаас орж ирж байгаа урсах урсгалыг олон улсын байгууллагууд, мөн энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцдэг мэргэжлийн байгууллагуудтай илүү хамтарч ажиллах шаардлага байна. НҮБ-ын энэ хар тамхитай тэмцэх байгууллагын үйл ажиллагаатай уялдуулах, энэ чиглэлээр хамтарсан олон улсын тандалт судалгаа хийх, эрсдэлийн нөхцөлийг илүү шинэ түвшинд тодорхойлох, бодитой тодорхойлох, түүний дагуу илүү эрчимтэй үйл

ажиллагаа явуулах боломж, нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр бас ажиллаж байна. Түрүүн би хэлсэн, дахиад одоо энэ НҮБ-ын конвенцын жагсаалтад ороогүй шинэ төрлийн синтетик бодисыг ашигласан гэмт хэрэг үйлдэх, жагсаалтад байхгүй гэсэн үндэслэлээр хуулийн хариуцлагаас мултрах, зайлсхийх ийм нөхцөлүүд бас ихээхэн бүрдсэн байгаа учраас энэ хуулийн зохицуулалтад эдгээр зохицуулалтууд орчихсон байгаа.

Онц их хэмжээний шалгуурыг ЗГ-аас тогтоохоор тусгасан байгаа. Тухай бүрд нь шаардлагатай цаг үеийн нөхцөл байдал, энэ өөрөө орчин нөхцөл нь өөрөө хурдтай хувьсан өөрчлөгддөг учраас тэр цаг хугацааг алдахгүйгээр бид тухай бүрд нь ЗГ-т оруулж жагсаалтаа өөрчлөх, шинэчлэх шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх үүднээс энэ хуульд ЗГ-ын эрх хэмжээг тогтоож өгсөн ийм онцлогууд байна гэдгийг хэлье. Товчхон танилцуулахад ийм байна. Тэгээд асуулт байвал хариулъя.

Д.Цогтбаатар: С.Амарсайхан сайдад баярлалаа. Одоо хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хууль зүй, дотоод хэрэг /ХЗДХ/-ийн сайд Амарсайхан, ХЗДХ-ийн дэд сайд Мөнх-Эрдэнэ, ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга /ТНБД/ Батбямба, ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын Нийгмийн эрх зүйн хэлтсийн дарга Энхтөр, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн зохистой ашиглалтын газрын дарга Балжинням, ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын Нийтийн эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч Амгалан, Эрүүл мэндийн яам /ЭМЯ/-ны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал хариуцсан ахлах шинжээч Энхтуяа, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлого, зохистой ашиглалтын газрын ургамал хариуцсан ахлах мэргэжилтэн Мөнхтуяа, ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх албаны дарга, цагдаагийн хурандаа Товуудорж, ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх албаны тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Эрхэсбаатар, ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Мөнхсайхан, Тагнуулын ерөнхий газар /ТЕГ/-ын хэлтсийн дарга Энхбат, ТЕГ-ын ажилтан Ундрахбаяр, Хил хамгаалах ерөнхий газар /ХХЕГ/-ын Хилийн боомтын газрын шалган нэвтрүүлэх хэлтсийн дарга, дэд хурандаа Мөнхцог, Шүүх шинжилгээний ерөнхий газрын Байгалийн ухааны шинжилгээний хэлтсийн дарга Ламчин, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар /ШШГЕГ/-ын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны Албадлагын арга хэмжээний хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Амарзаяа, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эмийн үйлдвэрлэл, хэрэглээний асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Лувсанжанцан, Гаалийн ерөнхий газар /ГЕГ/-ын Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтсийн дарга Ганзориг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Эрүүл Монгол хүн үндэсний хөдөлгөөний Сэтгэц, нийгмийн сэргээн засах төвийн зохицуулагч Түмэндэмбэрэл, Сэтгэцйн эрүүл мэндийн үндэсний төв /СЭМҮТ/-ийн Сэтгэц, нийгмийн эрүүл мэнд, гадаад харилцаа, сургалтын албаны мансуурлын асуудал хариуцсан мэргэжилтэн, эмч Байгальмаа, СЭМҮТ-ийн зөвлөх эмч Елена, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны Мансуурах, согтуурах донтолтоос урьдчилан сэргийлэх газрын дарга Нандин-Эрдэнэ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны ахлах мэргэжилтэн Дэлгэрхишиг, ШШГЕГ-ын Хорих ял эдлүүлэх албаны гүйцэтгэх ажлын хэлтсийн

дарга, хошууч Мөнхрэнчин гэсэн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хуралдаанд оролцож байна. Ажлын хэсгийн гишүүдийг танилцууллаа.

Хууль санаачлагчийн илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү. Сайнзориг гишүүнээр тасаллаа. Одонтуяа гишүүн, Сайнзориг гишүүний микрофоныг өгье. Баасанжаргал гишүүнийг оруулаарай.

П.Сайнзориг: Энэ хуулийг бүрэн дэмжиж байна. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулга орж ирж байгаа. Би хэдэн суурь асуудлуудыг асууя гэж бодож байна. Ер нь судалгаа хийхэд ч бас бэрхшээлтэй л байдаг, зүгээр магадлал ярих гэж байна. Ер нь хэрэглэгчийн тоо, насны сегмент /segment/ ямархуу байдалтай болж байгаа вэ? Зүгээр одоо энийг бас олон нийтэд дэлгэх тийм таатай биш, боломжтой тохиолдолд ер нь хариулаарай гэж хүсэж байна би ажлын хэсгээс.

2 дугаарт, бас энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажил дээр тагнуулын алба хэт төвлөрснийх гажиг гараад байна уу даа гэж би зүгээр хувьдаа боддог. 2016, 2017 оны хувьд тагнуулын чиг үүргүүдийг нэгтгэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, хилийн тагнуул, цэргийн тагнуулыг ТЕГ-тай нэгтгээд сүүлд цэргийн албан хаагчдын багц хууль баталж байхад цэргийн тагнуулыг тусад нь аваад гарчихсан. Гэтэл энэ хилийн тагнуул бол нэг эх сурвалж байсан байхгүй юу, ТЕГ бас нэг эх сурвалж. Энэ дээрээсээ эх сурвалжуудаа тулгаад энэ гэмт хэргүүдийн илрүүлэлт уг нь гайгүй байдаг юм шиг санагддаг, тэгж ч хуучны хүмүүс ярьдаг. Гэтэл энэ тагнуулуудыг нэгтгэх гэдэг юм уу ганцхан эх сурвалжтай болсон нь энэ мэдээллүүд яг хууль сахиулах албан дээр ирдэггүй, тагнуулын байгууллага дээрээ ирдэг. Энэ дээрээс тодорхой хэмжээний мэдээлэл ирвэл энийг чинь шалгах харьяаллын хувьд цагдаагийн байгууллагад ирнэ шүү дээ, цагдаагийн энэ чиглэлийн алба руу. Тэгэхээр энэ мэдээллүүд бүрэн ирж шалгагддаг уу, үгүй юу гэдэг ч гэсэн эргэлзээтэй байхгүй юу. Тэгэхээр Хилийн тагнуулын албыг буцаагаад ХХЕГ-т нь өгөх энэ тал дээр ер нь ЗГ ямар байр суурьтай байгаа юм бэ асуулт байна?

2 дугаарт, энэ үндэсний жагсаалттай болох асуудал байгаа юм. Энэ сэтгэцэд нөлөөт бодис болон эмийн асуудал дээр. Бид конвенцынхоо жагсаалтыг бариад л яваад байдаг. Үндэсний жагсаалтаа бас конвенцтой нийцүүлээд, үүндээ нийцүүлээд хурдтайгаар нэмэлт, өөрчлөлтүүдээ шийдээд явбал энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хариуцлагаас завшуулахгүй байх нэг үндэслэл байгаа юм. Тэгээд нөхцөл байдал даамжрахаас өмнө сэргийлчхэж бас болоод байгаа юм. Хэзээ билээ бас нөгөө мими /mimi/ билүү, тийм ээ? Энэ бодисыг чинь жагсаалтад хийж чадахгүй байж байтал явсаар байгаад, явсаар байгаад тээврийн жолооч нар нь бүгд одоо мими хэрэглэж унтдаггүй, ингээд үндсэндээ ядардаггүй гэдэг юм уу даа, одоо зомби /zombie/ болох маягтай байж байдаг ийм юм руу орчихсон. Тэгээд сүүлдээ залуу үе рүү, хэрэглэгч рүү орчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ Үндэсний жагсаалт гэж бий болгож гаргах уу? Энэ дээр бас нэг хариулт өгөөч.

Ял хариуцлагын хувьд салах ёстой, синтетик буюу лабораториор гаргаж авч байгаа хар тамхи дээр илүү их ял хариуцлага өгөх ёстой, Байгалийн гаралтай дээр бол тодорхой хэмжээ.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Гүйцээх үү? Хэн хариулах вэ? С.Амарсайхан сайд уу, хэн хариулах вэ? 3 дугаар микрофон, Мөнх-Эрдэнэ дэд сайд.

Д.Мөнх-Эрдэнэ: УИХ-ын гишүүдэд энэ өдрийн амгаланг айлтгая. Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Сүүлийн 9 жилийн байдлаар гэмт хэргийн судалгаа байгаа. Энд холбогдогчийн байдал, насны бүтэц, хүйсийн бүтэц, нийгмийн байдал, боловсрол гээд, би энийг танд асуултын дагуу хариулаад өгье. Нийт гэмт хэрэг газар зүйн байршлын хувьд Улаанбаатар хотод 83.3 хувь нь үйлдэгдэж байгаа, орон нутагт бол 16.7 хувь. Насны байдлаар авч үзвэл, 13-17 насны хүүхэд холбогдсон нь 107 хүн буюу нийт гэмт хэрэгт эзлэх хувь 4.4 хувь, 18-25 насных 1223 буюу 50.4 хувь, 26-35 нас буюу 868 хүн, эзлэх хувь бол 35.8 хувь, 36-аас дээш насны хүн 224 буюу 9.2 хувьтай байна. Хүйсийн бүтцийн хувьд эрэгтэй 2180 буюу 90 хувь нь, эмэгтэй 242 буюу 10 хувь нь байна. Нийгмийн байдлын хувьд ажилгүй иргэд 1442, энд бага насны залуучууд их холбогдож байгаатай холбоотой асуудал байгаа, 1442 бол 59.5 хувь, хувиараа хөдөлмөр эрхлэгч 454 буюу 18.7 хувь, оюутнууд 217 буюу 8.9 хувь, хувийн хэвшилд ажиллаж байгаа 191 буюу 7.8 хувь, сурагч 64 буюу 2.6 хувь байна, бусад гээд ТББ 23 хүн буюу 0.9 хувь, төрийн албан хаагч 19 буюу 0.7 хувь байна. Боловсролын байдлын хувьд бүрэн дунд боловсролтой 60.5 хувь, дээд 22.2 хувь, бүрэн дунд бус дунд боловсролтой 11.4 хувь, тусгай дунд 4.3 хувь, бага 1 хувь байна. Ийм статистик тоон судалгаа манай хууль сахиулах байгууллагуудын хэмжээнд байна.

2 дахь асуудлын хувьд ТЕГ-ын хар тамхитай тэмцэх үйл ажиллагааны хүрээнд гүйцэтгэж байгаа гол асуудал бол хилийн гадаад тал, гадаадаас орж ирж байгаа энэ гэмт хэрэгтэй тэмцэх асуудал байгаа. Энэ бодлогыг зангидаж байгаа газар нь, олон байгууллагууд оролцож байгаа учраас ер нь бид энэ шинэ хуулийн төслөөрөө үндэсний хороон дээр энэ оролцож байгаа байгууллагуудын мэдээллийг нэгтгэж, боловсруулалт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээн дээр арга хэмжээгээ боловсруулахад ашиглах энэ чиглэлээр ажиллая гэж байгаа. Өөрөөр хэлбэл, үндэсний хорооны үйл ажиллагааг идэвхжүүлэх, мэдээж энэ гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны хүрээнд ТЕГ, Хил хамгаалах.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Гүйцээгээд хариулах уу? 3 дугаар микрофон.

Д.Мөнх-Эрдэнэ: Цагдаагийн байгууллага гээд олон байгууллагуудын оролцоо байгаа. Өөр өөрийн чиг үүргийн хүрээнд энэ хар тамхитай тэмцэх үйл ажиллагаанд оролцоод чиг үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлээд явж байгаа.

3 дахь асуулт, тийм ээ таны хэлж байгаа үнэн. Бид бас энэ үндэсний жагсаалт заавал байх ёстой гэж үзэж байгаа. Өөрөөр хэлбэл, 1961 оны конвенц, 71 оны конвенц, 89 оны конвенцыг аваад үзэхээр энэ конвенцуудад өөрчлөлт оруулах асуудал бол 1-2 жилийн хугацаа шаарддаг. Гэтэл энэ шинэ төрлийн синтетик химийн гаралтай бодисууд бол маш хурдан өөрчлөгдөж байгаа. Тийм учраас энийг олон улсад байгаа сайн жишгээр ер нь энэ үндэсний жагсаалттай болж, ял завшуулахгүй байх, гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх энэ арга ажиллагаанд ашиглаж байгаа. Тийм учраас бид бас хуулийн төсөлдөө үндэсний жагсаалттай болох.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Тодруулъя, Сайнзориг.

П.Сайнзориг: Эрүүгийн хуулийн ял хариуцлагыг бас нэг хэлчхээрэй, олон нийт ч гэсэн мэдэг. Ер нь байгалийн гаралтай мансууруулах төрлийн бодис,

синтетик төрлийн буюу лабораториос гарсан ялын бодлогыг өөр болгоё гээд ХЗДХЯ үеийн үед л бодлогоо зангидаад явж байсан. Энэ яаж орж ирж байгаа вэ?

Дээрээс нь нэг эмчлэх бодлогын асуудал байгаа юм. Бид бол одоо олж авснаар бүгдийг нь суулгаж байгаа. Сүүлийн үед бүр суулгахаа ч больсон юм билээ. Тэгээд энэ хэрэглэж байгаа нөхдүүдийн чинь эмчлэх асуудлыг архины сангаар дамжуулаад дэлгэцийн дон, архины дон, мансууруулах донг эмчилье гээд архины сан дээр чинь 20 тэрбум төгрөг цугларчхаад байдаг. Одоо хүртэл нэг ийм ор, дэр, дэд бүтцийг бий болгох ажил удаашралтай. Сангийн яам нь архины санг аваачаад төрийн мөнгө гэж үзээд байдаг, энэ мөнгийг чинь архи үйлдвэрлэгчид литр тутамдаа өндөр градустай архинаасаа өгөөд ийм нийгмийн хариуцлагын хүрээнд өгч байгаа байхгүй юу. Энэ хуулийн би өөрөө бид нөгөө боловсруулаад явсан гээд төрийн мөнгөтэй хутгалдаад ингээд болдоггүй. Тэгэхээр энэ дээрээ ямар бас зүйлүүд хийх гэж байна? 2 дугаарт, энэ аптек.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Өөрийнх чинь уг нь дууссан, гэхдээ нэмээд асуучих, гүйцээгээд.

П.Сайнзориг: Тэгэх үү даргаа. Аптекуудын нөгөө эмийн хяналтын асуудлыг нэлээн сайн болгох асуудал байгаад байгаа юм. Ер нь энэ аптекуудаар анхлан орж байгаа хүмүүс чинь шууд орж байгаа, аптекуудаар ийм мансууруулах төрлийн эмүүдийг аваад, тэгээд цаашдаа илүү их өндөр тунгаар хэрэглэдэг ийм зүйлүүд рүү ингээд орж байна. Бид тэгээд ер нь зүгээр энэ мансууруулахтай тэмцдэг Үндэсний хороо гэхээсээ илүүтэй бас энэ нууц, далд аргаар илрүүлдэг, мэдээллүүдээ олж авдаг, энүүгээрээ баталгаатай байх ёстой. Энэ чиглэлийн эмийг уг нь бол хилийн тагнуулыг буцаагаад ХЗДХЯ, тэр Хил хамгаалахад нь өгчихмөөр л юм байгаа юм. Бид хэд нэг л дээ. Тэгээд аль аль талдаа хяналтаа хэрэгжүүлээд явах нь зүйтэй байгаа юм. Ер нь ТЕГ дээр төвлөрүүлээд, энэ дээрээс бас л нэг хугацаа иднэ шүү дээ. Дараагийн нэг асуудал, энэ нөгөө хэрэглэгчээ тогтоох буюу сүүлийн үед улс орнууд чинь ингээд байгалийн гаралтайг нь хэрэглүүлээд, хэрэглэгчээ тогтоогоод, синтетикээс нь болиулах л арга барил барьж байна. Зүгээр манай дээр ямар бодлогыг одоо энэ хуулийн хүрээнд.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Ажлын хэсэг, 3 дугаар микрофон.

Д.Мөнх-Эрдэнэ: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Бид шинэ төсөл дээр ял шийтгэлийн бодлого дээр гол оруулж ирж байгаа өөрчлөлт бол энэ тунгийн хэмжээ. Өөрөөр хэлбэл, өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуулиар ямар хэмжээний тунтай, тун хэмжээний хувьд хар тамхины төрлийн бодис хэрэглэснээс үл хамаараад яг адилхан ялын бодлого хэрэгжээд байгаа. Энэ шүүх дээр хууль хэрэгжиж байгаа байдлыг харахаар их хэмжээний тун хэмжээтэй энэ хар тамхины хууль бус хэрэглээтэй холбоотой асуудал дээр зарим тохиолдолд тэнсэх ял оноочихсон. Гэтэл харьцангуй бага тун хэмжээтэй энэ хар тамхины төрлийн бодис дээр бол илүү чанга ял оноочихсон. Тэгэхээр энэ юунаас харагдаж байна гэхээр бид бас энэ олон улсын жишгийг барьж, энэ хар тамхитай холбоотой хэрэг.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Амарсайхан гишүүн.

С.Амарсайхан: Тодруулъя. 1 дүгээрт, Сайнзориг гишүүний асуусан энэ мансууруулах бодисын төрөл, хэмжээнээс хамааруулан ялын бодлогыг ялгаатай

тогтооё гэж байгаа юм. Бүр цаашлах юм бол тусгай зөвшөөрөлтэй эм, эмийн хэрэгсэл, хангалт, нийлүүлэлтийг хийдэг байгууллагууд, түүнийг ашигладаг байгууллагууд хэрвээ хууль бусаар энийг эргэлтэд оруулсан байвал мөн гэмт хэрэгт тооцдог байх ийм тогтолцоо руу оруулна.

2 дугаарт, архины борлуулалтаас бүрдэх сан гэж бий. Энэ бол урьдчилан сэргийлэх бөгөөд энэ донтолт, хэрэглээтэй холбоотой эмчилгээнд зориулах ёстой ийм зардал. Гэхдээ Төсвийн тухай хууль, бусад хууль тогтоомжоос болоод энэ зарцуулагдаж чаддаггүй яваад байдаг ийм хөрөнгө санхүүгийн эх үүсвэрүүд бий. Өнөөдрийн байдлаар энэ санд 23 тэрбум төгрөг байна. Энийг одоо энэ төсөв, санхүүгийн бодлоготойгоо уялдуулаад бид урьдчилан сэргийлэх төвүүдийг барьж байгуулах, эмчилгээ, оношилгоонд зориулах.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Одонтуяа гишүүний микрофоныг өгье. Одонтуяа гишүүн бол энэ асуудал дээр нээрээ олон түмний анхааралд байх үед нь ч, байхгүй үед нь ч байнга төрийн анхаарлыг ийшээ хандуулж идэвхтэй ажиллаж байдаг гишүүдийн нэг. Одонтуяа гишүүний микрофоныг өгье.

С.Одонтуяа: Маш чухал хууль орж ирж байна. Тэгэхээр хүүхэд залуусыг хамгаалах ийм тусгай хөтөлбөрүүд энэ хуульд ер нь хэр хангалттай туссан юм бол? Сургуулиуд дээр урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжих үү, онлайн /online/ орчноор хүүхдүүдэд хүрэх эрсдэлийг хэрхэн бууруулах вэ гээд энэ хүүхдүүдтэй холбоотой асуудал?

2 дахь нь санхүүжилттэй холбоотой. Энэ хуулийг хэрэгжүүлэхэд улсын төсөвт хэдий хэмжээний зардал одоо тусгах шаардлагатай вэ? Аймаг, орон нутагт эмчилгээ, урьдчилан сэргийлэх үйлчилгээ хүртээмжтэй байж чадах уу? Ямар нэгэн одоо тэр хүний өөрийнх нь төлбөрөөс гадна өөр одоо даатгалаар ч гэдэг юм уу ямар нэг тийм эмчилгээ хийх боломж бий юү?

3 дахь нь энэ хууль сахиулах байгууллагатай холбоотой. Хар тамхитай тэмцэх газар гээд ийм бие даасан байгууллага нь байх юм уу эсхүл цагдаагийн бүтэц дотор байх юм уу? Энэ Үндэсний хороо, цагдаа, гааль, хил хамгаалах гээд нэг олон чиг үүргийн давхардал, зөрчлийг энэ хуульд хэрхэн тодорхойлсон бэ? Донтох эмгэгтэй иргэдэд зориулсан ямар зүйл орж чадсан бэ? Энэ улсын эмнэлэг чинь хангалттай эмчлэхгүй, хувийн эмнэлгүүд ажиллаж байгаа. Гэтэл хувийн эмнэлгүүд нь төрөөс дэмжлэггүй болохоор ажиллаж чадахгүй, ингээд хаагдаад байгаа юм л даа. Би бас хэд хэдэн эмнэлгүүд дээр очиж уулзаж байсан. Тэгэхээр түрүүн энэ Амарсайхан сайд ярьсан, тэр 20 тэрбум төгрөг гээд авдаг мөнгө төгрөг байвал энэ төр, хувийн түншлэлээрээ хийж болох юм уу, яах ёстой юм бэ? Бүгдийг төр хийнэ гэвэл одоо чадахгүй байх.

СЭМҮТ-ийн хашаанд баригдах энэ донтолтын эсрэг төвийнхөө зураг, төсвийг хийж эхэлсэн үү? Албадан эмчилгээг энэ хүний эрх хоёрын холбоог яаж зөв шийдвэрлэх юм бэ? Албадан эмчилнэ гэхээр л нөгөө талаас хүний эрх гээд яриад байдаг ийм хэдэн зүйлийг эхлээд асууя.

Д.Цогтбаатар: Хэн хариулах вэ? Амарсайхан сайдын микрофоныг өгье.

С.Амарсайхан: Энэ мансууруулах эм, эмийн хэрэгслийн донтолттой холбоотой эмчилгээ, оношилгоог илүү олон улсын түвшинд хүргэсэн байдлаар

зохион байгуулах энэ орчин нөхцөл энэ хууль батлагдсанаар бүрдэнэ гэж үзэж байгаа, 1 дүгээрт.

2 дугаарт, ер нь зөвхөн СЭМҮТ-ийн орчинд гэхгүйгээр энэ дүүрэг, орон нутгуудад бүсчилсэн маягаар энэ хэрэглээ, донтолттой холбоотой эмчилгээг хийх. Энэ өөрөө багадаа 3-6 сар, түүнээс ч урт хугацаа шаарддаг ихээхэн хүндрэлтэй ажил байдаг учраас энийг нэг бүсэд гэдэг юм уу, нэг газар хийснээр болчихгүй гэж үзэж байгаа учраас ялангуяа энэ олон нийтийн санг хууль тогтоомжид нь шаардлагатай өөрчлөлтийг оруулаад нэг стандартаар, түүнээс гадна барилга байгууламж, дэд бүтцийг барихаас гадна бид энэ сэтгэл зүйч, эмчлэгч, энэ хүмүүстэй харьцдаг одоо энэ мэргэжлийн хүмүүсийг маш сайн бэлдэхгүй бол өнөөдөр энэ дээр дутагдал асар их байна гэж үзэж байгаа.

3 дахь асуулт юу гэсэн билээ? Тийм, хууль сахиулах байгууллага, мэдээж Үндэсний хороо ажиллана. Үндэсний хороонд бүх төрийн байгууллагууд, хууль сахиулах болон холбогдох мэргэжлийн байгууллагууд орсон байгаа. Энэ бол бодлого, шийдвэрээ тодорхойлоод хууль сахиулах байгууллага өөрөө энэ хар тамхитай тэмцэх алба, байгууллагаа илүү чадавхжуулж, мэргэшүүлж энэ чиглэлээрээ нэгдсэн бөгөөд мэргэжлийн зохион байгуулалттай арга хэмжээг авах ёстой. Цагдаагийн байгууллагын Хар тамхитай тэмцэх алба, газар үйл ажиллагаа явуулдагараа явуулна. Энэ тусдаа газар, алба байх шаардлагагүй. Харин тэрний бодлого, шийдвэрийг үндэсний хэмжээнд Үндэсний хороогоороо тодорхойлж, үүрэг даалгавар, хэрэгжилтийг нь хангаж явдаг байх энэ тогтолцоогоо л бид хэрэгжүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавиад гүйцэтгэлийг нь хангуулаад явах юм бол өөр шинэ бүтэц хэрэггүй гэж үзэж байгаа. Болсон уу?

Улсын төсөвт энэ хууль батлагдсанаар нэг их айхтар ачаалал үүсгэхээсээ түрүүлээд урсгал зардлууд нэмэгдэнэ гэж үзэж байгаа юм. Яагаад гэвэл бид энэ хяналт, шинжилгээ, үнэлгээ, тэгээд хил, гаалийн хяналтаас эхлээд зохион байгуулалтын түвшинд ажиллагаанууд нэлээн хийгдэх ёстой. Энд хамгийн том төсөв хөрөнгөтэй холбоотой асуудал гэх юм бол мэргэжлийн байгууллагуудыг чадавхжуулах, өөрөөр хэлбэл төрөл бүрийн урвалж бодисуудыг аваад дэлхий нийтэд байнга шинээр нэмэгдэж байгаа энэ синтетик бодисуудыг хянах, шалгах, ялгах ажлыг зөвхөн одоо Улаанбаатар хотын төвд хийдэг, орон нутагтаа хийж чаддаггүй биш, энийг бүсчилж аймаг, орон нутгийн түвшинд хийж хэрэгжүүлэхээс эхлээд мэргэжлийн энэ хар тамхитай тэмцэх чиглэлийн алба хаагчдыг мэргэшүүлэх ажлууд байгаа. Өнөөдөр зөвхөн ЦЕГ дээр энэ алба удирдагдаж байгаа учраас.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Гүйцээх үү? Амарсайхан сайдын микрофоныг өгье.

С.Амарсайхан: Тэгэхээр дунд, доод шат буюу аймаг, орон нутаг, улсын хэмжээнд мэргэшүүлж, чадавхжуулах ажлуудыг идэвхжүүлэх хэрэгтэй. Энэ хэргийг илрүүлэх, таслан зогсоох, мөн зохих арга хэмжээнүүдийг цаг алдалгүй авч хэрэгжүүлэхтэй холбоотой тодорхой хөрөнгө оруулалтын ажлуудыг тухайн тухайн салбарынх нь жилийн болон төсөв хөрөнгийнх нь төлөвлөлт дээр тусгаад явахад энэ хууль батлагдсанаар айхтар том хөрөнгө, төсвийн өөрчлөлт, шинэчлөлт гараад түүнээс шалтгаалаад ажил хэрэгжихгүй байх тухай асуудал байхгүй гэж ойлгож байгаа.

Д.Цогтбаатар: Одонтуяа гишүүний микрофоныг гүйцээгээд өгье.

С.Одонтуяа: Энэ нөгөө СЭМҮТ-ийн хашаанд баригдах барилгын зураг, төсөв нь хийгдсэн болов уу гэсэн, хүүхэд, залуусын хамгааллын хөтөлбөр гэж асуусан юм. Тэгээд аль орны ер нь хуулийг бас нэг голчилсон бэ? Одоо бид нар чинь хууль яахдаа ерөнхийдөө нэг орны юу нэг жаахан ингээд судлаад аваад байдаг шүү дээ, тэгчихсэн юм уу эсхүл их олон орныхыг судалсан юм уу гэдэг ийм зүйлүүд.

Д.Цогтбаатар: Аль микрофон бэ, 3 уу? 3 дугаар микрофон.

Д.Мөнх-Эрдэнэ: Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Хуулийн төслийг боловсруулахад харьцуулсан судалгаа хийсэн. Европын Холбооны улсуудын жишээ, мэдээж энэ Зүүн Хойд Ази, Зүүн Өмнөд Азийн улсуудын жишээ. Сүүлийн үед манай бас гадаад харилцаа өргөжих, Монгол Улсын иргэд гадаад руу их зорчиж байгаатай холбогдуулан Зүүн Өмнөд Ази, бусад улсуудад энэ хар тамхи нэлээн өргөн тархсан санаа зовоосон нөхцөл байдлууд ажиглагдаад байгаа. Тийм учраас эдгээр улсуудын хууль тогтоомжийг онцгойлон судалсан байгаа. Тэгээд НҮБ-аас гаргасан зөвлөмж, зааврууд, олон улсын гэрээ, конвенцод манай хууль тогтоомжийг бүрэн нийцүүлэхэд ер нь гол анхаарсан. 1961, 71, 89 оны конвенцод Монгол Улс нэгдсэн мөртөө хууль тогтоомжоо бүрэн нийцүүлэх асуудал орхигдсон байсан. Тийм учраас эдгээр.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Яах вэ, гүйцээж хариулах уу? 3 дугаар микрофон.

Д.Мөнх-Эрдэнэ: Гол анхаарсан байгаа гэдгийг хэлье. Та бас түрүүн асуусан, би нэг гүйцээгээд хариулахад бид энэ согтуурах, мансуурах донтой эмгэгтэй тэмцэх чиглэлээр тусгай байгууллага энэ СЭМҮТ-ийн хашаанд байгуулна гэж ярьж байсан. Энэний зураг, төсвийн асуудлыг Эдийн засгийн хөгжлийн яаманд албан ёсоор тавиад, төсөв мөнгө нь шийдэгдээд ингээд хийгдээд явж байгаа гэдгийг бас танд хэлье.

Д.Цогтбаатар: Гүйцээж хариулах уу? Тодруулъя, 3 дугаар микрофон.

Д.Мөнх-Эрдэнэ: Бидний бас энэ хуулийн гол концепц бол урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх ажлууд байгаа. Энд боловсролын байгууллагын зүгээс голлон анхаарах ёстой зүйлүүд бий. Тийм учраас үүн дээр урьдчилан сэргийлэх чиглэлээр боловсролын байгууллагын хүлээх үүргийг маш тодорхой хуулийн төсөлд тусгасан байгаа гэдгийг хэлье. Нөгөө талаас та асуусан, нөгөө эрүүл мэндийн даатгал /ЭМД/ гэж ярьж байсан. Бид ЭМД-аар энэ жишээ нь өөрөө сайн дураараа донтох эмгэгтэй хүн сайн дураараа эмчлүүлэх гээд ирэхэд нь энэ хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээс илүү энэ хүнд туслах эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, тусламж.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Баярбаатар гишүүний микрофоныг өгье. Манайхан, Баярбаатар гишүүний цагийг түр зогсоож бай. Хэн хэн нэмж, Нарантуяа-Нара гишүүн асуулт асууна гэсэн, Нарантуяа-Нара гишүүнийг оруулаад өгөөрэй. Баярбаатар гишүүний микрофоныг өгье.

Б.Баярбаатар: Маш чухал хуулийн шинэчилсэн найруулгын төсөл орж ирж байгаа юм байна. ЗГ-аас өргөн барьж байна, ХЗДХ-ийн сайд танилцуулгыг хийлээ. Өнөөдөр манай улсад гол тулгамдаж байгаа асуудлын нэг мөн үү гэвэл яалт ч үгүй мөн. Өнөөдөр бид энэ хар тамхитай тэмцэх, урьдчилан сэргийлэх, илрүүлэх тал

дээр хоцрогдсон байгаа гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Тэгээд өдрөөс өдөрт энэ хар тамхинд донтогчдын тоо нэмэгдэж, нас залуужиж байгаа.

Тэгэхээр би хэдэн зүйл асууя. Гааль хариулах болов уу гэж бодож байна, манай Монголд ер нь яг энэ карго /cargo/ үйлчилгээ явуулдаг хэдэн байгууллага байна хувийн хэвшил? Тэгээд энэ каргогоор орж ирж байгаа бараа бүтээгдэхүүнд хяналт тавьж байгаа хяналт нь хэр байна? Одоо тэр чинь нэг ёсны эзэн нь яг хажууд нь байхгүй гэсэн ачаа шүү дээ одоо тэндээс ингээд ачуулчихсан байгаа.

2 дугаарт, неон илрүүлэгч гээд нэг юм байдаг юм шүү дээ. Энэ манайд байгаа юу? Одоо бусад улсын хилээр ороход янз бүрийн бүс, гутлын уланд ингээд нэг ийм юм арчаад, нэг ийм илрүүлэгч дотор хийгээд хараад, шууд дор нь ингээд явуулаад байдаг. Манайд яг энэ төхөөрөмж байгаа юу? Хэрвээ байгаа бол энүүгээр одоо бид нар илрүүлж чадаж байгаа юу? Ер нь одоо энэ галт тэргээр зорчиж орж ирж байгаа, хил нэвтэрч орж ирж байгаа улсуудын ачаа бараанд энэ яаж энэ илрүүлэлт явагддаг юм? Онгоцных одоо бас нэг арай өөр байж магадгүй. Газрын галт тэрэг болон тээврийн хэрэгслээр орж ирж байгаа, дээр нь тээврийн машинуудын одоо энэ зүйл дээр яаж хийж байгаа вэ?

Дараагийн нэг асуудал манай О.Номинчимэг гишүүн бид 2 сүүлийн үед толгойны өвчин болоод, олон хүнд ч шүүмжлүүлээд л явж байгаа, энэ Тамхины хууль гээд нэг зүйл дээр, ялангуяа энэ вэйп /vape/ тамхи бусад улсуудад орж ирчхээд байгаа шүү дээ. Вэйп тамхины дотор шингэнээр дамжиж хар тамхи орж ирсэн. Манайд шинжилдэг лаборатори байгаа юу? Одоо тэр вэйп тамхины дотор байгаа шингэнийг шинжлэх нэг хэрэг, тэр нь сороход утаа болоод гарахдаа ямар бодис болоод гарч байгааг шинжлэх нь бас нэг өөр хэрэг. Тэгэхээр эдгээр зүйл дээр өнөөдөр ямар шинжилгээ явж байгаа вэ гэдгийг. Тэгээд сүүлийн үед чинь энэ хар тамхи чинь өмнө бол гоо сайхны бараа, гар утас дотор орж ирдэг байсан, одоо цаас болоод орж ирдэг болчихсон байна шүү дээ. Ялтас хэлбэрээр, зүгээр ийм бичгийн цаас болоод орж ирдэг болчихсон. Энийг илрүүлэх боломж байгаа юу манайд? Ингэж байж, энийгээ нөхцөлөө бүрдүүлж байж урьдчилан сэргийлэх арга хэмжээ ярина. Цаашаагаа ярих боломж эндээс цааш хаагдчихаад байгаа байхгүй юу. Энэ дээр бас нэг тодорхой хариулт авмаар байна.

Сая бол Амарсайхан сайдын танилцуулгаас харамсалтай тоо мэдээллүүд гарч байна. Тэгээд энэ дээр гааль, тагнуул, цагдаа 3 бол ажлын уялдаа маш сайн хангагдах ёстой гэж харж байна. Тэгээд асуултдаа хариултаа авъя.

Д.Цогтбаатар: Ажлын хэсэг, Амарсайхан сайдаар эхэлье. Та 1 дүгээр микрофон дээр солиод сууж байх уу. С.Амарсайхан сайд.

С.Амарсайхан: Зохих түвшинд хяналтууд хийгдэж байгаа, тэгээд хангалттай биш байгаа. Ялангуяа энэ хил, гаалийн рентген /X-ray/ аппарат, хяналт шалгалтуудыг томоохон боомт, хил, гаалиуд дээр тавих ажлууд бас удаашралтай явж байна. Хэд хэдэн хэлбэрээр шалгаж байгаа. Энэ бол рентген аппарат, дээрээс нь хар тамхи, тэсрэх бодисыг илрүүлэх зарим төрлийн тоног төхөөрөмжүүд гээд. Тэгэхдээ энийг өнөөдөр шаардлага хангаж байна гэж хэлэх одоо боломж байхгүй. Хил, гаалийн алба төрөл бүрээр энэ дээр хяналт тавьж байгаа. Ялангуяа зорчигч тээврээр орж ирж байна. Хувцас хунар, бүр цаашлах юм болбол ундаа, чихэр хүртэл болоод орж ирж байгаа ийм хэлбэрүүд бий. Гэр ахуйн хэрэгсэл, машин тээвэр, тоног төхөөрөмж, цүнх сав гээд. Тэгээд сүүлийн үед бас илрүүлэлтүүд харьцангуй сайн

хийгдэж байгаа ч гэсэн хөрөнгө оруулалтууд хангалттай энэ хил, гааль болон бусад газруудад тавих шаардлагатай гэдгийг энд зориуд би онцолж тэмдэглэж хэлж байгаа юм.

Нөгөө талаараа энэ тавих хяналтууд дээр бид энэ төрөл бүрийн сүүлийн үеийн бодисуудыг илрүүлдэг, шинжилдэг, цаг алдалгүй тодорхойлдог, тэгээд түүнтэй уялдаатай арга хэмжээнүүдийг авдаг байх чадавхыг дээшлүүлэхгүй бол яг өнөөдрийн байдлаараа бид цаашдаа энэ өсөн нэмэгдэж байгаа хэрэглээ, үүсэж байгаа хүндрэлүүд, болзошгүй эрсдэлүүдийг таслан зогсоох боломж нөхцөл хомс байгаа гэдгийг хэлэхгүй бол болохгүй байх. Ажлын хэсэг бусад мэдээллүүд дээрээ мэдээгээ өгчих.

Д.Цогтбаатар: 1 дүгээр микрофон.

Г.Ганзориг: Гаалийн ерөнхий газар. Баярбаатар гишүүний асуултад хариулъя. Яг албан ёсны карго шуудан илгээмж үйлчилгээ эрхэлдэг ААН-ийн тусгай зөвшөөрлийг бол энэ Харилцаа холбооны зохицуулах хорооноос авсан тусгай зөвшөөрөлтэй ААН-үүд одоо эрхэлдэг байгаа. Эд нар маань ихэвчлэн АНУ, Солонгос тэгээд Европын Холбооны улсаас агаараар болон газрын карго ачаа тээвэрлэж орж ирэх тийм зөвшөөрөл авчихсан байдаг тусгай зөвшөөрөл. Энэ нь бол яах вэ, төрийн байгууллагуудад бүртгэлтэй.

Энэнээс гадна Зүүн Өмнөд Ази болон Туркээс ямар нэгэн тусгай зөвшөөрөлгүйгээр иргэдийн ачааг бөөгнүүлж байгаад Монгол Улсын хилээр оруулж ирэхдээ өөрийнхөө нэр дээр юм уу, эсвэл өөр хамаарал бүхий компанийнхаа нэр дээр бүрдүүлэлт хийгээд, энэ бол миний ачаа гэж мэдүүлээд орж ирдэг бас хэсэг бүлэг иргэд байдаг. Гол зам суваг маань бол энэ зам сувгаар, ялангуяа Туркээс гарал үүсэлтэй мансууруулах бодис бол тэрүүгээр ингээд явж байгаа зам суваг харагддаг. Мөн багаж тоног төхөөрөмжийн хувьд бол.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 1 дүгээр микрофон, гүйцээгээд хариулъя.

Г.Ганзориг: Тухайн жилийн төсөвт багтаж тодорхой шинэчлэлүүдийг хийдэг. Түрүүн ярьж байсан хүний бие болон эд зүйлээс арчдас авдаг багаж тоног төхөөрөмжийг бол одоогоор нисэх онгоцны буудал дээр ашиглаж байгаа. Энэ жилдээ багтаагаад бусад Замын-Үүд, Сэлэнгэ зэрэг том зорчигч хөдөлгөөн ихтэй боомтууд дээр ашиглахаар төлөвлөөд ажиллаж байгаа. Гол зам суваг маань тэр бүртгэгддэггүй иргэдийн нэрээр орж ирж байгаа тэр ямар нэгэн бүртгэл үүсгэгддэггүй явагддаг тэр карго илгээмж дээр гол эрсдэл үүсээд ажиллаж байгаа. Тэрэн дээр бол гаалийн байгууллага цагдаа, тагнуулын байгууллагатай хамтраад тодорхой суваг 1, суваг 2 гэдэг арга хэмжээнүүдийг аваад тодорхой хумих ажиллагаанууд бол хийгдээд явж байна.

Д.Цогтбаатар: Баярбаатар гишүүн тодруулъя.

Б.Баярбаатар: Миний гол хэлэх гээд байгаа санаа, бид нар энэ хуулиа сайжруулаад одоо баталж, шинэчилсэн найруулгыг баталж болж байна. Сая Одонтуяа гишүүн ч гэсэн хэллээ. Бид төсөв мөнгө шийдэж, тодорхой түвшинд энэ технологи, техникээ сайжруулахгүй, энэ илрүүлэлтийг нэмэгдүүлэхгүйгээр энэ хууль амь орохгүй. Гол санаа нь энэ. Тэгэхээр өнөөдөр манай Баасанжаргал гишүүн байж байна, Номинчимэг гишүүн байна энэ хуульч гишүүдтэйгээ нийлж байгаад,

Сайнзориг гишүүн бид хэд нийлээд энэ хуулийг хэлэлцэх эсэхийг нь дэмжчихвэл миний бие ахлах саналтай байна. Нэлээн нарийн судалгаанууд хийгдчихсэн байгаа байх. Энэ дээр тулж байгаа хууль бол ерөөсөө яг л Монголын хойч үеийн, энэ өсвөр ирээдүйн төлөө л урьдчилан сэргийлэх тэр гол асуудлыг л анхааруулж энэ хуулийг батлах ёстой гэж харж байна. Тэгээд ажлын хэсэгт баярлалаа, амжилт хүсье.

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

О.Номинчимэг: Энэ их чухал хууль хэлэлцэж байна. Бид нар тоо баримтаа харахаар 2017-2025 онд нийтдээ 4398 хүн энэ мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчилд холбогдсон байна гэдэг статистик байгаа. Тэгээд насных нь ангиллаар харах юм бол 80 хувь нь ерөөсөө л 18-35 насны, 12 хувь нь 13-17 насны бүр ийм сурагчид, өсвөр үеийнхэн байгаа. Тэгээд нийтдээ ер нь 92 хувь нь 35 нас хүртэлх залуучууд, хүүхдүүд байна гэсэн үг. Тэгээд дөнгөж амьдралд хөл тавих гээд явж байх үедээ ийм хүчтэй донтолтод нэрвэгдэнэ гэдэг бол бид үнэхээр энэ дээр далайцтай арга хэмжээ авахаас өөр сонголт байхгүй бидэнд. Харин ч хожимдож эхэлж байгаа гэж бодож байгаа.

Тэгээд ингээд харах юм бол сая бас хэлж байна, ерөөсөө ингээд нөгөө хувь хүний юугаар их орж ирж байгаа гэж байна шүү дээ гааль. Тэгээд энэ нөгөө электрон тамхины асуудал ч гэсэн би бас судлаад явж байхад электрон тамхины шингэн гээд тэр чинь ямар ч тамхи гэж үзэгдэхгүй, зүгээр бараа, хувь хүмүүс ч гэсэн тусгай зөвшөөрөлгүйгээр оруулж ирж байгаа. Тэгтэл тэнд нь электрон тамхины шингэн, цэнэглэгч юм гээд хар тамхи шингэн мөс илүүтэй орж ирж байна гэж хэвлэл мэдээллийн байгууллагаас гаргаж байсан. Тоо датаг нь аваад үзэх юм бол нэлээдгүй олон кэйс /case/ энэ электрон тамхиар дамжиж хар тамхийг оруулж ирж байна гэсэн юм гараад байгаа юм. Тэгэхээр энэ дээр бид нар хяналт эд нараа аль аль талдаа хийхгүй бол үнэхээр хэцүү байна. Манай Монгол Улсын нөхцөл байдлыг харвал бид нар ерөөсөө мэдээж хэрэглэгч нь нас залуужиж байна. Тэгээд тэрэн дээр нас залуужиж байгаа нь бас энэ социал /social/ мэдээ, хэрэглээ, түүнтэй холбогдуулж бие биедээ нөлөөлөх энэ асуудал их өндөр байгаа юм байна.

2 дугаарт, энэ синтетик бодисын хэрэглээ нь өсөж байна. Лабораториор гаргаж авсан маш илүү хүчтэй, энэ бол маш том аюул. 3 дугаарт, манай Эрүүгийн хууль энэ мансууруулах бодистой холбоотой хэрэг бол дандаа дандаа эрүүгийн ял, эрүүгийн хариуцлага хэлбэр дээр тогтож ирсэн. Үүнээс урьдчилан сэргийлэх, дээр нь үнэхээр донтолтод өртчихсөн байх юм бол тэр хүүхэд, залуучуудаа сэргээн засах, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, сэтгэл засал, нийгэмшүүлэх хөтөлбөр ерөөсөө их бага байгаатай холбоотой байгаа юм байна гэж харж байгаа юм. Энэ хуулиар бол мэдээж энэ зүйлүүдээ шинэчлээд бүгдийг нь оруулж ирж байгаа байх.

Би онцгойлж асуух нэг юм байна. Энэ эмчилгээ, сэргээн засах тогтолцоо манай Монгол Улсад маш муу. СЭМҮТ дээр нэг хэдхэн юм байдаг, тэгээд СЭМҮТ ч юм уу, Аддиктологийн төв эд нар дээр гэхээр дандаа нэг архианаас гарах эмчилгээ хийдэг, ямар ч яг энэ бодист нь тааруулсан, яг энэ зан үйлд нь тааруулсан эмчилгээний арга барил манайд байхгүй юм байна лээ шүү дээ. Тэгээд арга барилыг нь оруулъя гээд гаднын ингээд туршлага яая гэхээр ерөөсөө хүлээж авах тийм орчин байхгүй, аргачлалынхаа дагуу явж байна гэдэг. Тэгээд энэ чинь дэлхий дахинаа аль аргачлал нь илүү үр дүнтэй юм бэ гэдэг нь ингээд гарчихсан байдаг. Тэгэхээр энэ чиглэлийн хуулийн зохицуулалт юу орж ирсэн бол гэдгийг эхлээд асууя?

Б.Баярбаатар: Хэн хариулах вэ? 3 номер дээр эхлээд хариулчих уу? 3 номер.

Д.Мөнх-Эрдэнэ: Номинчимэг гишүүний асуултад хариулъя. Донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний асуудал манай улсад үнэхээр орхигдсон байгаа. СЭМҮТ-ийн хэмжээнд бол яг энэ донтох эмгэгтэй, тэр дундаа мансууруулах донтох эмгэгтэй хүний хувьд ямар стандартаар, яаж эмчилгээ үйлчилгээ, тусламж, үйлчилгээ үзүүлэх вэ гэдгийг хэрэгжүүлж чадахгүй байгаа. Тийм учраас бид энэ хуулийн төсөл дээр энэ чиглэлээр тусгайлан бүлэг оруулж ирсэн. Бүлгийн зохицуулалт, энэ дээр бол 9 дүгээр бүлэг дээр тодорхой зохицуулалтууд оруулж ирж байгаа. Үнэхээр энэ донтох эмгэгтэй хүнд ямар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх юм, олон улсын стандартууд байгаа. Эмчилгээний арга зүй, цаг хугацаанаас авхуулаад, сэтгэл заслын үйлчилгээ, энэ донтох эмгэгтэй хүн эмнэлгээс гараад эргээд нийгэмшихэд нь туслах үе шаттай ажлууд байдаг юм байна лээ. Нэлээн хугацаа шаардсан, тэрнээс биш нэг сар эмчлээд хэвийн байдалд ордог ийм зүйл биш юм байна лээ.

Тийм учраас бид энэ олон улсын стандартыг Монголд нутагшуулах, одоо бас үйл ажиллагаа явуулаад энэ чиглэлээр мэргэшээд эхэлсэн төрийн бус байгууллагууд Монголд байна. Эдгээр байгууллагуудыг бэхжүүлж, энэ төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хамтарч ажиллах чиглэлээр хуулийн төсөл дээр тодорхой тусгасан байгаа. Түрүүн бас асууж байсан, ЗГ-ын тусгай сан байгаа, Архидан согтуурахтай тэмцэх. Энэ сангийн үйл ажиллагааг өргөжүүлж, мансууруулах, донтох эмгэгтэй хүмүүст тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр энэ сангийн үйл ажиллагааг өргөжүүлэх нь зүйтэй гэж үзэж байгаа. Тэгээд ингэж ЗГ-ын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулж, ТББ-тай хамтарч олон улсын стандартыг хэвшүүлж, ингэж үүрэгжүүлж, бас түрүүн хэлсэн, бид тусгай төв байгуулах нь зүйтэй гэж төсөв санхүүжилтийн асуудлыг нь, зураг төсвийн асуудлыг нь шийдээд ингээд явж байгаа. Тэгээд стандартын эмнэлэг, эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх төв нь байгуулагдчих юм бол бас тодорхой ахиц дэвшил гарах болов уу гэж бид харж байгаа.

Б.Баярбаатар: Номинчимэг гишүүн тодруулъя.

О.Номинчимэг: Энэ сан дээр төвлөрч байгаа хөрөнгө мөнгийг энэ донтолтоос урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэх, энэ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ рүү зарах нь зөв. Гэхдээ энэ сан чинь ерөөсөө байгуулагдсанаасаа хойш нэг ч удаа зарцуулалт хийгдэхгүй байна гээд байгаа шүү дээ. Тэрний яг учир шалтгаан нь юу юм бол? Би энэ хуулийг нь харахаар Архидан согтуурахтай тэмцэх энэ сангийн хууль дээр чинь зөвлөлтэй байна гээд заачихсан. Тэгэнгүүтээ зөвлөлийнхөө олон нийтийн төлөөлөл гэнгүүтээ архи импортлогчид, оруулж ирдэг тусгай зөвшөөрөлтэй үйлдвэрлэгчдийн төлөөлөл байна гээд оруулчихсан. Тэгээд зөвлөл дээр нь нэг тийм хүмүүс байж байдаг юм байна лээ шүү дээ. Тэгээд энэ зөвлөлийнхөө үйл ажиллагаа энэ дээрээ байгаад байдаг юм уу, эсхүл Сангийн яаман дээрээ байгаад байдаг юм уу? Та нар нэг тодорхой мэдээлэл өгөөч. Тэгэх юм бол хэрвээ дагаж орж ирж байгаа хууль дээр энийг хөндсөн бол бид нар ч гэсэн анхаарч ажиллахгүй бол би жишээ нь тамхины татварыг бид нар аваад санд үүсгэнэ гэвэл тамхи импортлогч нар тэнд байх юм бол тамхинаас урьдчилан сэргийлэх, тамхигүй үеийг бүтээхэд энэ ажлыг зарцуулахгүй нь ойлгомжтой байхгүй юу. Тэгээд яагаад ингээд хийчихсэнийг би ерөөсөө ойлгохгүй байгаад байгаа юм.

Б.Баярбаатар: 3 номер тодруулж хариулъя.

Д.Мөнх-Эрдэнэ: Номинчимэг гишүүний асуултад хариулъя. Сан бүрдсэнээс хойш бас түрүүн сайд хэлсэн, 23 тэрбум төгрөг төвлөрсөн байгаа. Ямар нэгэн зарцуулалт хийгдээгүй байгаа. Гол асуудал бол энэ сангийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнээс илүү бид Сангийн яамтайгаа ойлголцож энэ мөнгөө гаргах асуудал байгаа юм. Өөрөөр хэлбэл, яг үндсэн согтуурах, мансууруулах донтой хүмүүсийг эмчлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, нийгэмшүүлэх үйл ажиллагаанд зарцуулахад энэ зүйлээ ойлголцох ийм л төрийн байгууллагын асуудал байгаа. Нэгэнт энэ сан өөрөө согтууруулах ундааны литр тутамд хамаарах энэ 300 төгрөгийн орлогоос бүрдэж байгаа учраас бас энэ сангийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компани, ААН-үүдийн төлөөлөл байдаг. Тэгэхдээ энэ заавал байна гэсэн бас биш. Засгийн.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 4 дүгээр микрофон өгье.

Б.Батбямба: Номинчимэг гишүүний асуултад нэмж хариулъя. Сангийн яамны ТНБД, ХЗДХЯ-ны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Батбямба байна. Энэ ерөнхийдөө Төрийн хэмнэлтийн тухай хуультай их холбоотой байгаад байгаа юм. Яагаад гэхээр урьдчилан сэргийлэх ажлын ихэнх нь сургалт, нөлөөллийн арга хэмжээнүүд байдаг. Энэ төрлийн бүх арга хэмжээг Төрийн хэмнэлтийн тухай хууль гарсан цагаасаа хойш буюу 2023 оноос хойш, ялангуяа 2025 оны төсвийн хүндрэлтэй холбогдуулаад, ялангуяа 25 онд төлөвлөсөн бүх энэ нөлөөллийн арга хэмжээнүүдийг санхүүжүүлэх эрхийг зогсоочихсон.

Одоо энэ чиглэлээр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн төлөвлөсөн, 2025 онд зохион байгуулаад явж байсан ажлыг зогсоосноос болж, жишээ нь энэ зөвлөл сангаа зарцуулах нь битгий хэл 150 сая төгрөгийн, 149 сая төгрөгийн өртэй байж байгаа. Энэ жил 80 сая төгрөг төлөвлөе бид нар гээд Сангийн яамаар арайхийж зөвшөөрүүлсэн. Тэр маань бас хаалттай, зарцуулж чадахгүй ингээд оны эхэнд хагас жил дуусчхаад байдаг. Тэгэхдээ бид нар энэ ажлаа ерөөсөө зогсоогоогүй. ТББ, холбогдох бусад орон нутгийн салбар зөвлөлүүд, бусад олон нийтийн байгууллагуудтайгаа хамтраад энэ арга хэмжээг тасралтгүй явуулж байгаа. Тэгээд энэ төсвийн тодотголын хүрээнд харин.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

О.Номинчимэг: Сангийн яам аливаа татвар, хураамжийг ерөөсөө л төсвийн орлого бүрдүүлэгч гэдэг нүдээр харахаар яг ингээд зориулалтынх нь дагуу бид нар энэ донтолтоос урьдчилан сэргийлэх юман дээрээ мөнгө ерөөсөө тавьж чадахгүй байгаад байгаа байхгүй юу. Гэхдээ би бас ингээд харж байна л даа. Сая дагаж энэ Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль сангийн тухай зохицуулалттай хууль орж ирээгүй юм байна. Тэгээд энэний чинь удирдах зөвлөлийнх нь 70 хувь нь олон нийтийн төлөөлөл буюу архи импортлогчид, үйлдвэрлэгчид юм байна. Ийм хууль гэж юу байсан юм. Үнэхээр олон нийт байх юм бол энэ чиглэлийн тэр эмчилгээ, судалгаа хийдэг байгууллагуудаас нь оруулж, үр дүнтэй бодлого, сангийн зарцуулалтаа хийх нь зөв шүү дээ. Энүүгээр нь бид дахиад энийг хэлэлцэх эсэхийг нь дэмжсэний дараа хийхгүй бол архиа өгсөн, татвараа өгсөн хүн чинь бид ингээд хараад, хянаад сууж байна гэдэг бол их логикгүй л хууль байна, ашиг сонирхлын

зөрчил гарна энэ чинь. Удирдах зөвлөлийн 70 хувь нь энэ хүмүүсийн төлөөлөл байхаар байна шүү дээ.

Д.Цогтбаатар: Амарсайхан сайдад микрофоныг өгье.

С.Амарсайхан: 2 асуудал байгаа юм. 1 дүгээрт, сая Номинчимэг гишүүний хэлсэн энэ удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнд бид өөрчлөлт гэж байгаа. Энэ сангийн үйл ажиллагааг илүү нээлттэй, ил тод, үр дүнтэй явуулах зайлшгүй шаардлага байгаа 1 дүгээрт.

2 дугаарт, энэ хууль нэгэнт хэлэлцэж байгаа учраас бид бас төсөв, санхүүтэй холбоотой, ялангуяа урьдчилан сэргийлэх болон эмчилгээ, оношилгоонд зориулсан зардлыг тэр зохих сангийнх нь шугамаар олон нийтэд ил тод, нээлттэй, илүү өгөөжтэй хэлбэрээр зарцуулдаг байх зохицуулалтыг дагалдах хуулиудад оруулж өгөх зарчмын зөрүүтэй саналуудыг оруулж шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байгаа.

3 дугаарт, энэ хууль батлагдсанаар хүний нөөц болон бусад техник хангамжийн хэрэгжилтэд 8 тэрбум төгрөг гэж байгаа. Энэ бол урьдчилсан сэргийлэлт, урьдчилсан зардал. Тийм учраас би урсгал зардлууд дээрээ тавиад явчихад болно гэж үзэж байгаа хэдий ч цаашдаа энэ хууль батлагдаад бүрэн хэмжээнд үр нөлөөгөө өгөх тийм боломжийг бүрдүүлэхийн тулд бид хил, гаалийн хяналтаа сайжруулах, лабораторийн цогц шинэчлэлийг хийх, ялангуяа.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Гүйцээгээд хариулъя.

С.Амарсайхан: Тэгээд ялангуяа Хэмнэлтийн хууль гээд танаж хасаж болохгүй зардлуудаа бид нар хасчихдаг. Хүнсний лабораторийн аюулгүй байдал, нян бактерийнхаа урвалж бодисыг хасаад хаячихдаг, халдварт өвчин, янз янзын өвчин эмгэг тодорхойлох урвалж бодисоо хасаад хаячихдаг. Яг өнөөдрийн байдлаар ингээд яриад байвал гашуун үнэн асуудлууд их бий. Одоо энэ хар тамхийг шинжлэх, илрүүлэхтэй холбоотой бодис, урвалж, шинжилгээ, түргэвчилсэн гээд бүх зардлуудыг нь хасаад хаячихдаг учраас энэ дээр хийгдэх ажлууд хийгддэггүй явдаг. Тэгэхээр энэ төсөв дээр манай Байнгын хорооны бүх гишүүд маань анхаарч, энэ хөрөнгө оруулалтыг нэлээн дорвитой тавьж өгөхгүй бол цаашдаа олон улсын нөхцөл байдал, энэ гэмт хэргийн гаралт, сэдэлтүүд улам нарийсаад байдаг. Бид нөгөө бахь байдаг арга барилаараа л тэмцэх гээд яваад байдаг, араас нь хөөцөлддөг, урьдчилж сэргийлж чаддаггүй ийм нөхцөл байдлууд байгаа шүү гэдгийг хэлмээр байна.

Д.Цогтбаатар: Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Би хэдэн асуулт асуучихъя. Энэ яг үзэл баримтлалын хүрээнд нь нэг ийм зүйл тодруулмаар байх юм. Энэ хууль өөрөө хэрэглэж байгаа хүмүүстэй тэмцэх гээд байна уу, худалдан борлуулж байгаа хүмүүстэй тэмцэх гээд байна уу? Яг энэ асуулт урган гараад хэрэглэгч дээр барьж байгаа бодлого, ялын бодлого, нөхөн сэргээх бодлого, энэ худалдан борлуулж байгаа хүмүүс дээр баримтлах ялын бодлого зэргийг ялгаатай, ялгамжтай оруулж ирээгүй юм шиг харагдаад байх юм. Яг энэ хуулийн төсөлтэй хамт ирж байгаа танилцуулга, бусад мэдээллүүдийг харахаар ч гэсэн тоон статистик мэдээллүүдээ бас ерөөсөө ийм ангиллаар гаргаагүй байна. Хэрэглэгч донтогч, яг далд хэрэглэгч, дээрээс нь

борлуулагч, зуучлагч гээд маш олон ялгаатай талууд байгаа шүү дээ. Тэгэхээр яг энэ дээр одоо юу гэдэг юм ял шийтгэл авсан хүмүүс нь ихэнх нь хэрэглэгч байгаа юм уу, борлуулагч нар байгаад байгаа юм уу гэдгийг ерөөсөө тоон статистик мэдээллүүд ялгаагүй байна. Тэгэхээр яг нөгөө хуулийн үзэл баримтлалын хүрээнд та хэд маань яг хэнтэй нь тэмцэх гээд байна вэ гэдэг ийм асуулт?

2 дугаарт үүнтэй холбоотой яалт ч үгүй яг энэ ялын бодлогын асуудал гарч ирж байна. Ялын бодлогоо саяын миний энэ хэлээд байгаа яг энэ ангиллын хүрээнд яаж харж байгаа вэ? Тэрнээс хэдэн грамм хэрэглэснээрээ ял ялгамжтай байх тухай ойлгомжтой мэдэж байна. Гэхдээ илүү энэ хар тамхийг чинь илүү ингэж хууль бус зах зээлийг бий болгоод, илүү донтогчдыг бий болгоод, илүү их хэрэглэгчдийг бий болгоод, хүүхдүүдийг, залуучуудыг уруу татаад байгаа энэ худалдан борлуулаад байгаа яг энэ сүлжээн дээрээ ямар бодлого барьж байна вэ? Тэд нарт баримталж байгаа энэ ялын бодлогын талаар нэг тодорхой хэлээч гээд?

3 дугаарт, би яагаад энэ хэрэглэгч гэдэг дээр жоохон санаа зовоод байна вэ гэвэл илүү хэрэглэгч дээр төвлөрсөн бодлого манай улс баримтлаад байна л даа. Хэрэглэгчийг бид өвчтөн гэж харахгүй байна гэсэн үг. Хар тамхи дээр ч ялгаа байхгүй, архи дээр ч ялгаа байхгүй, бусад төрлийн донтолт дээр ч гэсэн яг ялгаа байхгүй. Мөрийтэй тоглоом ч гэсэн ийм үүн дээр орно. Архинд донтож байсан хүн донтолт нь эдгэхгүй эргээд тоглоомын донтогч болж байна гэх мэтээр. Тэгэхээр яг энэ нөгөө донтолттой тэмцэж байгаа арга барил, зүйлүүд дээрээ илүү бид нар яг хармаар байна. Тэгэхээр энэ дээр ямар бодлого байна вэ гээд.

Хамгийн сүүлийн асуулт, би буруу сонсоогүй бол энэ Баянхонгор аймагт сүүлд байгуулагдаж байгаа нэг албадан эмчилгээний төвийн асуудал энэ нь ямар үе шаттай яваа вэ? Хамгийн гол нь нэг байшин барилга барихаас гадна нөгөө албадан эмчилгээний чинь хөтөлбөр, программ, хүний нөөц хэр бэлэн байгаа вэ? Тухайн аймаг орон нутгийн иргэд энэ төвийн чинь талаар зөв ойлголттой байна уу, буруу ойлголттой байна уу, ер нь нэг жаахан ад үзэх маягтай л юм сонсогдоод байна. Манай аймгийг архины ийм эмчилгээ хийлгэдэг хүмүүсээр дүүргэлээ, нөгөө хүмүүс нь буцаж явахгүй гээд ингээд нийгэмд эдгээр хүмүүсийг ялгаварлан гадуурхах энэ суурийг.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Хэн хариулах вэ? 3 дугаар микрофон.

Д.Мөнх-Эрдэнэ: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Өнөөдөр сүүлийн 9 жилийн байдлаар бидэнд байгаа статистик тоон мэдээлэл бол 2100 гэмт хэрэгт 2422 холбогдогч байгаа. Өөрөөр хэлбэл жилд дунджаар 233 хэрэг үйлдэгдэж байна гэсэн үг. Эндээс өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуулиар бид 5 төрлийн, багцалж хэлбэл үйлдэл, ял шийтгэлийн бодлого хэрэгжиж байгаа. Нэг нь бол хүүхдийг байнгын мансуурах байдалд татан оруулсан, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис ашиглах буюу хууль бусаар бэлтгэсэн, боловсруулсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, худалдсан, бусдад өгсөн, олж авсан, 3 дугаарт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх орон байраар хангасан, 4 дүгээрт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг албан тушаалтан, албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөгөө урвуулан ашиглаж завшсан, 5 дугаарт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын түүхий эдийг хууль бусаар тариалсан, ургуулсан үйлдлүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа.

Энэний цаана мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэх, түүх, хэрэглэх, ашиглах, дамжуулах, зуучлах, үйлдвэрлэх, тээврийн хэрэгслээр хангах, хууль бусаар эргэлтэд оруулсан гэх мэт олон үйлдлүүдэд ямар нэгэн эрүүгийн хариуцлага байхгүй. Зарим тохиолдолд Зөрчлийн хуулиар торгуулаад өнгөрч байгаа. Тийм учраас таны хэлээд байгаа статистик судалгаа гарвал ял шийтгэлийн бодлогын гэвэл маш олон үйлдлүүд нийгмийн аюулын шинж чанар, хор хохирлын хувьд бүр илүү, орон байраар хангахаас илүү аюултай, жишээ нь, үйлдвэрлэх гэсэн үйлдэл өөрөө эрүүгийн ял шийтгэлийн бодлогод хамрагдахгүй байгаа, өөрөөр хэлбэл торгуулаад л өнгөрч байгаа. Тийм учраас бид 61 оны, 71 оны, 89 оны НҮБ-ын конвенцоор хүлээсэн үүргийнх нь дагуу энэ аюултай үйлдэл болгоныг буюу одоо ямар нэгэн үйлдэл орхигдуулахгүйгээр ял шийтгэлийн бодлогод хамруулж, хариуцлага тооцохоор болж байгаа.

Энэ дундаа байнгын зохион байгуулалттай үйлдэж байгаа гэмт бүлэглэлүүдэд чиглэсэн ялын бодлогыг чангатгаж байгаа. Энэ юунаас хамаарч байна гэхээр хувийн хэрэглээнээсээ гадна тун хэмжээндээ, өөрөөр хэлбэл олон улсад байгаа нэг жишгийг харахаар ерөнхийдөө 50 грамм хүртэл, мэдээж бодисын төрөл төрлөөс хамаараад янз бүр байгаа юм. Жишээлбэл, канабис /cannabis/ дээр ярихад 50 грамм хүртэл бол бага хэмжээтэй, 50-иас дээш 100 гээд явчих юм бол их хэмжээтэй, 500 граммаас их бол онц их хэмжээний гээд. Тэгэхээр энэ болгоны цаана гэмт үйлдлийн цаад санаа зорилго, нийгмийн аюулын шинж чанар байгаа учраас ингэж бид ялын бодлогыг.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Гүйцээгээд хариулъя. Яагаад гэвэл наадах чинь чухал сэдэв яриад байна. 3 дугаар микрофон.

Д.Мөнх-Эрдэнэ: Дараагийн таны асуултад хариулахад, ер нь донтох эмгэгтэй хүмүүсийг ял шийтгэж, эрүүгийн хариуцлагад татахаасаа илүү бид энэ олон улсын жишиг ч ер нь тийшээ чиглэж байна. Бага хэмжээний хэрэглээн дээр энэ хүмүүсийг эмчлэх, донтох эмгэгээс нь салгах чиглэлээр бид хуулийн концепц өөрчлөлт оруулж ирж байгаа юм. Одоо жишээ ярихад, шүүхийн шийдвэрийн дагуу албадан эмчлэх мансууруулах донтой эмгэгтэй хүнийг ШШГЕГ-ын харьяанд албадан эмчлэх ийм хуулийн зохицуулалт өнөөдөр байгаа. Энэ хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж, хуулийн төслийг боловсруулж байх үед жишээ нь шүүхээс ямар нэгэн байдлаар албадан эмчлэх шийдвэр гаргасан тохиолдлууд байгаагүй. Харин ЗГ-ын хуралдаанаар хэлэлцсэн энэ үеэр 2 тохиолдол гарсан. Одоо өөрөөр хэлбэл шүүх бас энэ хуулийн хэрэглээг.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон.

Д.Мөнх-Эрдэнэ: Албадан эмчлэх энэ шийдвэр гаргаж эхэлж байна. Өөрөөр хэлбэл, мансуурах донтой, донтох эмгэгтэй хүнийг ШШГЕГ-ын харьяа энэ Мааньт дахь эмнэлэг дээр, шоронгийн тэр юун дээр албадан эмчлэх ийм шийдвэр гаргаж, одоогийн байдлаар 8 хүнийг албадан эмчилгээнд хамруулахаар ийм шийдвэр гараад явж байгаа. Тэгээд энэ ингээд цаашдаа бид олон улсын эмчилгээний стандарт, эмчлэх хөтөлбөр, энэ бүх зүйл дээр анхаараад явна гэсэн үг.

Д.Цогтбаатар: 4 дүгээр микрофон.

Б.Батбямба: Нэмээд хариулъя. Ер нь энэ албадан эмчлэхтэй холбоотой, сайн дурын эмчилгээтэй холбоотой асуудал их эмзэг сэдэв болчихоод байгаа. Иргэд нэг хэсэг нь сайн дураараа эмчлүүлэхээр ханддаг, ялангуяа архи ч бай, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис ч бай. Тэгэхээр ерөнхийдөө яг төвлөрсөн манай улсын мэдлийн эмнэлгүүд дээр хийж байгаа эмнэлгийн үйлчилгээ маань хүртээмжтэй биш. Тийм учраас хувийн хэвшлийнхэн, бизнесийн байгууллагууд энэ зарим төрлийн үйл ажиллагааг явуулдаг.

Өмнөх жишээнүүдээс харахад, ялангуяа Баянхонгор аймагт анхлан эхэлж энэ Итгэл төслийг бид нар хэрэгжүүлж үзсэн, Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, тэгээд аймгийн салбар зөвлөл, нийслэлийн зөвлөлтэйгөө хамтраад. Дараа нь нийслэл хотод, нийслэлийн хэмжээнд 2 жил хэрэгжүүлсэн. Дараа нь Баянзүрх дүүрэг дээр хэрэгжүүлсэн, болох юм байна гэж үзсэн. Тэнд бол хэн хамрагдсан бэ гэхээр, мэдээж архинд гүн донтсон иргэд хамрагдсан, голдуу сайн дураараа. Тэгэхдээ хороо, сум, дүүргийн холбогдох байгууллагуудаас бид засаг захиргааны анхан шатны нэгжээсээ судалгаа аваад ерөнхийдөө.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 4 дүгээр микрофон, гүйцээгээд хариулъя.

Б.Батбямба: Үзсэн хүмүүсээ 2021 оноос 2023 он хүртэл ингээд 3, 4 жилийн дотор эмчилж үзсэн, болох юм байна гэж харсан. Энэ туршлагыг бас нэлээн сайн хэрэгжүүлж, Эрүүл Монгол хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бас нэлээн ахиц гаргасан гэдэг утгаараа Баруун бүсийн эмчилгээний төвийг Баянхонгор аймагт байгуулахаар шийдвэрлээд, барилгын ажил нь одоо явагдаж байгаа. 7 тэрбум гаруй төгрөгийн төсөвтэй, ер нь ирэх ондоо багтаад үйл ажиллагаа нь жигдрээд явах байх гэсэн ийм төлөвтэй байгаа. Зүгээр жишээлээд хэлэхэд, ялангуяа тэр донтолтын эсрэг хэрэглэдэг гол эмүүд байгаа. Яг Монгол Улсад орж ирж байгаа яг шаардлага хангасан эмийг тухайн үеийн ханшаар тооцоод үзэхээр 100-аас 120 мянган төгрөгт ингээд аваад хэрэглээд болчихдог. Тэр хүн сайн дураараа эмчлүүлэхээр сая гараад явчихдаг. Тийм учраас улсын яг энэ хуулийн зохицуулалтын хүрээнд тэр эмчилгээ, үйлчилгээнийх нь чиг үүргийг тодорхой болгож байгаа юм. Эрүүл мэндийн байгууллага юуг нь хариуцах юм, төрийн бус байгууллагууд ямар оролцоотой байх юм, бусад эрх бүхий субъектүүд, орон нутаг, аймаг нь ямар байх юм гэдэг дээр бас ялгаа заагийг нь оруулж өгч байгаа учраас дараа нь энэ хүрээндээ ингээд энэ төвүүдээ түшиглээд.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 4 дүгээр микрофон гүйцээгээд хариулчих.

Б.Батбямба: Тэгэхээр иймэрхүү байдлаар иргэдэд дарамт, санхүүгийн дарамт үүсгэхгүйгээр энэ хуулийн үйлчлэл явагдаад эхлэх юм бол энэ хугацаанд бас зарим барилга байгууламжийн ажлууд жигдрээд явах байх. Тийм учраас хэрвээ энэ хуулийн зохицуулалт хэрэгжээд эхэлсэн тохиолдолд бол ялангуяа энэ донтолтоос урьдчилан сэргийлэх, эмчлэх чиглэл дээр чиг үүрэг нь тодорхой болно, тодорхой үр дүнгүүд гарах болов уу, эмчилгээний зардал, хэдийгээр урсгал зардлууд яригдаж байгаа ч гэсэн нэг тухайн иргэндээ хамааралтай зардлууд маань бодитойгоор буурна гэсэн ийм тооцоо судалгаа гаргасан байгаа.

Д.Цогтбаатар: Болсон, тодруулах уу? Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Баярлалаа. Тэгээд нөгөө яах вэ би хэрэглэгч, тэр дундаа хэрэглэгч хүүхэдтэй холбоотой зохицуулалтыг яг энэ хуулийн төсөл дотроос хайгаад олсонгүй. Ялангуяа хүүхэд, бага насны, өсвөр насны хүүхдүүд яг хэрэглэгч болж байгаа тохиолдолд ямар үйлчилгээ, ямар зүйл дээр илүү анхаарах юм, ямар асуудлыг бид нар анхаарах юм, үйлчилгээнийх нь өөрийнх нь дэд бүтэц нь яаж явах юм гэдэг зүйл ерөөсөө холбоос, яг нөгөө процессын холбооснууд ерөөсөө харагдахгүй байгаа байхгүй юу. Нөгөө Хүүхэд хамгааллын хуультай, нөгөө хууль зүйн хороотой гээд, ингээд нөгөө шүүхтэйгээ гээд ингээд ерөөсөө уялдаа нь харагдахгүй байгаад байна. Энийг нэг анхаарах ёстой болох байх.

2 дугаарт, энэ бидний нэг айтгар 2018 онд шинэчилсэн найруулгаар баталсан Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль гэж баталсан байгаа. Тэгээд энэ хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ өөрөө энэ одоо манай бидний хэлэлцэж байгаа энэ хуулийн төслийн чинь аягүй чухал хэсэг нь байхгүй юу. Энэ ерөөсөө огт байхгүй байгаад байх юм, энэ тарааж.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Хэн хариулах вэ? 3 дугаар микрофон.

Д.Мөнх-Эрдэнэ: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Энэ донтох эмгэгтэй хүнийг, тэр дундаа хүүхдийн хувьд яг ямар эмчилгээний арга зүй, сэтгэл заслын үйлчилгээ байх вэ гэдэг бол олон улсын стандарт байдаг юм байна лээ. Тийм учраас бид энэ хуулийн төслийнхөө 9 дүгээр бүлэгт яг төрөлжүүлж хүүхэд гэж бичээгүй ч гэсэн энэ донтох эмгэгтэй хүнд үзүүлэх тусламж, үйлчилгээ, үзүүлэх үйлчилгээний төрөл бүрээр нь бүлэглэж бичсэн байгаа. Бид бас дутуу зүйл байвал ажлын хэсгийн хүрээнд та бүхэнтэй хамтарч ажиллаж, илүү тодорхой болгох талаас анхаарч ажиллая гэж бодож байна. Түрүүн би бас таны асуултад хариулж байхдаа хэлж байсан. Үнэхээр үнэн, тэр хуулийн хэрэгжилт.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон, гүйцээгээд хариулъя.

Д.Мөнх-Эрдэнэ: Хангалтгүй байгаа. Шүүхийн практикт сая харин энэ жил 8 тохиолдол гарч байна. Өөрөөр хэлбэл, мансуурах донтой энэ эмгэгтэй хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх энэ шийдвэр шүүхээс гаргаж, одоо манай ШШГЕГ-ын харьяа Мааньт дахь эмнэлэг дээр албадан эмчилгээ хийлгэж байгаа. Өөрөөр хэлбэл, хуулийн хэрэглээ одоо л ингэж бий болж байна гэсэн үг. Өмнө нь ерөөсөө энэ албадан эмчилгээнд хамруулах ийм шүүхийн шийдвэр гарч байгаагүй. Тэгэхээр бид цаашдаа энэ асуудал дээр анхаарч ажиллая гэж бодож байна.

Д.Цогтбаатар: М.Нарантуяа гишүүн, тэгээд С.Эрдэнэболд гишүүн асуулт асуух уу түрүүн асууя гээд тэгж байсан? Тусдаа. Нарантуяа-Нара гишүүн.

М.Нарантуяа-Нара: Сайн байцаана уу. 2024 онд Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд СЭМҮТ дээр ажиллаад ирсэн. Тэгж байхад архинаас гаргах эмчилгээ, ийм сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг багийн эмчилгээ гэж байдаг юм байна лээ. Тэгээд тэр эмчилгээний хүмүүс ярьж байсан л даа, саяхан манайд хар тамхи хэрэглэдэг залуу сайн дураараа ийм эмчилгээнд хамрагдаад гарч болдог уу гээд асуугаад ирж байсан, даанч манайд тийм юм байдаггүй болохоор бид одоо байхгүй гээд л, тэгээд л тэр залуу явсан гэж. Энэ хар тамхи татдаг хүмүүс чинь одоо жишээлбэл, жилийн 365 хоног, 24/7 байнгын мансуураад байж байна гэж байхгүй шүү дээ. Энэ хүмүүс чинь заримдаа эрүүл болсон цагтаа харамсдаг, харамсаад,

харамсдаг болоод л тэнд одоо СЭМҮТ дээр оччихсон, ийм эмчилгээ байна уу, би эндээс гармаар байна гээд явж байгаа шүү дээ. Тэгэхээр ийм юм бол мэдээж байдаг юм шиг байгаа юм.

Харин бид яг нийтээр одоо орчихсон байгаа хүмүүсээ яаж энэ хар тамхинаас гаргаж авах вэ гэдэг нэг асуудал, дээрээс нь урьдчилан сэргийлэх асуудлыг энд нэлээн их тусгасан байгаа боловч судалгаа жоохон бага байгаа юм уу гэж би хувьдаа харлаа. Ялангуяа Монгол хүний сэтгэл санааны, сэтгэл зүйн байдлын онцлог гэж юу байдаг юм бэ, тэрэнд суурилад, жишээлбэл, гадаадад ч гэсэн сошиал дээр ялангуяа идэвхтэй байдаг хүмүүс маш сайн мэдэж байгаа. Гадаадад хар тамхинд орчихсон байж байгаад, олны нүдэн дээр элдэв янз болж байгаад сүүлдээ тэр сопер /sober/ ч билүү, юу билээ тийм эмчилгээнд явж байгаад эрүүл болоод, тэрийгээ ингээд Монголчуудтайгаа хуваалцаад, туршлага, онол нь ямар байдаг юм, практик нь ямар байдаг юм гээд маш сайн хуваалцдаг. Тэгэхээр та нар энэ хуулийг юу яахдаа яг ийм байдалд ороод гарсан хүнтэй уулзаад, ярилцаад, туршлага судалсан, сэтгэл зүйн байдлыг судалсан тийм зүйлүүд байна уу 1 дүгээр асуудал?

2 дугаар асуудал, хар тамхи ялангуяа татдаг байж байгаад гэмт хэрэг үйлдээд, хар тамхи татсан гэдгээр биш гэмт хэрэг үйлдсэнээрээ одоо хорих ялаар шийтгэгдэж байх хугацаандаа нас барсан ийм байдлууд гарч байгаа шүү дээ. Тэгэхээр яг энэ нөхцөлд мансууруулах бодисоос холбоо хамааралтай, нөлөө бүхий хэрэглээтэй, тэрүүгээрээ одоо бас юу гэдэг юм, эрүүл мэнд нь хямардаг ийм хүмүүсийг хорих явцад тусгай ямар нэгэн юу гэдэг юм хуучин өнгөрсөн туршлага дээр болсон явдал дээр тулгуурлаад одоо жишээлбэл ямар арга хэмжээ авч байгаа юм бол? Хоригдож байх хугацаанд тэр хүний сэтгэл зүйн болон эрүүл мэндийн нөхөн сэргээх гэх үү, тэр холбоо хамааралтай байгаа зүйлийг нь юу гэдэг юм бол би сайн хэллэгийг нь мэдэхгүй байна, гэхдээ энийг шийддэг арга механизмыг энд хэрэгжүүлэх тухай орсон байгаа юу?

Д.Цогтбаатар: Тодруулах уу? 1 дүгээр микрофон.

Б.Түмэндэмбэрэл: Та бүгдийн энэ өдрийн мэндийг хүргэе. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Эрүүл Монгол үндэсний хөдөлгөөний дэргэдэх Сэтгэц, нийгмийн сэргээн засах төвийн зохицуулагч Түмэндэмбэрэл байна. Хуулийн ажлын хэсэгт орж ажилласан, би өөрөө донтох эмгэгийг судлаач хүн. Сүүлийн 20 гаруй жил Япон улсын сэргээн засах тусламж, үйлчилгээг энэ улсад нэвтрүүлэх гэж явж байгаа ийм хүн байгаа юм. Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагаас гаргасан бодисын хэрэглээний эмгэгийг эмчлэх олон улсын стандарт /international standard/ гэж байгаа. Энэ эмчилгээний арга аргачлалыг ерөөсөө энэ хуулиар зохицуулж, бид эмчилгээний арга аргачлалаа бий болгохыг зорьж байгаа.

18 онд урьдчилан сэргийлэх арга аргачлалыг НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудаас гаргасан. Харамсалтай нь, манай улс энэ 2 арга аргачлалыг, стандартыг өнөөдрийг хүртэл эмчилгээ үйлчилгээ, урьдчилан сэргийлэх хөтөлбөр, арга хэмжээнд хэрэглэхгүй ирсэн байна. Донтох эмгэгийн эмчилгээ гэдэг бол эмнэлэгт суурилсан эмчилгээний хэсэг, нийгэм хамт олонд суурилсан эмчилгээний хэсэг гэж 2 бүлэгт хуваагдаж үздэг. ЭМД-аар СЭМҮТ, Аддиктологийн төв хордлого, шарталтын эмчилгээ хийчхэж байгаа. Яг донтох эмгэгийн зан үйлийг засахад Нарантуяа-Нара гишүүний асуугаад байгаа энэ сэтгэл заслын тусламж, орхигдож ирсэн манай улсад.

24 оноос эхлээд миний ажиллаж байгаа Сэргээн засах төв энэ төрлийн тусламж, үйлчилгээг улсдаа жишиг төв болж ажиллаж эхэлсэн. 25 онд 78 бодисын асуудал буюу хар тамхины хамааралтай хүнд тусламж, үйлчилгээ үзүүлсэн. Эмчилгээний үр дүнг авч үзвэл 30 хэдэн хувийн дахилтгүйгээр явж байна. Бидэнд тулгамдаж байгаа асуудал юу гэвэл ерөөсөө боловсон хүчний асуудал. Энэ чиглэлээр мэргэжилтнээ сургах, мэргэшүүлэх, зан үйлийн эмчилгээ явуулах, нотолгоонд суурилсан эмчилгээний хөтөлбөр, арга аргачлалыг боловсруулж эмчилгээний практикт нэвтрүүлэх ажлууд их хоцрогдсон. Энэ хуулиар эдгээр бүх зүйл зохицуулагдах боломж нээгдэж байгаа. Баярлалаа.

Д.Цогтбаатар: 2 дахь асуултад хэн хариулах вэ? 3 дугаар микрофон.

Д.Мөнх-Эрдэнэ: Нарантуяа-Нара гишүүний асуултад хариулъя. Яг үнэн, энэ мансуурах, донтох эмгэгтэй хүн бусад хүмүүстэй цуг хоригдохоороо бусдыгаа уруу татдаг, давтан үйлддэг тохиолдол олон байгаа. Тийм учраас цаашдаа эдгээр хүмүүст зориулсан тусгай хөтөлбөрийн хүрээнд тусад нь тусгаарлаж цагдан хорьдог ийм зохицуулалтыг хуулийн төсөлд тусгаж байгаа. Өөрөөр хэлбэл, хуулийн төслийн 8 дугаар бүлэг дээр энэ асуудлыг тусгаж өгч байгаа. Тэгэхээр яг энэ хүмүүсийн үйлдсэн гэмт хэрэг, нийгмийн аюулын шинж чанар, хувийн зан байдалтай нь тохирсон энэ цагдан хорих орчин нөхцөлийг бүрдүүлж, энэ хүмүүсийн сэтгэл зүйтэй ажиллах, дахин аль болох энэ төрлийн гэмт хэрэг үйлдэхгүй байх, бас бусдын.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон, гүйцээх үү? Нарантуяа-Нара гишүүн тодруулж асууя.

М.Нарантуяа-Нара: 2 дахь асуудал дээр жоохон буруу ойлгосон юм шиг байна. Миний бодлоор бол хоригдож байх хугацаандаа бусдыг уруу татах боломж байдаг юм уу, тэр газарт хоригдож байгаа газарт нь. Би бол яах вэ яриагаараа ч юм уу тийм боломж бол байдаг байх гэхээс биш тийм мансууруулах бодисоо аваад орох боломж бол байхгүй биз дээ тийшээ, байхгүй. Тэгэхээр миний бодлоор хамгийн гол нь тэнд уруу татах гэхээс илүү тэнд өөр, мансууруулах бодис хэрэглэдэг гэдгээсээ өөр шалтгаанаар хоригдож байгаа хүнд тэр байнгын жишээлбэл энэ нийгэмд байхдаа бол ямар нэгэн аргаар хулгай зэлгий хийгээд ч хамаагүй тэрийгээ татаад байна. Тэгээд бие, эрүүл мэнд нь тэрэндээ дасан зохицоод яваад байна шүү дээ. Гэтэл өөр хэргээр хоригдож байх хугацаандаа тэр нөгөө юм нь байхгүй болчихоор, байнга хэрэглэдэг юмаа нэхээд тэр чинь ингээд одоо хямрал өгөөд нас барчихсан байгаа байхгүй юу. Тэгэхээр угтаа бол тэр хүн хэрэг хийсэн ч гэсэн.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Нарантуяа-Нара гишүүний микрофоныг гүйцээгээд өгье.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр тийм нөхцөл байдалд байгаа хүмүүсийн сэтгэл зүйн болон тэр хүний төлөөх, тэр хүний эргэн тойронд байгаа уруу татагдаж болзошгүй хүмүүсээс илүүтэйгээр тэр хүнийг нөгөө амьд байгаад, хийсэн хэрэгтээ ялаа хүлээгээд, буцаагаад нийгэмд гараад эрүүл саруул хүн амьдрах тэр боломжоор хангах тухай яриад байгаа байхгүй юу. Тэгээд дээрээс нь, хамгийн гол нь тэр хүний эрүүл мэндийн тухай яриад байгаа байхгүй юу. Гэтэл бид хангаж чадахгүй аль хэдийн алдчихсан ийм кэйс байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр тэрийг бол ингээд тусгаарлах шаардлагатай байна, нөгөө хүмүүст муу нөлөө үзүүлэхийг нь, муу нөлөө үзүүлэхийг тусгаарлах шаардлагатай байна. Нөгөө талаар

тусгаарласан хүнээ сэтгэл зүйн, сэтгэл санааны болон бие, эрүүл мэндийн тэр одоо treatment-г яаж хийх вэ гэдэг асуудлыг тусгах шаардлагатай байгаа байхгүй юу. Би бол тэгж бодоод байна.

Д.Цогтбаатар: Амарсайхан сайдын микрофоныг өгье.

С.Амарсайхан: Нарантуяа-Нара гишүүний дурдаж байгаа маш зөв асуултууд байна. Яг энэ хууль батлагдаж байгаа гол зорилго, батлагдах гол зорилт нь бол яг л энэ чиглэл рүү явах ёстой юм. Бид ер нь хуулийг мэдээж хязгаарлах гэдэг юм уу, торгох, шийтгэх, яллах гэхээсээ илүүтэй 1 дүгээрт хууль өөрөө сэргийлэх, таслан зогсоох, урьдчилан хамгаалахад чиглэсэн байх ёстой.

2 дугаарт, хууль бус үйлдэл хийж байгаа аливаа иргэн хүнтэй хуулийн дагуу хатуу хариуцлага тооцож хязгаарлаж байх ийм л үндсэн 2 зорилго. Гэхдээ бид өнгөрсөн хугацаанд урьдчилан сэргийлэх ажлаа хангалттай хийж чадаагүй. Яг саяынх шиг ангилах, ялгах, дээрээс нь эмчлэх, нөхөн сэргээх, нийгэмшүүлэх, тэгээд цаашдаа донтогч байна уу эсхүл хэрэглэгч байна уу даамжрахгүй байхын тал дээр хийсэн ажлууд маш хомс. Тийм учраас өнөөдрийн тавьж байгаа энэ асуултууд дурдагдаж байгаа.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Амарсайхан сайдын микрофоныг, гүйцээгээд хариулъя.

С.Амарсайхан: Тэгье. Би энд бүр зориуд нэг зүйлийг тодруулж хэлье гэж байгаа юм. Мэдээж холбогдох байгууллагууд ажлаа хийж байна, тэгээд хангалттай хийж чадахгүй байна. Яг энэ хар тамхитай бол хэдэн мөрдөгчид өдөр шөнөгүй, цалин хөлс нь хангалтгүй, орон тоо нь хүрдэггүй, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, бодис урвалжууд нь байдаггүй. Үндсэндээ одоо нөгөө монголчилсон аргаар тэмцэж байна гэж хэлж болно. Энийг бид ерөөсөө хаана ч мартаж болохгүй 1 дүгээрт.

2 дугаарт, өнөөдрийн энэ албан тоонууд зүгээр дурдагдаж байгаа тоо бол яг нийгэмд хор нөлөө үзүүлж байгаа тооноосоо хэдэн 10, хэдэн 100 дахин бага орж ирж байгаа гэж та бүхэн харж байгаа байх.

3 дугаарт, энэ чиглэлийн үйл ажиллагаануудыг цааш нь нэлээн эрчимтэй явуулахгүй бол энэ өөрөө манай нийгмийн хар тахал болж хувирах ийм үзэгдлүүд байна. Өнөөдрийн өсвөр насны хүүхдүүдийн дунд байгаа, дээрээс нь одоо хэрэглэгч рүү чиглэсэн байсан бол сүүлийн үед бид ажлын хэсэг байгуулж.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Гүйцээх үү? Амарсайхан гишүүний микрофоныг өгье.

С.Амарсайхан: Ажлын хэсэг байгуулж тэр хангадаг, нийлүүлдэг, ялангуяа Зүүн Өмнөд Азийн улс орнуудаас энэ чиглэлийн синтетик бодисыг үйлдвэрлэдэг, нийлүүлдэг, энэ хар тамхийг хангадаг, нийлүүлдэг нөхдүүд чинь манай Монгол Улсыг үндсэндээ бай болгочихсон байгаа. 2 том гүрний дунд байдаг хамгийн том боломжтой, хамгийн сул хяналтай, хамгийн хурдан хэрэглээнд нэвтрүүлж, хамгийн хурдан уусгаж авах ийм боломжтой гэж тодорхойлсон байгаа. Энийг бид биш, бүр НҮБ-ын олон улсын томоохон байгууллагуудын судалгаагаар хүртэл гарч байгаа. Тэгэхээр энэ дээр энэ хуулиас гадна бид энэ хуулийг хэрэгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх, богино хугацаанд үр дүнтэй ажлуудыг чиглэл бүрээр хийж байж хазаарлаж авахгүй бол энэ өөрөө хяналтаас гарах ийм эрсдэлүүд байна гэдгийг маш сайн тооцож, энэ хуулийг эцэслэж батлах ёстой гэж бодож байгаа юм.

Д.Цогтбаатар: Нарантуяа-Нара гишүүнд, танд би илүү цаг өглөө шүү, хариулъя.

М.Нарантуяа-Нара: Энэ нөгөө нэг ингэж сонсож байсан юм л даа. Жишээлбэл, хар тамхи хэрэглэдэг гээд, тэр нь мэдэгдэх юм бол шууд цагдаа очоод барьж авдаг, хорьдог гэж сонсож байсан. Энэ үнэн үү? Үнэн бол энэ өөрөө нөгөө шууд барьж байгаа, хорьж байгаа байдал чинь хүнийг сайн дураараа “би ийм юм хэрэглэдэг болоод, энэнээсээ эндээ ингээд донтоод байна, гэхдээ би энэнээсээ гармаар байна, энийг болиод би хүн шиг сайхан амьдармаар байна” гэдэг энэ байдлыг шууд хаагаад байгаа юм шиг санагдаад байгаа байхгүй юу. Хүн мэдээж ингээд давхар хэрэгцээтэй болчихсон байна, давхар асуудалтай болчихсон байна, тэрний дээр давхар хоригдоод, ар гэрийнхэндээ бүр дахиад ийм том, том дарамтууд авчрах вий гэдгээс айдаг болчихож байгаа юм шиг санагдаад байна. Тэгэхээр хэрвээ хууль нь ийм байдаг бол энэ хуулийг зайлшгүй эргэж харах ёстой бөгөөд тэр талаар энд орсон байгаа юу гэдгийг нэг тодруулчихъя.

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон.

Д.Мөнх-Эрдэнэ: Нарантуяа-Нара гишүүний асуултад хариулъя. Одоо бол хэрэглэсэн хүн, энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хүмүүс бол шууд одоо Зөрчлийн болон Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээж байгаа. Бидний одоо хуулийн шинэ өөрчлөлтөөр бол хүн өөрөө сайн дураараа эмчлүүлэх гээд ирвэл тэр хүнд хариуцлага хүлээлгэхээсээ илүү эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх энэ чиглэлээр боломж олгох чиглэлээр хуулийн өөрчлөлтийг хийж өгч байгаа. Өөрөөр хэлбэл хэрэглэгч зохион байгуулагч биш, худалдан борлуулагч биш, энэ үйлдлийг байнга санаатай давтан үйлдэж байгаа хүн биш хэрэглэгч хүн өөрөө сайн дураараа “Би эмчилгээнд хамрагдах” гэж ирж байгаа тохиолдолд энэ хүмүүст эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, энэ чиглэлээр донтох эмгэгээс нь салгах чиглэлээр хуулийн төслийг боловсруулсан гэдгийг хэлье. Дараагийн асуултад манай цагдаагийн байгууллагаас тодруулж нэмж хариулна.

Д.Цогтбаатар: 1 дүгээр микрофон.

Э.Товуудорж: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амрыг эрье. ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх албаны дарга, цагдаагийн хурандаа Товуудорж байна. Нарантуяа-Нара гишүүний асуултад хариулъя. Монгол Улсад сүүлийн 9 жилийн байдлаар бол нийт 49 хүн нас барсан байдаг, он цагийн дарааллаараа бас бүртгэлтэй. Энэ бол Шүүх шинжилгээний ерөнхий газраас авдаг тоон мэдээ байгаа. Сүүлийн 3 жилийн байдлаар бол Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын 461 дүгээр хорих ангид хоригдож байсан, манай санд бүртгэлтэй нэг иргэн 3 дугаар эмнэлэг дээр очиж эмчилгээ хийлгэж байгаад нас барсан асуудал гарсан. Энэ бол Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын эмчлэх, тусгаарлах асуудал бол Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын асуудал болохоор ингээд орхиё. Дараагийн дугаарт, хар тамхи хэрэглэж байхад нь шууд барьдаг уу гэдэг асуудал, энэ бол.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 1 дүгээр микрофоныг гүйцээгээд өгье.

Э.Товуудорж: Өнөөдөр Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн дагуу цагдаагийн байгууллага хар тамхи, мансууруулах бодис хэрэглэсэн

иргэнийг баривчлах, шалгах үүрэгтэй. Энэ үүргийнхээ хүрээнд холбогдох ажиллагаагаа хийгээд явдаг гэдгийг хэлье. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Гишүүд асуулт асууж дууслаа. Би хэдэн юм асуучихъя. 1 дүгээрт, Цагдаагийн хуулийг би нэмэлт, өөрчлөлтийг би өргөн барьсан байж байгаад сая цагдаагийн байгууллагын өөрийнх нь хүсэлтийн дагуу эргүүлэн татаад авчихсан байж байгаа. Ахиад тэрэн дээр нэлээн хэдэн санаанууд оруулж байгаад өргөн барина гэж байгаа. Манай Байнгын хорооны гишүүд энийг анхаарч байгаад бид дэмжих хэрэгтэй байгаа. Яагаад гэвэл яг тэр Цагдаагийн хуульд одоо энэнтэй холбоотой санаа, олон улсын хамтын ажиллагааны асуудлууд нь орж өгсөн байгаа байхгүй юу. Олон улсын хамтын ажиллагаагүйгээр хэдүүлээ энэ бор зүрхээрээ тэмцээд дийлнэ гэж бол ерөөсөө тийм ойлголт байхгүй шүү, дийлэхгүй. Тийм учраас тэр олон улсын хамтын ажиллагаа бол өөрөө аягүй чухал байгаа. Тэр цагдаагийн хуулиа, 1 дүгээр асуулт, тэнд орсон санаануудаа энэндээ бас тусгаж, ер нь энэнтэйгээ уялдуулсан байгаа юу, тэрийгээ боловсруулахдаа?

2 дахь асуулт бол энэ дотоод хяналт, ялангуяа цагдаагийн байгууллага энэнтэй хууль хэрэгжүүлэх тал дээр тэмцэж байгаа байгууллагын хувьд дотоод хяналтынхаа механизмыг энэнд хэр тусгаж өгсөн байгаа вэ? Одоо энэ тэмцлийн асуудал дээр бол хэрэглэгч, олон үе шатны байгууллагуудын тухай ярьж байгаа ч гэсэн яг энэ дээр бол шийдвэрлэх үүрэг ерөөсөө төр дээр шүү, тэгээд цагдаа дээр. Тэгэхээр энэ дээр бол ингээд нялганаад, янз бүр гоё ойлгож яриад байх биш, хамгийн 1 дүгээрт таслан зогсоох цагдаагийн үйл ажиллагаа, ур чадвар энэ дээр маш өндөр байх ёстой. Тэгэхээр цагдаа өөрөө энэ дээрээ харин оролцоотой болчих эрсдэл хэр өндөр байгаад байгаа вэ? Энийгээ хянадаг дотоод хяналтын механизмаа сайжруулах тухай санаа чинь энд хэр тусаж өгсөн байгаа вэ?

Тэгээд 3 дахь асуулт нь бол ер нь одоо яг энэ нийт энэ зах зээлийг аваад үзэхэд түрүүн хүмүүс яриад байна л даа, дотоодын нийлүүлэлт, гадаадын бүтээгдэхүүний нийлүүлэлт гээд ингээд яриад байх шиг байгаа юм. Тэгэхээр хэрэв ийм 2 юу байгаа бол гадаадаас орж ирж байгаа мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын нийлүүлэлт нь яг нийт зах зээлээ 100 хувь гээд аваад үзвэл хэдэн хувь нь тэр гаднаас орж ирж байгаа вэ гэдгийг, нийт хэрэглээний зах зээлийг нь аваад үзэх юм бол гаднаас орж ирж байгаа нь хэдэн хувь бэ? Тэндээр ямар нэгэн тооцоо байгаа юу? Ийм 3 асуулт асуух гэсэн юм. 3 дугаар микрофон.

Д.Мөнх-Эрдэнэ: Цогтбаатар даргын асуултад хариулъя. Ер нь хэрэглээний хувьд бол, сүүлийн асуултаас эхэлж хариулахад, хэрэглээний хувьд нийт хэрэглээ, дотоодын манай бид өвсний төрлийн ургамал гэж яриад байгаа каннабис, энэ хэрэглээ бол ер нь 60-70 хувьтай, гаднаас 30 орчим хувьтай гэсэн ийм статистик тоон мэдээллүүд байгаа. Дотоодод түүж хурааж бэлтгэсэн энэ каннабисын төрлийн ургамал бол хэрэглээний дийлэнх нь байна. Тэгэхдээ сүүлийн үед, ялангуяа 2011 оноос хойш бол синтетик химийн төрлийн бодисын гаднаас орж ирэх хэрэглээ бол огцом нэмэгдсэн, жил болгон нэмэгдэж байгаа ийм статистик тоо байгаа. Нарийн мэдээллийг бид танд тоон бичгээр, албан ёсоор ийм, ийм харьцуулж үзүүлье, хүргүүлье.

Хуулийн гол онцлог бол энэ хар тамхитай тэмцэх хууль сахиулах байгууллагыг бэхжүүлэх чиглэлээр онцгой анхаарч үзэж байгаа. Тийм ч учраас ЗГ-аас энэ ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газрыг алба болгон өргөжүүлж, үйл ажиллагааг нь бэхжүүлэх чиглэлээр анхаарч байгаа. Хар тамхитай тэмцэх албаны

хувьд энэ чиглэлээр хийх, хэрэгжүүлэх чиг үүргийг хуулийн төсөл дээр гадаад хамтын ажиллагаа, дотоод чиг үүргийн хувьд хуулийн төслийн 8 дугаар бүлэг дээр тодорхой зохицуулалтуудыг тусгасан. Нөгөө талаасаа энэ албанд зүтгэж байгаа албан хаагчдын онцлогийг харгалзаж, нийгмийн баталгааг нь сайжруулах, энэ тэмцэж байгаа албан хаагчдыг урам зоригтой ажиллуулах чиглэлээр нийгмийн баталгаа дээр нь анхаарч тодорхой зохицуулалтыг тусгасан байгаа.

Ерөнхий хяналт, тийм хардлага, яриа байдаг. Өөрөөр хэлбэл, олон улсын жишээг харахад тийм юм бий. Энэ өөрөө асар их мөнгө эргэлддэг, нийгэмд онц аюултай, зохион байгуулалттай гэмт хэрэг учраас хууль сахиулах байгууллагын албан хаагч нар татагдан орох ийм тохиолдлууд гардаг юм билээ. Тийм учраас энэ албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулж, дотоод хяналт, урьдчилан сэргийлэх чиглэлээр анхаарах ийм шаардлага байгаа гэдгийг бид ойлгож байгаа. Тэгээд энэ Хар тамхитай тэмцэх албыг бэхжүүлэх ажлын хүрээнд бид ЗГ-ын түвшинд энэ асуудалд онцгой харж ажиллана гэдгээ хэлье.

Д.Цогтбаатар: Тэгвэл тэр цагдаагийн хуультайгаа бас уялдуулж тэрийгээ ер нь та нар харсан байна гэж би ойлголоо, тийм ээ, хариултыг, окэй. Ингээд миний асуулт дууслаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгье. Эрдэнэболд гишүүнийг нэмээд оруулаарай, үг хэлнэ гэж байсан. Нарантуяа-Нара, Эрдэнэболд гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Энэ хуулийг хэлэлцэхийг дэмжиж байна. Тэгээд яаралтай ажлын хэсэг гараад бас нэг алгуурлахгүйгээр энэ зуны хугацаанд яагаад намрын чуулгандаа баталъя гэсэн ийм л төлөвлөгөө гаргаж ажиллаасай гэж хүсэж байна. Ер нь зүгээр хар тамхи, мансууруулах бодис хэрэглэдэг энэ хүмүүс хаана хандахаа мэдэхгүй байгаа юм. Дөнгөж хэрэглээд эхлэнгүүт нь ээж аав, эцэг эхчүүд хаана аваачиж хүүхдээ энэ эмчилгээ, сэтгэл зүйн асуудлыг нь засах вэ гэдэг асуудлаа мэдэхгүй байгаад байгаа, байхгүй л дээ.

Тийм учраас энэ чиглэлийн тэмцэх гэдэг юм уу, урьдчилан сэргийлэх бодлого угаасаа байхгүй байгаад байгаа байхгүй юу. Энийг л мэдэрч уг нь Архины тухай хууль гаргаад, тэр үйлдвэрлэгч буюу нийгмийн хариуцлагын хүрээнд өгч байгаа шүү. Тэр улсын мөнгө биш, тэр үйлдвэрлэгч нар бас 50 хувьд нь орж ирж хяналтаа тавьж, яг зөв зүйлд зарцуулж байна уу гэдэг зүйл дээр хяналт тавих гэж орж ирсэн юм. Манай гишүүд бас буруугаар ойлгоод байна лээ. Тэр архи үйлдвэрлэгчид энэ чиглэлээр зөвхөн архины дон биш, дэлгэцийн дон, энэ мансууруулах дон дээр хүртэл эмчилгээ, эмнэлэг барих үйл ажиллагаа, энэ чиглэлийн үйл ажиллагааг нь санхүүжүүлэхийг дэмжээд байгаа байхгүй юу. Гол нь Сангийн яам мөнгийг нь өгөхгүй байна шүү дээ. Анх удаа төр гэдэг юм уу ийм 23 тэрбум төгрөг босгочоод байдаг, зарцуулж болдоггүй, яриад л байдаг, харамсалтай байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ арга барил, юмнуудаа өөрчилмөөр байна. Энийг улсын төсвөөс санхүүжүүлнэ гэвэл угаасаа мөнгө тавигдахгүй. Би сүүлийн 20-иод жилийн туршлагыг нь судалсан учраас л ийм юм хийсэн юм. Тэгээд одоо 23 тэрбум төгрөг босгож өгөөд байдаг, зарцуулж болдоггүй, харамсалтай байгаад байгаа байхгүй юу. Ийм л байна.

Дээрээс нь энэ чиглэлийн урьдчилан сэргийлэх, эмчлэх бодлогыг нь энд чиглэлийн бодлогоо барихаасаа гадна энэ химийн гэдэг юм уу синтетик төрлийн л

мансууруулах бодис хэрэглэх, энэ юунаас нь аль болохоор оруулчихгүйхэн шиг дэлхийн улс орнууд барьж байна. Одоо каннабис гэдэг юм уу байгалийн юмнаас нь бага зэрэг эмчийн жороор олгож, энэ бага багаар тунг нь багасгаад ингээд эмчлэх бодлого руу явж байна. Энийг зүгээр ний нуугүй хэлэхэд, илэн далангүй судалж яриарай. Түүнээс биш энэ эмчилгээ чинь шууд эмнэлэгт аваачаад гардаг эд биш. Дор хаяж 2 жил, бараг синтетик төрлийн бодисын хэрэглээнд орвол эдгэхгүй ингээд дуусаж байгаа гэсэн үг. Ийм л хатуу хувь тавилан хүлээж байдаг. Тэгэхээр энийг анхааръя.

Тэгээд хууль сахиулах байгууллагын ажлын уялдаа, би яах вэ хэлж байгаа юм. Тагнуулын байгууллагатайгаа мэдээлэл солилцох ажиллагаа байгаа л байх. Тэгэхдээ ер нь зүгээр цаашдаа бүтцийн хувьд ч гэсэн энэ хилийн тагнуул энэ тэрийг нь буцаагаад өгөөд, харилцан бие биедээ хяналттай, мэдээлэл солилцдог, шуурхай мэдээллээ авах бололцоотой байдлаар ингэж зохион байгуулахгүй бол энэ ил далд аргаар үйлдэгддэг гэмт хэрэг, "Би хар тамхи тээвэрлэж байна" гэж хэн ч хэлэхгүй байхгүй юу, улам нарийсаад байгаа юм. Энэ дандаа нууц туршуулын аргаар л илэрнэ. Энэ дээр бид бодитой алхам хийж, энэ хууль сахиулах байгууллагын бүтэц, чиг үүргээ ч гэсэн эргэж харахгүй бол бүтэхгүй.

Яг үнэнийг хэлэхэд, хилийн тагнуул ТЕГ-т очихоор тагнуул чинь өөрөө энэ чиглэлийн хууль сахиулах байгууллага биш байхгүй юу даа. Тийм л зүйлүүд байна. Тэгээд энийг илэн далангүй яриад, энэ асуудлаа шийдэхгүй бол ер нь гамшгийн хэмжээнд хүрчихсэн шүү. Энэ баар, савуудаар чинь бараг хэрэглээ энэ тэр явдаг бүр тийм тусдаа ч бас зориулалтын газрууд бий болчихсон юм билээ. Тэгэхээр энийг одоо ингэж анхаарч цаашдаа бодлогын өөрчлөлтийг яаралтай л хиймээр байна гэж хэлье.

Тэгээд мөнгө босгоод өгсөн шүү, мөнгийг нь зарцуулахгүй байна гэдэг л харамсалтай. Хэзээ ч улсаас тэрбум төгрөг байтугай нэг байгалийн хар тамхины ургамал устгахад хүртэл мөнгөө харамладаг байхгүй юу. Гэтэл архи үйлдвэрлэгчдийг лоббидоод, ойлгуулаад, нийгмийн хариуцлагын хүрээнд нь гээд 23 тэрбум төгрөг одоо ингээд бий болчихоод байхад зарцуулах эрхийг нь өгөхгүй байна гэдэг бол туйлын харамсалтай.

Д.Цогтбаатар: Нарантуяа-Нара гишүүн.

М.Нарантуяа-Нара: Ер нь бол төрийн үүрэг бол иргэнээ хамгаалах. Тэгэхээр ер нь бол аз жаргалтай хүн бол ийм юманд донтохгүй шүү дээ. Энэ нийгмийн асуудал, нийгэм, эдийн засгийн маш хүнд хэцүү энэ нөхцөл байдал, өр шир, энэ дарамттай амьдралаас болоод л хүн ер нь ийм хэзээ ч хүний хүсэхгүй зүйлд санамсаргүй байдлаар нэг сонирхож үзээд, тэрнээсээ болоод л цааш цаашдаа өөрсдийгөө тайвшруулах зорилгоор л ингэж явсаар байгаад гүн шигдчихдэг байх гэж би хувьдаа төсөөлж байна. Тэгэхээр хамгийн 1 дүгээрт бол сайн дураараа хүн ингээд энэнээс гармаар байна гээд ирэхэд бол энийг зайлшгүй сайн дураар нь зохих бүхий л арга, механизмыг хэрэглээд, сайн дураараа ирж байгаа хүмүүсийг бол эмчлээд энгийн иргэн болгоод гаргах нь бол төрийн үүрэг байх гэж би хувьдаа бодож байна.

Тэгээд манай Монгол Улсад бол яг эндээс амжилттайгаар гарсан он удаан жилийн түүх байхгүй учраас одоо бид нар эхэлж байгаа дээрээ энийг олон улсад хамгийн их тохиолдлыг амжилттай давж чадсан ийм улс орнуудтай ялангуяа

хамтарч ажиллах хэрэгтэй. Тэгээд дээрээс нь Монгол хүний сэтгэл зүйгээ маш сайн судлаад, тэгээд гадаад улсад байгаад энэ зүйлийг даван туулж чадсан, энгийн амьдралдаа буцаад орж чадсан Монголчуудтайгаа бас туршлага судлах байдлаар уулздаг юм уу, ярилцдаг юм уу ийм зүйлүүдийг авч хэрэгжүүлэх нь зөв байх гэж бодож байна. Ямар ч байсан энэ бол нэгэнт ийм том асуудал болчихсон байгаа, нууц, ер нь бол ийм асуудлыг нууц гээд дарах тусам л нууцаар улам өргөжөөд байна. Дээрээс нь энэ нууц байгаа асуудлыг улам илрүүлэнгүүтээ барьж хорьдог байгаад байх юм бол энэ бол улам л далд байдал нь улам л гүн гүнзгий болоод байна. Тийм учраас энэ хуулийг маш олон түвшинд юу яагаад, ажлын хэсэг энэ тэрийг нь яаралтай гаргаад, энэ хуулийг баталсныхаа дараагаар яг энэ хэрэгжүүлэх ажилдаа, жишээлбэл энэ дөнгөж саяын энэ 23 тэрбум төгрөгийг хүртэл яаж захиран зарцуулах юм гэдгээс авхуулаад маш яаралтай дүрэм журмыг нь гаргаад явах хэрэгтэй байх гэж бодож байна. Хуулийн төслийг бол дэмжинэ.

Д.Цогтбаатар: Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэболд: Хуулийн сайд маш том асуудал оруулж ирж байгаа. Тэгээд энэ бол бас зүгээр нэг яриад өнгөрөх зүйл биш. Тэгэхдээ яг энэ сэдэв бол хар тамхи, мансууруулах бодис гэдэг энэ сэдэв бол хамаагүй бас дуртай болгон нь яриад байж болохгүй. Яриад хор уршгийг нь таниулах гээд хичээхээр шууд утгаараа, шууд бус утгаараа сурталчилгаа болчихдог. Мэдэж амжаагүй байсан зүйлүүдийнхээ хор уршгийг яриад эхлэхээр бас мэдээд авчихдаг. Тийм учраас цаашдаа энэ хэлэлцэх асуудал нь дэмжигдээд, ажлын хэсэг байгуулаад явахад хаалттай маш олон сэдвийг ярих зайлшгүй шаардлагатай байгаа.

Хуулийн сайд бол цар тахалтай тэмцэж байсан хүн, энэ хар тахалтай их сайн тэмцмээр байгаа юм. Ер нь үе үеийн Хуулийн сайд нэг өөрийнхөө сайд хийж байх үеэр овоглох нэг, хоёр ажлыг л маш сайн нухацтай хийх ёстой. Миний харж байгаагаар бол энэ хар тамхитай тэмцэх асуудал, аюул хөнөөлийг бууруулах асуудал бол маш том асуудал. Түүнээс энэ дээр бол ингээд эр зориг гаргаж, манлайлж явах ёстой бөгөөд энэ дээр бол ерөөсөө улс төржиж болохгүй гэдэг нь энэ хуулийн төсөл дээр ч гэсэн бид энэ улс төржихгүй байх, үндэсний аюулгүй байдалтай шууд ба шууд бусаар холбоотой, ирээдүй хүүхэд залуучуудтай шууд утгаараа холбоотой учраас бид нар хичээж ажиллана. Их Хурлын гишүүд бол мэргэжилтнүүд байх албагүй ч гэсэн, нэгэнт хууль батлах гэж байгаа учраас, баталсан хуульдаа хяналт тавих гэж байгаа учраас нэлээн долоо хэмжиж нэг огтлох хэмжээнд маш нарийн хэлэлцүүлгүүдийг явцын дундаа хийх байх гэж бодож байна.

Тэгэхээр аливаа хуулиудад, тэр тусмаа энэ хуульд нэг зайлшгүй шаардлагатай зүйл бол энэ төсөөт аргын загварчлалаар /predictive modeling/ олон төрлийн судалгаа хийх ёстой. Энэ хууль батлагдсанаараа нийгэм, эдийн засгийн ийм эерэг үр дүн гаргана гээд сая оруулж ирж байгаа зүйл дээр харагдаж байна л даа. Гэхдээ яг тодорхой, хэмжигдэж болохуйц үр дүн рүү чиглэсэн ажлууд юу байж болох вэ гэдэг дээр маш нухацтай ажиллаж, энэ дээр олон улсын туршлага, Монголын судалгааны байгууллагууд дээр нэлээн ингээд хамтарч, төвлөрч ажиллах ёстой. Одоо Монголын нэг зүй тогтол бол юу вэ гэхээр, хуулиа баталчихдаг, тэгээд тэр нь ингээд хэрэгжихгүй цаасан дээрээ өтөлчихдөг, бодит амьдрал дээрээ асуудал бэрхшээлүүд их ургаж гараад байдаг, энэ асуудал дээр их анхаарах ёстой байх. Тэгээд Мөнх-Эрдэнэ дэд сайд энэ дээр нэлээн өөрөө хуулийн хүн учраас их амбиц гаргаж ажиллаарай гэж хүсмээр байна.

Жишээлбэл бид утааны асуудлыг ярихад, нэг салбараар жишээлэхэд эрүүл мэндийн салбарт CDC гээд Өвчний хяналт, урьдчилан сэргийлэлтийн чиглэлийн байгууллага байгуулж байгаа юм, сая 1 сард ЗГ-ын шийдвэрээр. Тэгэхээр энэ жилийн эрүүл мэндийн төсөв 168.2 тэрбум гэлээ гэхэд ийм байгууллага байгуулснаар нэмэлт орон тоо тавихгүйгээр ер нь 300-450 тэрбум төгрөгийн үр ашиг буюу алдагдсан боломжийн тэр үр өгөөжийг авчрах, бий болгох тийм үнэ цэнийг бий болгож байгаа юм гэдэг шиг яг энэ хууль гарснаараа яг ямар нийгэмд эерэг нөлөөллийг хэмжигдэх нэгжээр харуулах вэ гэдэг дээр нэлээн сайн харуулмаар байна, илэрхийлмээр байгаа юм.

Ер нь бол хууль хэрэгжүүлэхэд 3 төрлийн асуудал гараад байх шиг байгаа юм. 1 дүгээрт, энэ салбарын уялдааны асуудал. Утаа гэнгүүт олон яам, газруудын хооронд ингээд эзэн биегүй үлдчихдэг гэдэг шиг яг энд бол олон төрлийн байгууллагууд орж байгаа учраас энэ хуулиараа уялдааг нь маш сайн хангаж, нэгдсэн мэдээллийн сан, тоо бүртгэл дээр маш сайн анхаарах зайлшгүй шаардлага байгаа. 2 дугаарт нь, энд тэнд очоод бид чинь ХЗБХ, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны шугамаар байгууллагууд дээр очихоор ерөөсөө очоод л мөнгө санхүү дээр, төсөв дээр гацчихдаг. Тэгэхээр энэ уялдааг их сайн гаргах. 3 дугаарт нь, энэ хариуцлага, ил тод байдлыг явахгүй бол, ярихгүй бол, энэ хуульдаа сайн тусгаж оруулахгүй бол эргээд одоо нөгөө эзэн.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Эрдэнэболд гишүүний микрофоныг гүйцээгээд өгье.

С.Эрдэнэболд: Тэгээд бид нар сая удаа дараа хэлээд энэ Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа төсөв болон энэ төсвийн хүрээ нийцэж байх тухай ингээд хууль байгаа. Гэхдээ аудит энийг хийж чаддаггүй гэдэг шиг одоо яг энэ Үндэсний аюулгүй байдлын шинэ үзэл баримтлал орж ирж байгаа, орж ирэх гэж байгаа юм байна гэж ойлгосон. Энэндээ бас яг энэ хуулиа маш сайн яв цав нийцүүлэх, тэр эрэмбийнхээ дагуу энэ хар тамхитай тэмцэх, энэ хорт аюулыг бууруулахад чиглэсэн төсөв, төсвийн эрэмбийн асуудлыг бас их тодорхой оруулж ирэх зайлшгүй шаардлагууд байгаа.

Тэгээд Байнгын хорооны гишүүнийхээ хувьд энэ ажлын хэсгийг дараа нь дэмжээд, болбол оролцоод, ингээд нээлттэй болон хаалттай горимоор асуудал шийдэхэд нарийн ширийн юмыг яриад явна гэж бодож байна. Тэгээд ажлын хэсгийнхэнд амжилт хүсье. Энэ бол зүгээр нэг алба өнгөрөөж байгаа хуулийн асуудал биш. Энэ бол Үндэсний аюулгүй байдалтай маш том холбоотой ийм асуудал. Тэгээд Хуулийн сайд энэ хуулийг их сайн чанартай болгоход нь их анхаараарай гэж хүсэж байна.

Д.Цогтбаатар: Би нэг хэдхэн зүйл хэлчихье. 1 дүгээрт, энэ хууль дээрээ ажлын хэсгээ байгуулаад ажиллаад явахдаа нэг юмыг та нар бас бодоцгоогоорой. Ер нь яг энэ дээр би өөрөө ЕАБХАБ-ын Терроризмын эсрэг хорооны гишүүн. Тийм учраас энэ талаар олон улсын туршлага, мэдээллийг бол терроризм өөрөө нөгөө хар тамхи, хууль бус мөнгө угаах энэ бүх юмтай аягүй нарийн холбоотой байдаг болохоор Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын хүрээнд мэдээллүүдийг хангалттай авч байдаг. Та бүхэнтэй хэрэгтэй юман дээр чинь яг энэ дээр санаа бодол солилцож, гаднаас топ мэргэжилтнүүдийг /expert/ авчрахад туслах боломжтой.

Энэ дээр хамгийн хатуу баруунд барьж байгаа зарчим бол trace the money буюу мөнгийг нь мөшгөх. Мөнгийг нь мөшгөхөд цаад эзэд нь олдоно, зам мөр нь олдоно гэсэн яг ийм хатуу зарчим барьж байгаа. Яагаад гэвэл зах зээл нь өөрөө маш том болохоор зүгээр хэдэн төгрөг бэлэн мөнгөөр /cash/ хийгээд байх тухай асуудал биш учраас энэ дээр та нар бас сайн анхаарч өгөөрэй. Түрүүн Мөнх-Эрдэнэ сайд хэлж байна лээ, дотоодын жагсаалтаа бид нар гаргана гээд. Тэгэхээр би бол ингэж бодож байгаа, тэр бодисын жагсаалт. Ер нь гаднын, Одонтуяа гишүүн бид нар ноднин билүү, хэдэн жилийн өмнө бас яг энийг нарийвчлаад ярьж байхад хамгийн гол ярьж байсан асуудал гаднын манайд бүртгэгдээгүй байгаа, гэхдээ НҮБ эд нар тэр холбогдох байгууллагын бүртгэлд орчихсон байгааг шууд автоматаар манайд хүлээж аваад, түүнээс бид Монголынхоо MNS стандартуудад нийцүүлж оруулаад ингэвэл цаг хугацаа алдаж байгаа байхгүй юу. Тэгэхээр гаднынхыг шууд автоматаар Монголдоо аваад хэрэглэдэг байх нь илүү өгөөжтэй бөгөөд цаг алдахгүй, үр ашигтай байх болов уу гэж бодож байгаа юм. Тэгэхээр дотоодын үндэсний гаргалгүй л яах вэ, гэхдээ гаднын шинээр гарч байгааг бол шууд автоматаар өөрийнхтэйгөө бүртгээд, дараа нь харин шалгаж явсны дараа хасвал хасдаг юм байгаа биз. Гэхдээ эхлээд автоматаар ордог байх нь бараг зөв болов уу гэж бодож байна.

3 дахь хэлэх гэсэн асуудал, тэр дотоод хяналтынхаа асуудлыг та нар маань сайн тавиарай. Яагаад гэвэл энэ асуудал дээр хэдүүлээ сайн, муу хүн гэж ерөөсөө байхгүй гэдгийг л ойлгох хэрэгтэй. Систем өөрөө сайн ажиллаж байна уу, системд хэнд ч итгээд хэрэггүй. Системдээ ажиллаж байгаа бүх хүнийг энэ дээр эрсдэлтэй шүү гэж тооцож ажиллахгүй бол цаад эргэлдэж байгаа мөнгөний хэмжээ, тэр гэмт бүлэглэлийн ажиллах арга барил, бүх юм чинь бидний сэтгэж байгаагаас хамаагүй том. Ямар ч зарчимгүй, ямар ч ёс суртахуунгүй, тэндээс ямар нэгэн хууль мөрдөх хэм хэмжээ горьдоод хэрэггүй бүлэглэл байж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр бол тэр төрийн тал дээрээ бол яг дотоод хяналтын системээ бол нэн сайжруулж ажиллах ёстой шүү гэж бодож байгаа юм.

Тэгээд энэ дээр тэр юугаа би түрүүн нөгөө гадаад зах зээлийн нөлөө чинь хэр байгаад байна вэ гээд асууж байгаагийн шалтгаан нь юу вэ гэхээр ингээд нууц байгаа тохиолдолд бид нар бүрэн зургийг гүйцэд харж чадахгүй л байгаад байгаа шүү дээ. Жишээлбэл, түрүүн ярьж байна шүү дээ, энэ донтчихсон хүмүүсийнхээ тоог авч, хэдэн хүн байна гээд асуугаад байгаа чинь тэр чинь бүртгэгдсэн байгаа хүмүүс, түүнээс бүртгэгдээгүй нууц байгааг угаасаа бүртгэх боломжгүй. Түрүүн сайд ч хэлж байна шүү дээ. Тэгэхээр бидний төсөөлж байгаагаас бол том байгаа шүү гэдэг тооцоотойгоор, презумпцитэйгээр /presumption/ бид нар хуулиа боловсруулах ёстой, аль болох мууг бодож, муу хүмүүсийг ажиллах боломжгүй болгож тооцож л энэ хуулиа гаргах ёстой л гэж бодож байгаа юм. Миний хувьд бол дэмжиж байгаа. Ингээд гишүүд үг хэлж дууслаа.

Одоо санал хураалтдаа бэлтгэе гишүүд. Бүртгэлийн санал хураалт нэг явуулчихъя. Санал хураалт. Болохоор байна.

1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

2.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Эрүүгийн

хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

4.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

5.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

6.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

7.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

8.Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Намайг дэмжсэн, тэгвэл би горимын санал гаргая. Саяын санал хураалтыг хүчингүйд тооцъё гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 52.6 хувиар санал дэмжигдлээ. Түрүүн уншиж танилцуулсан Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн томьёоллоор уншсан байгаа. Тэгээд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ. Одоо 9 зөв үү?

9.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

10.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

11.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн

хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

12.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

13.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

14.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

15.Байгалийн ургамлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

16.Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

17.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

18.Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

19.Гэр бүлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Баярмаа гишүүн, Баярмаа гишүүний микрофоныг өгье.

Ж.Баярмаа: Горимын санал гаргая, саяын саналыг хүчингүй болгож өгнө үү.

Д.Цогтбаатар: Баярмаа гишүүний гаргасан саяын саналыг хүчингүй болгож өгнө үү гэсэн саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ. Түрүүн уншиж танилцуулсан Гэр бүлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дэмжье гэсэн томьёоллоор санал

хураасан байгаа, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

20.Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

21.Жолоочийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

22.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

23.Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

24.Ирээдүйн өв сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

25.Монгол Улсын Төрийн ордны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

26.Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

27.Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

28.Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

29.Тагнуулын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар

хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

30.Усан замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

31.Харьяатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

32.Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

33.Цэргийн алба хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

34.Шуудангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

35.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

36.Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

37.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

38.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

39.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы

нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

40.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

41.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

42.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд УИХ-ын гишүүн Одонтуяа танилцуулна.

19.42 цаг

Тав. "Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Одоо ганц асуудал байгаа гишүүдээ. Дараагийн асуудалдаа оръё. Ганц асуудал, 5 дахь асуудал, тогтоолын төсөл байгаа.

Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийг гишүүдэд тараасан байгаа. Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байвал нэрсээ өгнө үү? Алга байна.

Би энд нэг горимын санал гаргачихъя. Тогтоолын төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй тул хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргаж байна. Хэн гараад явчав? Би түрүүн горимын санал гаргасан, нөгөө анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат хүртэл шилжүүлэх горимын санал гаргасан, дэмжиж өгнө үү.

Горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Байж байгаарай манайхан, санал хураалтдаа бэлдье. Гишүүдээ, санал хураалтдаа бэлдье. Горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт

явуулъя. Санал хураалт. 52.6 хувиар санал дэмжигдлээ. Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд УИХ-ын гишүүн Эрдэнэболд танилцуулна.

19.16 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүддээ талархал илэрхийлж байна.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА